

ДОРНОД АЙМГИЙН ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Гурав. Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авилгаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

Дөрөв. Санхүү, бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Тав. Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

Зургаа. Дотоод хяналт, шалгалтын талаар

Долоо. Дүгнэлт

Найм. Санал

ДОРНОД АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗАР

**ДОРНОД АЙМГИЙН ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар
сарын 10-ны өдөр.

Хэрлэн сум.

Цагдаагийн газар 2022 онд Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, офицер бүрэлдэхүүний манлайлал, сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах, тасаг албад, алба хаагч бүрийн ажлын бүтээлч чанар, үр дүнг өнгөрсөн оныхоос ахиулах зорилт тавин ажиллалаа.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Цагдаагийн газраас Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн сайд болон аймгийн Иргэдийн хурал, Засаг дарга нараас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын өгсөн үүрэг, шийдвэрийг алба хаагчдад судлуулах, тайлбарлан таниулах, бие бүрэлдэхүүнийг шинэ мэдээ мэдээллээр ханган тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан 63 заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх журам”-ын /код 108/ дагуу 5 бүлэг 98 заалт бүхий цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн “Лхагва” гаригт дотоод журмын дагуу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тушаал шийдвэр, холбогдох эрхийн актууд, байгууллагын бодлого чиглэл, цаг үеийн ажлын талаар тогтмол мэдээлж, албад, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, нэн шаардлагатай зарим бичиг баримтыг хувилж олшруулан тарааж, хэрэгжүүлэх талаар үүрэг чиглэл өгч байна. Тус Цагдаагийн газрын хэмжээнд 12 дугаар сарын 10-ны байдлаар нийт 4085 албан бичиг хүлээн авч газрын удирдлагад танилцуулан хариуцсан алба хаагч нарт нь хуваарилан бүртгэлээр өгч, цагдаагийн газраас нийт 2392 албан бичгийг хүргүүлж, явуулсан бичгийн бүртгэлд хөтөлж ажиллав.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдолтой хууль, зарлиг, тогтоол, тушаал, шийдвэр болон Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, журам, заавар зэргийг системчлэн мэдээллийн сан бүрдүүлж дотоод сүлжээгээр алба хаагчдад шуурхай хүргэх ажлыг холбооны инженерийн ажлын байрны тодорхойлолтод тусган биелэлт үр дүнг нь тооцон ажиллалаа.

Сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, сумын удирдлагын дэмжлэг туслалцааг авах зорилгоор 2022 оны эхэнд аймгийн засаг даргаар батлуулсан сумын засаг дарга, хэсгийн төлөөлөгч цагдаагийн газрын хамтарсан “Гурвалсан гэрээ”-г байгуулан сар бүр дүгнэн ажиллаж байна.

Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын нийгмийн баталгааг сайжруулах, орон нутгийн зүгээс дэмжлэг туслалцаа авах зорилгоор аймгийн агентлагийн удирдлагууд болон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарын нэгдсэн хуралдаан дээр Цагдаагийн газрын дарга, сумдын цагдаагийн алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх, алба хаагчдын

амьдрах нөхцөлийг сайжруулахад орон нутгийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай байгаа талаар өнөөгийн нөхцөл байдлын талаар сонсгол мэдээлэл хийж, ажил үүрэг гүйцэтгэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, санал хүсэлтийг авч хэлэлцэн аймгийн Засаг дарга, орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахаа илэрхийлж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 171,2 сая, сумдын цагдаагийн хэсгийн байрны засварт 20,0 сая, тоног төхөөрөмжийн зардалд 27,0 сая нийт 218,8 мянган төгрөгийг шийдвэрлүүлэв.

Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах төсөв хөрөнгийн талаар аймгийн Цагдаагийн Ерөнхий газар, аймгийн ИТХ, Засаг дарга, Чойбалсан хотын дарга нарт холбогдох санал, төсөв хөрөнгийн тооцоо судалгааг гарган хүргүүлж ажилласнаар улсын болон орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөс тодорхой дэмжлэгийг авч, бүтээлч санаачилга гарган ажилласны үр дүнд 2021 онд 411.3 сая төгрөг, 2022 онд 427.2 сая төгрөгийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 15.9 сая төгрөг буюу 3,7 хувиар өссөн байна.

Алба хаагчдын харилцаа хандлагыг төлөвшүүлэх, соёлыг дээшлүүлэх зорилгоор алба хаагчдын дунд “Тэргүүний соёлч боловсон офицер, цагдаа, эмэгтэй ажилтан” болзолт уралдаан, “Шилдэг мөрдөгч, Шилдэг хэсгийн байцаагч, ахлагч, харуулчин”, “Шилдэг удирдагч”, “Шилдэг хэсгийн төлөөлөгч” зэрэг ажил мэргэжлийн уралдаан, болзолт уралдаануудыг тус тус зарлан явуулж дүгнэлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хэсгийн төлөөлөгч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажил үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, алба хаагчдын ажиллах урам зорилгыг нэмэгдүүлэх зорилгоор “Тэргүүний шилдэг хэсгийн төлөөлөгч”, “Шилдэг хэсгийн байцаагч” болзолт уралдааныг дүгнэж явууллаа.

Цагдаагийн газраас алба хаагчдын сахилга ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийж, гэр бүлийн гишүүдтэй уулзах, санал хүсэлтийг сонсох чиглэлээр “Гэр бүлээ сонсьё” аяныг 2020.04.23-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хэсэгчилсэн байдлаар 8 удаа тасаг албадын алба хаагч нарын гэр бүлийн гишүүдтэй уулзаж, Цагдаагийн газрын авч хэрэгжүүлсэн ажлын тайланг тавьж, санал хүсэлтийг сонсож, гэр бүлийн гишүүдээс гаргасан саналуудыг нэгтгэн Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн цаашид авч хэрэгжүүлэх ажлаа тодорхойлж ажиллалаа. Уулзалтад нийт 153 алба хаагчийн гэр бүл буюу 82.7 хувь нь хамрагдсан ба хүндэтгэн үзэх шалтгаанаар уулзалтад хамрагдаагүй алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэй тасгийн дарга нар уулзаж, санал хүсэлтийг сонсох ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

А. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал: Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгүүлж, долоо хоног бүрийн Мягмар гаригт 21 удаа хуралдаж, 281 асуудал хэлэлцсэнийг дотор нь ангилж үзвэл: ажлын байрны томиллолт болон чөлөөлөх асуудлаар 58, шагнаж урамшуулах 22, албаны шалгалт 15, сахилга хариуцлагын талаар 17, ажлын хэсэг байгуулах талаар 32, тасаг албадын сарын ажил дүгнэх талаар 12, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг авч хэлэлцэх талаар 23, ажлын хэсгийн танилцуулгын талаар 52, сонсгол мэдээлэл 23, бусад 52 асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан ба зөвлөлийн хурлаас 62 алба хаагчид хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлт үр дүнг тооцсон байна.

Цагдаагийн газрын даргын 257 тушаал төлөвлөж гаргаснаас ажилд томилох 22, сахилгын шийтгэл оногдуулах 5, ажлын хэсэг томилох 40, шилжүүлэн томилох 71, сарын ажлын үр дүнгийн тухай 20, зардал гаргах тухай 30, болзолт уралдаан зарлах тухай 2, ажлаас чөлөөлсөн 11, суралцуулах 4, цагдаагийн бага цол олгосон 19, бусад асуудлаар 41 тушаал гаргаж биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэв.

Албадын дарга нарын манлайлал, бүтээлч ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүй, цагдаач шуурхай ажиллагааг хангаагүй, шат дараалсан шаардлага, хяналт сул байгаа байдлыг юуны түрүүнд сайжруулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засаж арилгах, орон нутгийн цагдаагийн тасаг, хэсгийн дарга, хэсгийн

төлөөлөгч, цагдаа нарын ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр газрын даргын 78 үүрэг, ажлын чиглэлийг албан бичгээр хүргүүлж, биелэлт үр дүнг нь тооцож байна. Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр бүрэлдэхүүнд 34 удаа үүрэг тавьж, давхардсан тоогоор 62 алба хаагчтай ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгч, 105 алба хаагчийн гэр бүлийн гишүүдтэй уулзаж ярилцан зөвлөгөө өгч, санал хүсэлтийг нь сонсов.

Б. Хүний нөөцийн талаар: Цагдаагийн газар нь цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, алба хаагчдын эрх зүйн баталгааг хангах, ажлын таатай орчныг бүрдүүлж мэдлэг боловсрол ухамсраа дээшлүүлэх боломжоор хангах, хүн төвтэй цагдаагийн үйлчилгээний тогтолцоог бий болгох, ил тод нээлттэй байж өргөдөл гомдлыг хүлээн авах барагдуулах ажлыг боловсронгуй болгох, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан иргэдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд өдөр тутам анхаарч ажиллаж ирлээ.

Цагдаагийн байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан иргэдийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”, “Хүний нөөцийг судлах, ажилд томилох /код 901/ журам”-ын дагуу сонгон шалгаруулалт зарлаж цагдаагийн байгууллагад ажилд орох хүсэлт гаргасан 56 иргэнийг бүртгэснээс болзол шаардлага хангасан 21 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн сонгон шалгаруулалтад хамруулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн А/293 дугаар тушаалаар батлагдсан байвал зохих 200 алба хаагчаас одоогийн байдлаар бэлэн 190 алба хаагч ажиллаж байгаагийн 180 эрэгтэй, 10 эмэгтэй, 92 буюу 49,7 хувь нь офицер, 88 буюу 47,5 хувь нь ахлагч, 5 буюу 2,7 хувь нь энгийн гэрээт ажилчид байна.

Алба хаагчдыг насны байдлаар нь ангилбал: 21-25 настай 19, 26-30 настай 48, 31-35 настай 50, 36-40 настай 23, 41-45 настай 15, 46-50 настай 2, Боловсролын байдлаар нь ангилбал: дээд боловсролтой 126 /үүнээс магистр 13/, бүрэн дунд боловсролтой 34 /үүнээс тусгай дунд 7/ алба хаагч,

Цагдаагийн байгууллагад ажилласан жилээр нь ангилбал: 1 жил хүртэл 12, 1-5 жил ажилласан 48, 6-7 жил ажилласан 16, 8-10 жил ажилласан 26, 11-15 жил ажилласан 41, 16-20 жил ажилласан 18, 21-25 жил ажилласан 8, 26-аас дээш жил ажилласан 2 алба хаагч байна. Одоогоор 3 /Сэтгэл зүйч-1, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга-1, Эрүүгийн ахлах мөрдөгч-1/ алба хаагчийн орон тоо дутуу байгаа болно.

Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхааран ажиллаж Цагдаагийн газраас Дорнод аймагт “ЗОХИОМЖ” дээд сургуулийн эчнээ эрх зүйн анги 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс хичээллэж, тус сургалтад 5 алба хаагчийг хамруулан суралцах нөхцөл бололцоогоор ханган 3 алба хаагч эрх зүйч мэргэжлээр төгсөн одоо 2 алба хаагч суралцаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны Б/95 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилд “Эрх зүй Цагдаагийн байгууллагын ажилтан” хөтөлбөрийн эчнээ 2.5-5.5 жилийн сургалтад 4 алба хаагч тус тус суралцаж байна.

Цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хамт олны дунд нэр хүндтэй, ажлын дадлага, чадвар, туршлагатай, албаны мэдлэг чадвар сайтай нэр бүхий алба хаагчдын гаргасан санал хүсэлт, боловсрол мэргэжлийн түвшин, дадлага, туршлагыг харгалзан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-909/-д заасан болзол шаардлагыг хангасан алба хаагчдыг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2022 оны жилийн эцсийн байдлаар тасаг, хэсгийн даргаар 3, ахлах албан тушаалд 5 байгаа ба офицерын албан тушаал /ажлын байр/-д томилсон 6, ажлын байр өөрчлөгдсөн 13, шинээр томилогдсон 3, шилжсэн 4 алба хаагч байна.

В. Шагнал урамшил: Иргэдэд чирэгдэл учруулж, эрх ашгийг нь хөндөж хохироосон алба хаагч бүртэй хариуцлага тооцож, алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, төрийн болон байгууллагын шагналаар шагнуулах санал гаргах, шагнах, цагдаагийн цол олгох асуудлыг хэлэлцэхэд тухайн алба хаагч хүний эрх зөрчиж иргэдийг чирэгдүүлж хүнд суртал гаргаж гомдоож байсан эсэхийг шалгуур үзүүлэлт болгож, алба хаагчдын ажлын үр дүнг цаг тухайд нь үнэлж дүгнэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагнал олгох журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-925/ “Шагнаж, урамшуулах тухай” журмын баримтлан шагнаж урамшуулах асуудлыг дэмжиж ажиллалаа.

2022 оны 12 дүгээр сарын байдлаар Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын болон Цагдаагийн байгууллагын 101, Дотоодын цэргийн 100 жилийн ой, Бүгд найрамдах улс тунхагласан өдрийг тус тус тохиолдуулан алба хаагчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажилласан алба хаагчдыг Төрийн дээд шагнал “Цэргийн хүндэт медаль”-аар 3, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Цагдаагийн алдар” хүндэт тэмдгээр 3, “Жуух бичиг”-ээр 2, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 4, “Хүндэт жуух” бичгээр 10, хугацааны “Цагдаагийн хошууч” цолоор 2, хугацааны “Цагдаагийн ахмад” цолоор 6, хугацааны “Цагдаагийн ахлах дэслэгч” цолоор 8, хугацааны “Цагдаагийн дэслэгч” цолоор 7, 4 офицерыг ахлах албан тушаалд, 12 ахлагчийг офицер албан тушаалд дэвшүүлэн томилуулж, 14 иргэнийг ахлагч бүрэлдэхүүнд оруулж “Цагдаагийн дэд ахлагч” цол тус тус олгосон байна. Мөн цагдаагийн газрын даргын тушаалаар хугацааны “Цагдаагийн ахлах ахлагч” цолоор 2, хугацааны “Цагдаагийн ахлагч” цолоор 2, урьд хэрэглэж байсан “Баярын бичиг”-ээр 25 хаагчийг тус тус шагнаж, Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 алба хаагчид олгуулж ажиллалаа.

Г. Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар: Цагдаагийн газрын удирдлага, албан тушаалтанд хандаж иргэд, аж ахуй, нэгж байгууллагаас жилийн эцсийн байдлаар 213 өргөдөл, гомдол, санал ирүүлснийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж хариу өгөв. Ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг ангилбал ажилд орох, суралцахыг хүссэн 14, ажил өөрчлөх шилжихийг хүссэн 45, захиргааны чөлөө хүссэн 149, тэтгэвэр, тэтгэмж орон сууц хүссэн 4 байна.

Цагдаагийн газрын удирдлага алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар гомдол мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэж байгууллагын болон алба хаагчийн нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллав.

Д. Байгууллагын үйл ажиллагаа, түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Цагдаагийн газар нь тасаг албад, алба хаагчдын албаны шуурхай бэлэн байдал, цагдаач ажиллагаа, ажлын хариуцлага, сахилга ёс зүйг дээшлүүлэх, ажлын үр дүн, шат дараалсан хариуцлагыг өндөржүүлж “Захиргааны удирдлагын тасгийн жолооч, алба хаагчдын ажлын хариуцлага сахилга, ёс зүйг сайжруулах сарын аян”, “Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлье” 45 хоногийн аян, “Сахилга ёс зүй, дэг журмыг сайжруулах 60 хоногийн аян”, “Дүрэмч ажиллагааг дээшлүүлэх” зэрэг 4 нэгдсэн арга хэмжээ, “Сахилга ёс зүйн зөвлөгөөн”, “Гэр бүлийн зөвлөгөөн” нэгдсэн арга хэмжээг төлөвлөгөө удирдамжийн дагуу зохион байгуулж явууллаа.

Алба хаагчдын болон тэдний ар гэрийнхний хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, санал хүсэлтийг сонсох, алба хаагчдын ажлын цаг ашиглалтын байдлыг сайжруулж зөрчил гаргагчдад хариуцлага хүлээлгэх, албадын дарга ахлахуудын гүйцэтгэдэг ёс журмын эргүүлийн чанар, үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын албаны шуурхай бэлэн байдал, цэрэгжилт жагсаалч байдал, ажил үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшинг шалгах, ахиулах, ажлын хэсэг, эргүүл, жижүүр, харуул болон эрүүлжүүлэх баривчлах байр, түр саатуулах байрны үйл ажиллагааг шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг

засуулах зэргээр иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээнд шуурхай, хуульч ажиллагааг хэвшүүлж, хүнд суртлыг багасгахад чиглэгдсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Зохион байгуулсан онцлог ажлаас дурдвал:

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөр, Улсын хэмжээнд зохион явагдаж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян”-нийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын ажлын байран дахь эрсдэлийг бууруулах болон үйлдвэрлэлийн осол, хөдөлмөр хамгаалал, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “АЛБА ХААГЧИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙР-2022” өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр “Аюулгүй ажиллаж - Амжилтаараа тэргүүлцгээе” урин дор зохион байгуулагдаж буй өдөрлөгийн арга хэмжээнд ХАБЭА-ийн мэргэжилтэн Д.Ган-Эрдэнэ “ХАБЭА-н тухай хуулийн танилцуулга, байгууллагын дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам, дүрэм, ажилтан болон ажил олгогчийн эрх үүрэг хариуцлага”, Онцгой байдлын газраас “Объектын гал унтраах, гал түймрийн нөхцөл байдал”, Мэргэжлийн хяналтын газраас “Үйлдвэрлэлийн ослын шалтгаан, үр дагавар”, Аймгийн Улаан загалмайн хорооноос “Анхны тусламж үзүүлэх” сэдвүүдээр тус тус танхимын болон дадлага сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Мөн арга хэмжээний төгсгөлд сургалтаар олж авсан мэдлэгийг бататгах зорилгоор “АХА” тэмцээнийг алба хаагчдын дунд зохион явуулж ажиллалаа.

Цагдаагийн газрын алба хаагч нарын илтгэх ур чадварыг сайжруулах, харилцааны соёлыг дээшлүүлэх, улс орны болон гадаад орон, аймаг орны онцлог үйл явдал, дотоодод зохион байгуулагдсан ажил, арга хэмжээ болон цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой цахим орчинд нийтлэгдсэн мэдээ мэдээллийг нэгтгэн анхаарах асуудлын талаар “ДОЛОО ХОНОГИЙН СУРВАЛЖИЛГА” мэдээг цагдаагийн газрын эмэгтэй алба хаагчдаас бэлтгэн 7 хоног бүрийн “Даваа” гарагт, Цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгүүд болох цагдаагийн алба хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах ажлын хэсэг, эрүүл мэнд сэтгэл зүйн багийн ажлын хэсэг, криминологи судалгааны баг, хөдөлмөр аюулгүй байдлыг хангах ажлын хэсэг, санхүү аж ахуй албаны үйл ажиллагаа, эрэн сурвалжлах ажлын талаар алба хаагч нарыг шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, болон байгууллагын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажил, зохион байгуулалтын арга хэмжээ авч байгаа ажлын талаар мэдээллээр ханган долоо хоног бүрийн “Баасан” гарагт нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан нийт 77 удаа 14524 алба хаагчдад танилцуулав.

Цагдаагийн газрын удирдах албан тушаалтнаас алба хаагчдын ажлын хүндрэл бэрхшээл, санал шүүмжлэл, анхаарах асуудлын талаар харилцан ярилцаж, санал бодол, сэтгэгдлийг сонсох, алба хаагчдад өдөр тутмын үйл ажиллагаандаа анхаарах зүйлийн зөвлөмж, зааварчилга өгөх, удирдах ажилтан, алба хаагчдын дунд эерэг таатай уур амьсгалыг бүрдүүлж, тасаг хэсэг, алба хаагчидтай “Алба хаагчаа сонсьё” арга хэмжээг энэ онд 2 удаа зохион байгуулж хуваарийн дагуу давхардсан тоогоор 384 алба хаагчтай уулзаж дэвшүүлсэн санал хүсэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллав. Мөн алба хаагч нарыг насны онцлог, тэдний хүсэл сонирхол, ар гэр ахуй амьдралтай танилцах, шинэ санал санаачилгыг дэмжих чиглэлээр 18-25 нас, 26-31 нас, 32-36 нас, 37-оос дээш нас, цагдаа эмэгтэйчүүд гэсэн 5 ангилалд хуваан тасаг албадын дарга нараар ахлуулсан алба хаагчид уулзаж санал хүсэлтийг сонсон тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар шийдвэрлэж ажиллалаа.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үсч хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд алба хаагчдын чөлөөт цагийг зөв болсон өнгөрүүлэх, сахилга ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Намар эрүүл цагдаа-гэр бүл” өдөрлөгийн үйл ажиллагааг “Энх зуслан” амралтын бааз дээр Цагдаагийн газрын хамт олон, гэр бүлийн дунд зохион байгуулав.

Цагдаагийн ерөнхий газраас улсын хэмжээнд зохион явуулсан "Хандлага дор хүндлэл оршино" нөлөөллийн аяны хүрээнд харилцаа, хандлагаа өөрчлөхөд чиглэсэн "Инээмсэглэлийн өдөр" арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээний хүрээнд өглөө ажилдаа ирж буй алба хаагч нартай ёсолж хүндлэн, эерэг сайхан үгсээр мэндчилэн угтаж, амин дэм, витамин өгч, өөрт хамгийн эерэг мэдрэмж төрүүлдэг, бусдад үргэлж инээмсэглэл бэлэглэдэг алба хаагчдад бэлэглэх арга хэмжээг зохиож, "Хамгийн эелдэг алба хаагч"-ийг шалгаруулж, урамшууллаа.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн судалгаа хяналтын мэдээллийн санд объект, субъектын судалгааг бүрдүүлэх, баяжилт хийх мэдээ, мэдээллийн давхардал зөрчлийг арилгах, гудамж талбай, гэр орон сууцанд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн газрын даргын 2022.04.19-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар "Объект, субъект судалгаа" болзолт уралдааныг цагдаагийн газрын зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагч, хамтарсан багийн гишүүдийн дунд сарын хугацаатай зохион байгуулан үр дүнг тооцож ажиллав. Тус арга хэмжээний хүрээнд аж ахуй нэгжийн судалгаанд 31, объектын судалгаанд 713, субъектийн судалгаанд 1674 нийт 2148 мэдээллийг санд оруулсан байна.

Цагдаагийн газрын алба хаагчдыг иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай, харилцааны өндөр соёлтой үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор газрын үүдний иргэдэд үйлчлэх өрөөнд "Санал хүсэлтийн дэвтэр", "Санал авах хайрцаг" "Байгууллагын ил тод байдлын самбар", "Авилгаас урьдчилан сэргийлэх самбар" зэргийг байрлуулан цагдаагийн алба хаагчийн хүнд суртал, авлигал хээл хахуулийн талаарх мэдээллийг хүлээн авах утасны дугаар бүхий зурагт хуудсыг иргэдийн нүдэнд харагдахуйц газарт байрлууллаа.

Гэмт хэрэг, зөрчил гарсан даруйд цагдаагийн газрын жижүүрийн шуурхай бүрэлдэхүүнийг дуудлагад очсон хугацаа, ажлын үр дүн, гаргасан санал хүсэлтийн талаарх асуулга бүхий "Дуудлага үнэлгээний хуудас"-ыг дуудлага өгсөн иргэнээр бөглүүлж, иргэдийн өгсөн саналыг харгалзан ажлын хэсэгт үнэлгээ өгч ажиллаж байгаа нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүргэх, алба хаагчдын албаны шуурхай бэлэн байдлыг сайжруулахад зохих үр дүнгээ өгч байна.

Цагдаагийн газрын эмэгтэй алба хаагч нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тулгамдаж буй асуудлын талаар санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор "Эмэгтэйчүүдийн зөвлөгөөн"-нийг зохион байгуулж, цагдаа эмэгтэй алба хаагчдыг Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн үйл ажиллагаа болон цагдаа эмэгтэйчүүдийн хийсэн ажилтай танилцах, туршлага судлах ажил арга, хэмжээг зохион байгуулав.

Тус Цагдаагийн газраас Дотоодын цэргийн түүхт 100 жилийн ойг угтсан ажлын хүрээнд 2022 оны төв орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн удирдах ажилтны сургалт зөвлөгөөний үеэр Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соён гэгээрүүлэх ажил" /код 940/-ыг удирдлага болгон алба хаагчдын дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, тамирчин алба хаагчдын алдрыг таниулан сурталчлах, алба хаагчдын спортоор хичээллэх дур сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор "ЁС ЗҮЙГЭЭ МӨРДӨЖ, ДҮРМЭЭ БИЕЛҮҮЛБЕ" аяны хүрээнд "БИДНИЙ БАХАРХАЛТ ТАМИРЧИД" спортын цол зэрэгтэй алба хаагчдыг алдаршуулах өдөрлөгийн арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулан ажиллалаа.

Арга хэмжээнд МҮОНРТелевизийн ахлах редактор Д.Батжаргал урилгаар хөтөлж, спортын цол зэрэгтэй алба хаагчдын амжилтыг танилцуулж, алдаршууллаа. Цагдаагийн газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу алба хаагчдын спортын замналын талаарх сурвалжилга, видео нэвтрүүлгийг бэлтгэн, нийт бие бүрэлдэхүүнд сонирхуулж, Цагдаагийн газрын хамт олон, алба хаагчдын гавьяа шагналаас бүрдсэн "Алдарын булан"-г шинээр байгуулан ажиллалаа.

Е. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай:

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үндсэн үүргээ гүйцэтгэхдээ энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хууль хяналтын байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах, үр дүнг ахиулах

зорилгоор Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын газар, Тагнуулын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Тээвэр зохицуулалтын алба зэрэг газруудтай оны эхэнд хамтарсан зөвлөгөөн хийж, 2022 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга, Чойбалсан хотын захирагч нарт Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд 7 хоногт гарсан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн мэдээлэл, цагдаагийн газраас зохион байгуулсан ажлын танилцуулгыг 48 удаа бичиж хүргүүлэв.

Нийт алба хаагчид хуваарьт байгууллага дээрээ сар бүр өөрсдийн санаачлагчаар улсын хэмжээнд болон орон нутагт зохион байгуулагдаж байгаа арга хэмжээг танилцуулж оролцоог нэмэгдүүлэн ажиллав.

Тус Цагдаагийн газраас аймгийн Прокурорын газартай хамтран мөрдөн шалгах ажиллагаа, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааны талаар хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг улирал бүр нийт 4 удаа зохион байгууллаа. Зөвлөгөөнд Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, аймгийн ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Доржсүрэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч болон хяналтын прокурор нар оролцон, шалгагдаж буй хэргийн талаар тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэж ажиллалаа.

Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Цагдаагийн газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, ХХААГазар, бүх сумдын Засаг дарга, ИТХурлын дарга, багийн Засаг дарга, малын эмч, Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа зэрэг нийт 160 гаруй төрийн алба хаагч нарыг оролцуулан цахимаар “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагуудын оролцоо” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулав.

Аймаг, сум дамжин малын хулгай болон бусад төрлийн гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн талаар мэдээ, мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг эрчимжүүлэх Цагдаагийн Ерөнхий газрын тэргүүн дэд даргад 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 37/2074 албан бичгээр бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулах санал хүргүүлэн зөвшөөрөл авч 2022 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр Эрүүгийн цагдаагийн албаны VII дугаар хэлтэс, Хэнтий аймгийн Цагдаагийн газар, хил залгаа сумдын хэсгийн төлөөлөгч нарын оролцсон бүсчилсэн зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Зөвлөгөөний хүрээнд цаашид хэрхэн хамтарч ажиллах мэдээ, мэдээлэл хэрхэн солилцох, хүндэрч буй бэрхшээл ололт амжилтын талаар санал солилцон зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг зүүн 3 аймгийн Цагдаагийн газрын дарга нарт хүргүүлэн хамтран ажиллалаа.

Цагдаагийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Хөлөнбуйр, Баяндун, Матад, Чойбалсан сумдад “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэн бүрийн оролцоо чухал” сэдэвт бүсчилсэн зөвлөгөөнийг зохион явуул ажиллав.

Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээний мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор алба хаагчид хариуцсан байгууллага, аж ахуй нэгж болон 13 сумын иргэдэд 21 удаагийн сургалт, 42 удаагийн зөвлөгөөн, хэлэлцүүлэг, тэмцээн уралдааныг зохион байгуулж, нийт 74 удаагийн арга хэмжээнд 6060 иргэнийг хамруулан хууль сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

А. Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал: Цагдаагийн байгууллагад иргэд, хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 4547 гомдол мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 354 буюу 8.4 хувиар өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллийн 1518 буюу 33.3 хувийг гэмт хэргийн шинжтэй, 3029 буюу 66.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сард 467 холбогдогчтой, 2.548.2 төгрөгийн хохиролтой, 600 гэмт хэрэг бүртгэгдэж, 94 хэргээр буюу 18.5 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 53.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 245 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 2 буюу 10 хувиар буурч,

гэмтсэн хүний тоо 26 буюу 11.8 хувиар буурсан байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 530.7 төгрөг буюу 28.7 хувийг нөхөн төлүүлжээ.

Аймгийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сард 18083 зөрчил илрүүлсэн нь 2365 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 15 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 16464 иргэнийг 1,027,016.500 төгрөгөөр торгож, 1148 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 306 иргэнийг шүүгчийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлах шийтгэл оногдуулсан байна. Согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 2434 иргэнийг эрүүлжүүлсэн нь 507 буюу 26.3 хувиар өссөн байна.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 134 бүртгэгдэж 40 буюу 34 хувь, Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 38 бүртгэгдэж 11 буюу 40.7 хувь, Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100%, хүүхэд оролцсон гэмт хэрэг 22 бүртгэгдэж 17 буюу 3.5 дахин тус тус өссөн.

- Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 37 бүртгэгдэж 5 буюу 11.9 хувь, Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 36 хүн холбогдсон нь 7 буюу 35 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 44 бүртгэгдэж 5 буюу 10.2 хувиар тус тус буурсан.

- Мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, Гадаадын иргэн оролцсон гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Үйлдэгдсэн газраар: - Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 197 бүртгэгдэж 7 буюу 3.6 хувь, Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 68 бүртгэгдэж 5 буюу 7.9 хувь, Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 41 бүртгэгдэж 20 буюу 95.2 хувь, Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 32 бүртгэгдэж 5 буюу 18.5 хувь, Хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 50 бүртгэгдэж 14 буюу 38.8 хувь, Балчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 47 бүртгэгдэж 2 буюу 4.4 хувь, Бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 150 бүртгэгдэж 61 буюу 68.5 хувиар тус тус өссөн. Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдэж 8 буюу 34.7 хувиар буурсан байна.

Хэргийн төрлөөр: - Хүнийг алах 8 бүртгэгдэж 2 буюу 33.3 хувь, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж буюу 100 хувь, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 225 бүртгэгдэж 27 буюу 13.6 хувь, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 2 нэгжээр буюу 2 дахин, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 1 дахин, Хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдэж 43 буюу 61.4 хувь, Залилах гэмт хэрэг 68 бүртгэгдэж 18 буюу 36 хувь, Хөрөнгө завших гэмт хэрэг 20 бүртгэгдэж 6 буюу 42.8 хувь, , нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 буюу 25 хувь, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 3 буюу 3 дахин, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин, Бусад төрлийн гэмт хэрэг 24 бүртгэгдэж 12 буюу 100 хувиар тус тус өсөж;

Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 15 бүртгэгдэж 2 буюу 11.7 хувь, Хүчиндэх гэмт хэрэг 12 бүртгэгдэж 2 буюу 14.2 хувь, Гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3 буюу 33.3 хувь, Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах 1 бүртгэгдэж 100 хувь, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувь, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 буюу 50 хувь, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин, Хууль бусаар ан агнах гэмт хэрэг 1 дахин, Хууль бусаар мод бэлтгэх 7 бүртгэгдэж 6 буюу 53.8, Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 21 бүртгэгдэж 4 буюу 16 хувиар тус тус буурч, Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг 2, Халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 6, Дээрэмдэх гэмт хэрэг 4 ижил түвшинд байна. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг, Эрүүл мэндийн эсрэг, , Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, Үндэсний аюулгүй байдлын эсрэг, Авлигын эсрэг, Соёлын өвийн эсрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна. Хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 буюу 61.4 хувь өсөж үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 97 бүртгэгдэж 37 буюу 61.6 хувь өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 49 бүртгэгдэж 1 буюу 2 хувиар буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 53.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурсан байна.

Б. Цагдаагийн газрын тасаг, албадаас хийж гүйцэтгэсэн ажлын талаар

Эрүүгийн цагдаагийн тасаг: Цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгаас 2022 оны гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан байна.

Тасгийн хэмжээнд иргэд байгууллага, аж ахуй нэгжээс нийт 721 гомдол мэдээллийг эрүүгийн тасгийн алба хаагч нар хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн байна. Үүнээс: гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 307, зөрчлийн шинжтэй 414 гомдол мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд шалгаж ажиллалаа.

Хэрэг бүртгэлтийн нийт 534 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийж, 42 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар аймгийн прокурорын газарт хүргүүлэн, 86 хэргийг ажиллагааны явцад илрүүлэн мөрдөн байцаах тасагт шилжүүлэн ажиллажээ.

Нийслэлийн дүүргүүд болон бусад орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүд, болон аймгийн Прокурорын газраас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр 21 даалгавар ирүүлснээс, 19 даалгаврын биелэлтийг ханган, хугацаанд нь ажиллагааг явуулж ажиллав.

Аймаг орон нутгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж, тодорхой төрлийн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, албадын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах албадаас улсын хэмжээнд зохион байгуулсан “Сар шинэ”, “Тулгалт”, “Илрүүлэлт-оргодол”, “Мал мах-хяналт” нэгдсэн арга хэмжээнүүд, цагдаагийн газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу тасгийн алба хаагчдын хүчээр “Малын хулгайн хэргийг илрүүлэх чиглэлээр Хяналт-шалгалт-3”, “Зочид буудал” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг цагдаагийн газрын хэмжээнд төлөвлөгөө удирдамжийн дагуу 7-30 хоногийн хугацаагаар зохион явуулж үр дүнг тооцлоо.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн байгууллагууд болон хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Тагнуулын ерөнхий газрын Дорнод аймаг дахь газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Гаалийн газар, Худалдан авах ажиллагааны алба, ГИХГ-ын зүүн бүс дэх газар, Газрын харилцаа хот байгуулалтын газар, Санхүүгийн аудитын алба, Хилийн 0275, 0132, 0306 дугаар анги зэрэг газруудтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөө гарган батлуулж ажиллав.

Мөн цагдаагийн газрын даргын тушаалаар аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд судалгаа дүгнэлт хийх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бодитой төлөвлөн ажиллах зорилгоор криминологи судалгааны багийг мөрдөн байцаах тасгийн даргаар ахлуулан тасаг албадын ахлахуудыг томилон хуваарийн дагуу гарган ажиллуулж байна. Мөн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэрэг бүртгэлтийн хэргүүдийг илрүүлэх зорилгоор Цагдаагийн газрын төрөл албадын алба хаагч нарыг аймгийн төвийн багууд, сумдыг хариуцуулан биелэлт үр дүнг тооцон ажиллалаа.

Эрэн сурвалжлах ажлын талаар: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Эрэн сурвалжлах” /код 229/-ыг хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах “Орон тооны бүс зөвлөл”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Ганзоригийг эрэн сурвалжлах ажил хариуцсан алба хаагчаар тус тус томилж, албан тушаалын тодорхойлолтод ажил үүргийг тусган оруулав.

Цагдаагийн газар нь 2022 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах ажлыг тасралтгүй үр дүнтэй зохион байгуулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Цагдаагийн газрын удирдлага аймаг орон нутгийн хэмжээнд эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Эрүүгийн хэргийн оргодлын тоо бүртгэл хөтлөх, эрэн сурвалжлах, зардал төлүүлэх журам” -ийг боловсруулан газрын даргын тушаалаар батлуулан мөрдөж байна. Журмын дагуу гэмт этгээд оргосон тохиолдолд хэргийг шалгаж байгаа буюу хамгаалалт хийж буй алба хаагч газрын даргад нэн даруй танилцуулж олж баривчлах ажлыг нэн даруй бие даан шуурхай эхлүүлэх, хойшлуулшгүй ажиллагааг 72 цагийн дотор хийж, үр дүн өгөөгүй тохиолдолд оргодолд тооцох тогтоол бичиж газрын даргаар батлуулан эрүүгийн цагдаагийн албанд албан тоотоор шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг журамлан хэрэгжүүлэв.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд удирдлагаас тавих хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг засуулах зорилгоор газрын даргын зөвлөлийн хуралдаанаар Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргын “Эрэн сурвалжлах ажлын

чанар үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сонсгол мэдээллийг хэлэлцэж үүрэг, ажлын чиглэл өгч ажиллалаа.

Эрэн сурвалжлах ажлын “Орон тооны бус зөвлөл”-ийг 2022 онд 16 удаа хуралдуулж, эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалтыг сайжруулах, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тухай бүр нь тооцон ажиллаж байна. Эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалтыг сайжруулах, алба хаагчид мэдлэг мэдээлэл олгох чиглэлээр цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд 4 удаа сургалт, мэдээллийг зохион байгууллаа.

Цагдаагийн газрын алба хаагчдаас “Эрэн сурвалжлах ASAP” санд оруулсан эд зүйлс, мал, амьтан, тээврийн хэрэгсэл, оргодол хүний талаарх мэдээллүүд шаардлага хангасан эсэхэд “Эрэн сурвалжлах журам”-ын 229.7.2-т заасны дагуу хяналт тавьж, шаардлага хангаагүй мэдээллийг буцаах, тухай бүр нь засуулах арга хэмжээг авч, хянан ТТБ-д бүртгэн ажиллалаа.

Цагдаагийн газрын удирдлагаас алба хаагчдад Эрэн сурвалжлах ASAP сангийн бүрдүүлэлт, ашиглалтыг сайжруулах, эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр цагдаагийн газрын даргын 2 үүрэг, дэд даргын 2 ажлын чиглэл, 8 зааварчилгыг тухай бүр хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажиллалаа.

Эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” сангийн ашиглалт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар бүртгэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийхэд алба хаагчдаас эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд 340 зарлан мэдээлэл хийснээс тухайн оны болон урьд оны нийт 610 мэдээллийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож, тухай оны 109, урьд оны 31, нийт үлдэгдэл 140 зарлан мэдээлэлтэй байна.

Эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалт бүрдүүлэлтийг сайжруулах, алба хаагчдыг сурган дадлагажуулах, санд ажиллахдаа гаргаж буй алдаа дутагдлыг арилгуулах, оруулсан мэдээллийн шийдвэрлэлтийг тухай бүр нь оруулах чиглэлээр Эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP сан тулгалт-2022” хэсэгчилсэн арга хэмжээг дотооддоо 14 хоногийн хугацаатай зохион байгуулан сангийн зөрчлийг засуулж, үр дүнг тооцлоо.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Оргодол-Илрүүлэлт-Шийдвэрлэлт-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр “ASAP” санд эрэн сурвалжлагдаж буй Шүүхээс даалгасан иргэний хариуцагч болон оргодол этгээдүүдийг олж тогтоох чиглэлээр 2 алба хаагчийг Улаанбаатар хотод 7-30 хоногийн хугацаатай томилолтоор ажиллуулж тус аймгаас зарлан мэдээлсэн гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 18, бусад орон нутаг дүүрэг хэлтсээс эрэн сурвалжилсан 6 этгээдийг олж тогтоон удааширсан хэрэг, материалыг шийдвэрлэсэн нь үр дүнтэй ажил боллоо.

Эрүүгийн цагдаагийн газар болон бусад газар хэлтсээс эрэн сурвалжлуулахаар ирүүлсэн албан бичгийг алба хаагч нарт тухай бүр нь зарлан мэдээлж, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан бөгөөд алба хаагчид нь эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд давхардсан тоогоор 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 52826 зарлан мэдээлэлтэй танилцаж ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 2.6 дахин өссөн байна.

Эрэн сурвалжлах ажлыг шуурхай хүртээмжтэй байлгах зорилгоор орон нутаг, сумдад ажиллаж буй цагдаагийн алба хаагчдад эрэн сурвалжлагдаж буй мэдээллийг харилцаа холбооны хэрэгслээр шуурхай мэдээлэн ажиллаж байна. Эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлж алба хаагч нарт шуурхай мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор “Дорнод цагдаа- дотоод ажил” нэртэй фэйсбүүк хаалттай групп хуудсыг нээн ажиллуулснаар алба хаагч бүр хоногт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчилд эрэн сурвалжлагдаж буй хүн, мал амьтан, эд зүйлийн талаарх мэдээллийг шуурхай хүргэн танилцаж, хойшлуулшгүй арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй “Мижиг, Дорнод, Шинэ суваг, ТВ6, D1” телевизүүдэд 12 удаа яриа таниулга хийж, богино хэмжээний сургалтын кино шторкуудыг 7 хоногт өдөрт 2 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж ажиллав.

Оршин суугаа газраасаа сураггүй алга болсон үндэслэлээр эрэн сурвалжлагдсан насанд хүрээгүй хүүхдийг олж тогтоон сэтгэл санааг тогтворжуулах, гэрээсээ дайжин явах шалтгаан нөхцөлийг олж тогтоох зорилгоор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч нартай хамтран зөвлөгөө өгч сургуулийн нийгмийн ажилтан, ар гэрийнхэнтэй уулзалт ярилцлага зохион байгуулж ажиллалаа. Эрэн сурвалжлах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 92.4 хувьтай дүгнэн тайланг ЭЦА-нд хүргүүлэн ажилласан байна.

Мөрдөн байцаах тасаг: Тайлангийн хугацаанд хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн урьд оны үлдэгдэл 26, энэ оны онд 608, нийт 695 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 374 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 105 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 184 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж шийдвэрлэн, 12 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 20 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 35 хэргээс 13 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 17 хэргийг хааж, 5 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэж, урьд оны мөрдөн байцаалтын 6 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж тус тус **100** хувьтай шийдвэрлэв. Энэ онд шинээр нээсэн болон харьяаллын дагуу шилжиж ирсэн 242 хэргийг хүлээн авч, нийт 277 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 99 хэргийг хааж, 107 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 13 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн 23 хэргийн үлдэгдэлтэй ажилласан байгаа нь **91.6** хувийг шийдвэрлэж ажиллав.

Мөрдөн байцаалтын 446 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 383 хэргийг шүүхэд шилжүүлэх, 19 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж, 29 хэргийг нэгтгэн, 9 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 6 хэргийн үлдэгдэлтэй ажилласан нь **98.6** хувийг шийдвэрлэж ажиллалаа.

Гэмт хэргийн улмаас учирсан 1,037,099,227 төгрөгийн хохирлоос 959,929,997 төгрөгийн хохирлыг буюу **92.5** хувийг нөхөн төлүүлж, 130 хэрэг бүртгэлтийн хэргээс 107 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь хэрэг бүртгэлтийн хэргийн илрүүлэлт 89.5 хувьтай байна

Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн 383 хэрэгт **100** хувь гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мөрдөгчийн мэдэгдэл бичиж, мэдэгдлийн хариуг 100 хувь авч мэдэгдлийн мөрөөр газар дээр нь шалгах ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Цагдаагийн Ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/03 дугаартай тушаалаар батлагдсан “Сар шинэ-2022” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 06-ний өдрийг дуустал 16 хоногийн хугацаанд зохион явуулахтай холбоотой тус тасгаас салбар төлөвлөгөө боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулан ажиллалаа. Нэгдсэн арга хэмжээний хүрээд тус тасагт шалгагдаж байгаа яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 10 хэргийг нөхөн илрүүлж, 3 сэрдэгдсэн этгээд, 1 оргодлыг олж тогтоон үр дүнтэй ажиллажээ.

Улсын ерөнхий прокурорын орлогч, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга нарын хамтран баталсан “Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл 60 хоногийн хугацаанд зохион байгуулж байгаатай холбогдуулан Мөрдөн байцаах тасгаас шийдвэрлэх хэргийн графикт орсон хэрэг бүртгэлтийн 44, эрүүгийн 20 хэргүүдийг бүрэн шийдвэрлэж ажиллав.

Цагдаагийн газрын дарга, аймгийн Ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар гэмт хэргийн түргэн шуурхай шийдвэрлэх, хэргийн оролцогч нарын эрхийг хангах зорилгоор “Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг эрчимжүүлэх-2022” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бүтэн жилийн хугацаатай зохион байгуулан ажиллаж нийт 202 хэргийг шийдвэрлэн ажиллалаа.

Зөрчлийн хэрэг бүртгэх тасаг: Тайлангийн хугацаанд 2022 онд 2988 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авснаас 482 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 816 гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 1669 хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 13 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж хуулийн хугацаанд шийдвэрлэн, 8 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Хялбаршуулсан журмаар 2125 хүнд 555,049,000₮ төгрөгийн торгууль оногдуулж, 1173 жолоочийн эрх хасаж шийдвэрлэсэн. Нийт шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн 336 буюу 11.24 хувийг зөрчлийн ахлах байцаагч, байцаагч, 1029 буюу 34.43 хувийг бусад зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчид, 1623 буюу 54.31 хувийг замын цагдаагийн тасгийн зохицуулагч нар шалгаж, шийдвэрлэн ажиллалаа.

Зөрчлийн улмаас иргэд, байгууллага, аж ахуй нэгжид 57,377,006 төгрөгийн хохирол учирснаас 49,227,006 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлөлтийн хувь 85.7 хувь байна.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан, тасаг, хэсгийн дарга нараас дээрх прокурорын шаардлага, арга хэмжээ тооцуулах албан бичигт дурьдагдсан зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гаргуулахгүй байх чиглэлээр эд мөрийн баримтыг хураан авах, хадгалах, шилжүүлэхтэй холбоотой зөвлөмж, зааварчилга, үүрэг, ажлын чиглэлийг 2021, 2022 онд, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж, шийдвэрлэн прокурорын бүртгэлд бүргүүлэх чиглэлээр 2021 он, 2022 онд зөвлөмж, албан мэдэгдэл, хүргүүлсэн, “Зөрчлийн хэргийн шийдвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг 2021 онд нийт 3 удаа зохион байгуулсан, мөн 2022 онд Цагдаагийн газрын даргаас “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны чанар, үр дүнг ахиулах, зөрчлийн хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх тухай” 04 тоот албан даалгавар гаргаж хүргүүлэв.

Энэ онд архи согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлийн хугацаа дууссан 15 аж ахуй нэгжийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 11 дүгээр хэсэгт зааснаар 3.900.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч гар дээрээс хууль бусаар архи худалдан борлуулсан 10 иргэнийг 100.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж 1073 ширхэг архи согтууруулах ундааг хураан авч Дорнод аймгийн Хэрлэн сумын засаг даргын тамгийн газрын орон тооны бус комиссд улсын орлого болгуулахаар хүлээлгэн өгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд сурталчилж “Дорнод аймгийн Цагдаагийн газар цахим хуудсанд согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл хяналт” арга хэмжээний талаархи мэдээллийг оруулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын Зөрчлийн хэрэг бүртгэх газраас зохион байгуулж байгаа “Зөрчлийн хэрэг шийдвэрлэлт-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Аймгийн Прокурорын газартай хамтран эзэн холбогдогч нь тогтоогдоогүй зөрчлийн хэргийг илрүүлэх, хугацаа сунгасан, удаашралтай шалгагдаж байгаа хэргийг шуурхай шийдвэрлэх, зөрчил шалган, шийдвэрлэх ажиллагааны үед гарч байгаа зөрчил дутагдлыг арилгах, эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хамтарсан зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Тус Цагдаагийн газраас 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 479 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж шалгаснаас 25 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай шилжүүлсэн бөгөөд үүнээс 2 хэргийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт /хөөн хэлэлцэх хугацаа дууссан/ заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Одоо 58 хоногоос дээс хугацаа сунган шалгаж байгаа хэрэг байхгүй байна.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд судалгаанд авагдсан 42 зөрчлийн хэрэг, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн гомдол, мэдээллийг 100 хувь шийдвэрлэж, санд мэдээллийг оруулна ажиллалаа.

Замын цагдаагийн тасаг: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлд тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн нас барах, гэмтэж бэртэх явдлыг бууруулах чиглэлээр “Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2021-2023” хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн 2022 онд зохион байгуулсан ажлын танилцуулга, гарсан гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгаан нөхцөл, хүрсэн үр дүнгийн талаарх криминологи судалгааг танилцуулгын хамт гарган Аймгийн Гэмт Хэргээс Урьдчилан Сэргийлэх Ажлыг Зохицуулах Салбар Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн үр дүнг тооцон ажиллалаа. Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2022 онд хийж хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг 3 бүлэг, 31 заалттай гаргаж батлуулан заалт тус бүрийг хэрэгжилтийг ханган ажиллав.

Аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүс, түүний орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэл, замын хөдөлгөөний зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ногоон бүсийг хамгаалах үүрэг бүхий “Эцэг эх зохицуулагч” арга хэмжээг жил бүрийн хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд хуваарь гарган эцэг, эхчүүдтэй хамтран зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн “Эцэг, эх-Зохицуулагч” арга хэмжээг эрчимжүүлэх тухай А/80 тоот захирамж гаргуулан хэрэгжүүлэн ажилласан.

“Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2021-2023” хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 онд шаардлагатай төсвийн зардлын тооцоо аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хүргүүлэн 10

сая төгрөгийг шийдвэрлүүлэн “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээг сурталчлах ажилд зориулан орон нутгийн зам дагуу 7х3, 2х1 мөн бүх сумдад 2х1 хэмжээтэй самбар байрлуулах зардалд зарцуулан ажиллалаа.

Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, техник замын зохион байгуулалтын чиглэлээр явуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүд болох аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Таван эрдэнэ”, “Шөнийн эргүүл”, “Согтуу жолоочтой хамтдаа тэмцье 2022”, “Сар шинэ 2022”, “Сар шинэ-Тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээвэр”, “Хурд”, “Бяцхан зорчигч”, “Улсын дугаар” “Танд баярлалаа”, Тээврийн цагдаагийн албанаас улсын хэмжээнд зохион байгуулж буй “Хурд”, “Ачааны авто машины бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт, “Мотоцикл”, “Дүрэмч цагдаа”, “Бяцхан зорчигч”, “Авто машин-2022”, “Арлын дугаар тулгалт” “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл” зэрэг арга хэмжээний хүрээн холбогдох удирдамж төлөвлөгөөг гарган аймгийн төв болон 12 сумдыг хамруулан зохион байгуулав.

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр такси үйлчилгээ эрхэлж буй 45 иргэн, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Политехник коллеж, Халх сум дахь нэр бүхий 12 байгууллагад нийт 3 төрлийн 15 мэдэгдэл, баяр амралтын өдрүүдэд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 19 байгууллагад, шинэчлэгдсэн Замын хөдөлгөөний дүрмийн заалтыг хэрэгжүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Айсвен, Адуун чулуу ХХК-д 2 удаа, Дорнод Их сургууль, Айсвен, “ТОУУ ХК, Петрочайна дачин тамсаг” ХХК, Улаанбаатар хот хөдөө орон нутгаас амралт зугаалгаар зорчих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбогдуулан Дорнод аймгийн амралтын газрууд, Баян-Уул сумын 6-р багийн засаг даргад тус тус мэдэгдэл хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцон ажиллалаа.

Гудамж замын хяналт шалгалтаар 1721 зөрчил илрүүлэн ажилласнаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1364, эрхийн үнэмлэхгүй болон эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 148, нийт түр саатуулах үндэслэлээр 1648 тээврийн хэрэгслийг түр саатуулж, замын хөдөлгөөний хууль, дүрмийг бусад байдлаар зөрчсөн 1574 жолоочид 47.010.000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулан 1177 жолоочийн эрхийг хасаж 214 жолоочийг шүүгчийн шийтгэврээр баривчлуулах арга хэмжээ оногдуулж ажиллажээ.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар зам тээврийн гэмт хэрэг ослын шинжтэй 123 дуудлага мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан, гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 65 хүн гэмтсэн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал: Бүртгэгдсэн гэмт хэрэг, осол 11 нэгжээр буюу 9,8 хувиар, гэмтсэн хүн 20 нэгжээр буюу 44,4 хувиар тус тус өссөн бол, харин зам тээврийн гэмт хэрэг ослын улмаас нас барсан хүн 7 нэгжээр буюу 36,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийтийн хэв журам хамгаалах тасаг: Нэгдсэн эргүүл шалгалт 14 удаа, хүч нэмэгдүүлэн эргүүлийг 23 удаа, “Эргүүл шалгалт” нэгдсэн арга хэмжээ 8, хэсэгчилсэн арга хэмжээг 18, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс нийтийн эргүүлийг 54 удаа тус тус зохион байгуулан үр дүнг тооцон эргүүлд давхардсан тоогоор 8114 алба хаагч, 55524 цагийн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд эргүүлийн хуваарь томилгоог 7 хоног бүр гаргаж, цагдаагийн газрын даргаар батлуулан хуваарийн дагуу алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангуулан гаргаж, үйл ажиллагааг 298 удаа шалгаж, үүрэг, зааварчилгаар өгч ажилласан байна.

Шинэ жил, Цагаан сар, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу нэгдсэн болон хүч нэмэгдүүлсэн эргүүлийг 24 удаа зохион байгуулж, шинэ жил, сар шинийн баярын өдрүүдийн хамгаалалтын төлөвлөгөө гарган зохион байгууллаа.

Алба хаагчдаас 2022 онд 54 гэмт хэргийг илрүүлж, 101 гэмт хэргийг таслан зогсоож, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 41 мэдэгдэл бичиж, ЦБҮАЖурам код 307 заасны дагуу гэмт хэргийн талаар 124 илтгэх хуудас бичиж танилцуулан, эрэн сурвалжлах ASAP сангийн мэдээлэлтэй 55 алба хаагч 592 удаа орж, давхардсан тоогоор 14600 мэдээлэлтэй танилцсан байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан байдлаар “Шинэ жил”, “Сар шинэ-2022”, “Зах-Хяналт”, “Орон гэргүй тэнэмэл иргэдийн судалгаа-Хяналт”, “Мэдэгдэл-Аж ахуйн нэгж, байгууллага”, “Камержуулалт”, “Нэгдсэн эргүүл, шалгалт”, “Харуул, манаа”, “Олон нийтийн эргүүл”,

“Нэгдсэн эргүүл”, “Албадан эмчилгээ”, “Ноолуур”, “Мөрийтэй тоглоом хяналт”, “Голын эрэг”, “Сургууль-төгсөлт”, “Сумдын наадам хяналт”, “Эргүүл, Шалгалт” арга хэмжээг 24 удаа, “Камержуулалт”, “Мал мах хяналт”, “Архи хяналт” арга хэмжээг 12 удаа, “Гэрээт харуул, хамгаалалтын байгууллага, хяналт шалгалт” арга хэмжээг 5 удаа, “Хичээлийн шинэ жил”, “Харанхуй эмзэг цэг хяналт”, “Объект, субъектийн судалгаа эрчимжүүлэлт”, “Таван эрдэнэ”, “Галт Зэвсэг 2022” зэрэг давхардсан нэршлээр 45 ерөнхий арга хэмжээ, 78 тусгай арга хэмжээ, 70 нэг бүрчилсэн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж биелэлт үр дүнг тооцон, иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулж хамтран ажиллалаа.

Хэсгийн байцаагч нараас 2022 онд иргэд байгууллага, аж ахуйн нэгжээс зөрчлийн шинжтэй 1329 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас зөрчлийн хэрэг нээсэн 187, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 57, татгалзсан 966, зөрчил гаргасан 80 иргэнийг шүүхээр баривчлуулах арга хэмжээ авч 194 иргэнд 18,685,000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.

Хэсгийн байцаагч нараас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 681 аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл, санамж өгч, 330 байгууллага, аж ахуйн нэгжээр гадаад дотоод орчимд нь камерын хяналт, гэрэлтүүлэг шалгаж, 149 байгууллагыг нийтийн эргүүлд татан оролцуулж, давхардсан тоогоор 1820 айл өрхөөр орж санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, нийт 6400 орчим иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийж, ХӨТЯШийтгэлтэй 6 хүнд хяналт тавьж ажилласан. Гэмт хэрэгтэй тэмцэх илрүүлэх чиглэлээр нийт ЦБҮАЖурам /код-307/ - оор 86 илтгэх хуудас, мэдээ мэдээлэл бичиж танилцуулан 41 хэрэг илрүүлсэн байна.

Дээрх нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдэгдэл, зөвлөмж 112 хүргүүлэн нийт 74 удаа 7700 орчим иргэдэд яриа танилцуулга хийж, 1940 иргэдээс санал хүсэлтийг авч ажилласан байна. Хариуцсан багийн Засаг дарга, багийн ажлын албатай хамтран иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг нийтийн эргүүлд 167 удаа 749 иргэдийг татан оролцуулсан.

Саатуулах, баривчлах байрны үйл ажиллагааны талаар: Эрүүлжүүлэх, саатуулах байранд гэмт хэрэг, зөрчлийн холбогдлоор 2022 онд эрүүлжүүлэгдээд хэсгийн байцаагч, эрүүгийн төлөөлөгч, мөрдөгч нар дээр цохогдсон үлдэгдэл 596 хүний төлбөрийг нөхөн барагдуулах талаар зөвлөлийн хурлын шийдвэрээр ажлын хэсгийг байгуулан, ажлын хэсгийн ахлагчаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, гишүүдэд эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга, эмч, нягтлан бодогч нарын бүрэлдэхүүнтэйгээр 2022 оны 03 дугаар сарын 15-ны дотор үүргийг хэрэгжүүлэн, төлбөрийг бүрэн барагдуулж ажиллав. 2096 хүнээс 8 сая 698,400 төлбөр 82,9 хувьтай

Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар эрүүлжүүлэх байранд 2526 хүн зөрчлийн улмаас эрүүлжүүлэгдсэний дотор эрэгтэй 2401, эмэгтэй 125 хүн бүртгэгдсэн байна. Цагдаагийн газрын дотоод сүлжээнд 2526 хүний картыг шивж, эрэн сурвалжлах асап сантай тулгалт хийж 3 хүнийг дотоод сүлжээнээс олж тогтоон илтгэх хуудсаар холбогдох албан тушаалтанд танилцуулсан байна.

Мөн Шүүхийн шинжилгээний албаны павильон санд нийт 365 хүний гарын хээг шинээр бүртгэлд авч ажилласан байна.

Тайлангийн хугацаанд эрүүлжүүлэгдсэн нийт 2096 хүнээс 8 сая 698.400 төгрөгийн төлбөр хураамжийг авч, төлбөрийн тайланг тухай бүрд нь санхүү албанд хүргүүлэн ажиллажээ.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, Шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг нь Монгол Улсын хууль тогтоомж, цагдаагийн албаны тухай хууль болон цагдаагийн эргүүл харуулын дүрэм, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хамтарсан тушаал А/40, 113-г хэрэгжүүлэн, харуул хамгаалалтыг ердийнөөс өндөржүүлсэн бэлэн байдалд, өндөржүүлсэн бэлэн байдлаас ердийн байдалд шилжүүлэн зохион байгуулж, Шүүх, шүүгчийн аюулгүй байдал, шүүхийн байр, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон хуулиар хүлээсэн бусад чиг үүргүүдийг, биелүүлэн ажилласан.

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн алба хаагчид батлагдсан, хуваарь томилгооны дагуу Шүүхийн байрыг нийт 303 удаа 7248 хүн/цагийн харуул хамгаалалтын ажил үүргийг гүйцэтгэв.

Тус хэсгийн харуулын цагдаа, хамгаалалтыг цагдаа нар 2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар Эрүүгийн хэргийн шүүх хурал 464, Иргэний хэргийн шүүх хурал 591, Захиргааны хэргийн шүүх хурал 48, Зөрчлийн хэргийн шүүх хурал 523 тус тус болж, шүүх хурлын дэг журам сахиулж ажилласан. Үүнээс шүүх хуралдаанд шүүгч 1898, улсын яллагч 992, нарийн бичгийн дарга 1626, өмгөөлөгч 605, хохирогч 87, шүүгдэгч 513, хариуцагч 315, нэхэмжлэгч 598, гэрч 23, шинжээч 9, хэвлэл мэдээллийн ажилтан, бусад 4 оролцлоо.

Хуяглан хүргэгчээс хүлээн авсан яллагдагч насанд хүрсэн эрэгтэй , насанд хүрсэн эмэгтэй 2, насанд хүрээгүй-1 хуяглан хүргэгчид хүлээлгэн өгсөн яллагдагч насанд хүрсэн эрэгтэй 4, хүч нэмэгдүүлсэн 8, ердийнөөр 315 удаагийн хуяглан хүргэх ажиллагааг автомашинаар хийж ажилласан. Шүүхийн байранд 6291 иргэнийг шалган нэвтрүүлж, 24 зөрчлийг илрүүлэн шийдвэрлэж ажилласан.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсэг нь 2022 оны жилийн эцсийн байдлаар Дорнод аймаг дахь сум дундын шүүхээс иргэний хариуцагчийг албадан ирүүлэх тухай захирамж 62-г хүлээн авч ажилласнаас 62 захирамж биелүүлэн, яллагдагч 6, бусад зохигч 8, иргэний хариуцагчийг 50 албадан авчирч шүүгчийн туслахад хүлээлгэн өгч ажиллаа.

Шүүхийн харуулын цагдаа, хамгаалалтын цагдаа нарын үүрэг гүйцэтгэлд, хуяглан хүргэх ажиллагааны өдөр тутмын хяналтыг Цагдаагийн газрын ёс журмын эргүүлийн хамт тавьж нөхцөл байдлын талаар жижүүрийн шуурхай албанд цаг тутам танилцуулан үүрэг чиглэл авч ажилласан.

Цагдаагийн газраас албаны Элентра маркийн 62-28 ДОР улсын дугаартай автомашинаар хангаж Шүүхийн байрнаас Цагдан хорих байр хүртэл, Цагдан хорих байрнаас Шүүхийн байр хүртэлх хуяглан хүргэлт, Шүүхийн захирамж, шүүгчийн шийдвэрээр эрэн сурвалжлах, албадан ирүүлэх ажилд зарцуулах 14 хоногт 20л бензинээр ханган ажиллаж байна.

Шуурхай удирдлагын тасаг: Тайлангийн хугацаанд 2022 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар гэмт хэрэг, зөрчлийн 4547 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 3029, гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл 1407, сураггүй алга болсон, олдсон хүний талаарх мэдээлэл 18, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 242, зам тээврийн ослын 111 мэдээлэл бүртгэгдсэн байна. Үүнээс архидан согтуурахтай холбоотой дуудлага 1178, цагдаагийн алба хаагч болон гадаадын иргэнтэй холбоотой мэдээлэл 6 бүртгэгдсэн байна.

Шуурхай удирдлагын тасгаас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах /код-202/ журам”-ын хавсралт /Маягт ЦБҮАЖ № 202.31.6/-д заасан “Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авсан тухай тэмдэглэл”-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, журмын 202.3-т заасан гомдол, мэдээлэл хүлээн авах, 202.6-д заасан гомдол, мэдээллийг бүртгэх гэсэн заалтын дагуу цагдаагийн байгууллагад гомдол, мэдээлэл гаргагч иргэд нь гомдол, мэдээллийн хяналтын хуудсыг бичиж, дуудлага, мэдээллийг хүлээн авсан цаг хугацаа, хэргийн газарт очиж байгаа цагдаагийн алба хаагч үйл ажиллагаанд үнэлгээ өгүүлж хяналтын хуудастай тасгийн дарга нар танилцан цохолт хийж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Гэмт хэргийн санд баяжилт, хөдөлгөөнийг тогтмол хийлгэх үүднээс 7 хоног бүр үлдэгдэл хэргийн жагсаалтыг гаргаж, тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудтай тулгалт хийж, шийдвэрлэсэн боловч мэдээллийн санд шийдвэрлэлтийн маягтыг хийгээгүй, бусад газарт шилжүүлсэн боловч санд хөдөлгөөн хийгээгүй хэргүүдийн судалгааг гарган маягт дутуу шивсэн хэргүүдийн мэдээллийг нөхөн шивүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд 26 удаа гэмт хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн тулгалтыг тасгуудтай хийж ажилласнаас гадна 2022 оны эхний 12 дугаар сард аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийж цагдаагийн газрын удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.

Мөн аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээлэл судалгаа, танилцуулгыг долоо, 7 хоног бүр бэлтгэн цагдаагийн газрын удирдлага, нутгийн өөрөө удирдах байгууллагыг мэдээллээр ханган гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг

хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, өнөөгийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулахад ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код-701/ журам”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх /код-702/ журам”-ыг баримтлан мэдээллийн сан бүрдүүлж, баяжилт, хөдөлгөөнд хяналт тавьж, мэдээллийн санд түшиглэн дүн шинжилгээ хийж, цагдаагийн газрын удирдлага, хэрэглэгчдийг шаардлагатай мэдээ мэдээллээр шуурхай хангах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд өдөр тутам шивэгдэж байгаа мэдээллийг тасаг, албадын дарга нар хянасны дараа захиргааны тоо бүртгэгч, мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн нар бүртгэж, төвлөрсөн тоо бүртгэлд авч ажилласан.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд шивэгдсэн өргөдөл гомдлын 4543 маягт, гэмт хэргийн 1407 маягт, зөрчлийн 3136 маягт, эрүүлжүүлэгдсэн хүний 4192 маягт, захиргааны хяналтад байгаа хүний 19 маягтыг хянан төвлөрсөн тоо бүртгэлд авч, санд алдаатай шивэгдсэн 16 маягтыг буцаалгаж хариуцсан алба хаагчаар засуулан хяналт тавин ажиллав.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/ журам”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх /код 702/ журам”-ыг хэрэгжүүлэх, мэдээллийн сангийн ашиглалт, бүрдүүлэлтийг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр “Зөрчлийн хохирогч”, мөн оны 08 дугаар сарын 12-ны өдөр “Алдаанаасаа суралцахуй”, мөн оны 09 сарын 15-ны өдөр “Эрүүгийн хэргийн тулгалт-хяналт 2” зэрэг хэсэгчилсэн болон тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж алба хаагч нар сургалт орж ажилласан. Судалгааны хяналтын сангийн чиглэлээр гэмт хэргийг илрүүлэхэд ашиглах зорилгоор хамтарсан багуудаас объект, субъектийн 44 төрлийн судалгааг мэдээллийн санд шивж оруулсныг зөрчлийн тоо бүртгэгч, мэдээлэл судалгааны мэргэжилтэн нар хянаж төвлөрсөн тоо бүртгэлд авч ажилласан. Үүнд: Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг 38, зочид буудал 33, автомашин дулаан граж, ил зогсоол 17, банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо 50, томоохон зах бөөний төв 21, хаягдал түүхий эд авдаг газар 7, эмнэлэг 18, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж 265, аялал жуулчлал, амралтын газар 7, авто засвар сэлбэг хэрэгсэл борлуулдаг газар 20, интернэт, РС тоглоом, өнгөт хэвлэгч, олшруулагч ашигладаг газар 25, боловсролын байгууллага 46, эмийн сан, үйлдвэр 15, улсын онц чухал объект 3, буяны шашны байгууллага 5 буюу нийт 14 бүртгэлд 485 объект, *субъектийн бүртгэлд*: гэмт хэрэгт уруу татагч 121, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 178, архаг архичин 730, тэнэмэл иргэд 145, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүс 140, тусгай мэргэжлийн хүмүүс 8, ченжүүд 255, хэрэгт холбогдож, өртөж болзошгүй этгээд 1562, алт мөнгөний дархан 4, төв суурин газрын мал бүхий иргэд 230, нийт 11 бүртгэлд 3433 субъектийг бүртгэж картыг маягтын дагуу бичиж санд баяжилт хийлээ.

Цагдаагийн газрыг олон нийтэд таниулах, сурталчлах, иргэдэд тухай байгууллагын мэдээлэл нээлттэй ил тод байх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор Цагдаагийн газрын “Dornod.police.gov.mn” веб сайтад 178 шинэ мэдээлэл, “Дорнод аймгийн Цагдаагийн газар”, фэйсбүүк хуудсанд 189 мэдээ, мэдээлэл тавьж, 5900 мэдээг share-н, 52 төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны шинэчилсэн хувилбар, бусад төрлийн мэдээллийн баяжилтыг тухай бүр сайтад байршуулж ажиллалаа. Мөн “Dornod.police.gov.mn” веб сайтад мэдээллийн ил тод байдлын хэсэгт Цагдаагийн газрын үйл ажиллагааны тайланг 2022 оны 1 дүгээр улирал, хагас жил, 3 дугаар улирлын байдлаар, санхүүгийн ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдлын мэдээ тайланг байршуулан иргэд олон нийтэд сурталчилж ажиллалаа. Мөн Цагдаагийн даргаас өгсөн үүргийн дагуу “Дорнод цагдаа дотоод ажил” фэйсбүүк группт хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засварлаж ажиллав.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын төлөвлөгөөний дагуу Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 05 тоот албан даалгавар, дэд даргын өгсөн 4/1397 албан тоот үүргийг танилцуулж, албаны хэмжээнд яригдаж байгаа аливаа яриа, баримт бичиг, мэдээ мэдээллийг бусдад задруулахгүй байх талаар үүрэг чиглэлийг тогтмол өгч, ажиллаж байна. Цахим хуудсанд мэдээлэл тавих нэгдсэн бүртгэлийг гаргаж, вэб сайт, фэйсбүүк-т тавих мэдээ, мэдээллийг Цагдаагийн газрын даргаар хянуулан байршуулан ажиллалаа.

Цагдаагийн газрын дарга, “Чойбалсан хөгжил” ОНӨҮГазрын даргын 2022 оны 01 дүгээр улиралд “Гудамж зам талбайн телехяналтын камерын ашиглалт, хамгаалалтын байдлыг хангах зорилгоор “Хамтран ажиллах гэрээ”, “Засвар үйлчилгээ хийх график хуваарь”-ийг батлуулж, 3 дугаар улирлын байдлаар 3 удаа үзлэг хийж, засвар, үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлж, хяналтын 12 камерт засвар үйлчилгээ хийж ажиллав.

Чойбалсан хотын ундны эх үүсвэрийг хамгаалах тусгай салаа: Тус салааны алба хаагчид 2022 онд батлагдсан томилгооны дагуу “Дорнод НАА” ОНӨААТҮГ-тай байгуулсан харуул хамгаалалтын ажлын гэрээнд заасны дагуу Чойбалсан хот дахь цэвэр ус хангамжийн анги, цэвэр ус дамжуулах шугам насос, станцуудыг хамгаалах шалган нэвтрүүлэх 1-р пост, хяналтын 2,3-р постод 1535 удаа 36840 хүн/ цагийн харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн.

Салааны харуулчин, ахлагч нар 2022 онд шалган нэвтрүүлэх 1-р пост хяналтын 2,3-р постод албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа цэвэр усны анги хориотой болон ариун цэврийн бүсэд өдрийн болон өглөө оройн ээлжид гарч ажилласан 4539 хүний бичиг баримт болон биед үзлэг шалгалт хийж, гаднаас хамгаалалттай объектод албан ажлаар нэвтэрсэн 2760 хүн, 3710 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж нэвтрүүлж ажиллалаа.

Улсын онц чухал объектын шалган нэвтрүүлэх 1-р пост хяналтын 2,3-р постод харуул хамгаалалтын ажил үүрэг гүйцэтгэсэн харуулчин ахлагч нар 12839 хөдөлгөөн хяналтад авч ажиллан нийт 83 зөрчил илрүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Объектод тогтоосон дэглэм журам зөрчсөн зөрчил	36
2. Хориотой бүсийн дэглэм журам зөрчсөн зөрчил	46
3. Бичиг баримтын зөрчил	1

Зөрчлийн талаар холбогдох албан байгууллагуудад 35 удаа албан мэдэгдэл шаардлага өгч, заагдсан зөрчил дутагдлыг засуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Шалган нэвтрүүлэх 1-р цэг хяналтын 2,3-р цэгүүдэд албан үүрэг гүйцэтгэсэн харуулчин, ахлагч нарын ажлын хариуцлага, албаны сонор сэрэмжийг цагдаагийн газрын ёс журмын эргүүлтэй хамтран нийт 149 удаа шалгаж, тодорхой үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцон ажиллалаа. Долоо хоног бүрийн даваа гаригт салааны долоо хоногт хийж гүйцэтгэсэн хамгаалалтын ажлын танилцуулгыг Дотоодын цэргийн штабт хүргүүлэн ажиллаж байна.

Салаанд хөтлөгдвөл зохих бүртгэл судалгаанд баяжилт хийж алба хаагчдад Дотоодын цэргийн тухай хууль, цагдаа, дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдөр баталсан “Аюулгүй арга хэмжээний заавар”, байгууллагын стандарт cs11-0129:2018, дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм, дотоодын цэргийн үйл ажиллагааны журам болон албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар, журмуудыг танилцуулж, хоног тутам зааварчилга өгч баталгаа авч, гарын үсэг зуруулан биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.

“Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын удирдлагад хамгаалалтын үйл ажиллагааны мэдээлэл болон хамгаалуулагч байгууллагын ажилчдаас илрүүлсэн зөрчил, харуул хамгаалалтад ашиглагдаж байгаа инженер техник хэрэгслийн засвар үйлчилгээ бусад шаардлагатай зүйлийн талаар албан тоотоор, долоо хоног бүрийн Даваа гаригт өгч биелэлтийн хариуг тооцон ажиллалаа.

Салбарын хариуцлагатай эргүүлийг 24 цагаар томилон улсын онц чухал объектын харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын сонор сэрэмж, албаны бэлэн байдлыг тогтмол шалгаж, хамгаалуулагч байгууллагын удирдлагад хамгаалалтын үйл ажиллагааны мэдээлэл болон хамгаалуулагч байгууллагын ажилчдаас илрүүлсэн зөрчил, харуул хамгаалалтад ашиглагдаж байгаа инженер техник хэрэгслийн засвар үйлчилгээ бусад шаардлагатай зүйлийн талаарх мэдээллийг албан бичгээр өгч, хариуг тооцон, улсын онц чухал объектод нэвтэрч байгаа ажилчдын биеийн халууныг хэмжиж бүртгэл хөтлөн, гарыг ариутган нэвтрүүлж амны хаалтгүй ажилтныг нэвтрүүлэхгүйгээр буцаан хамгаалуулагч байгууллагын удирдлагад танилцуулж, заавар зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Шалган нэвтрүүлэх байр болон хяналтын цэгүүдэд ариутгал цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж, үүрэг гүйцэтгэх хугацаанд амны хаалтыг тогтмол зүүж хэвших талаар үүрэг, ажлын чиглэл өгч, хамгаалуулагч байгууллагатай хамтран ариутгал,

халдваргүйтгэлийг 7 хоногт 2 удаа хийж нийт 24 удаа халдваргүйжүүлэлт хийн, тогтоосон дэглэмийг сахиулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Дотоодын цэргийн анги, тусгай салбарын 2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний дагуу тус цагдаагийн газрын холбооны инженер цагдаагийн хошууч В.Болормаа, харуулын дарга, хошууч Б.Гэрэлчулууны хамтаар Улсын онц чухал объектын хамгаалалтын харуулын цэгүүдээр явж холбоо, телехяналтын камер, компьютер, техник тоног төхөөрөмжид үзлэг хийж, илэрсэн зөрчлийг засах чиглэлээр хамтран ажиллав.

Улсын онц чухал объектын Цэвэр ус хангамжийн ангийн 1 дүгээр өргөгчийн инженер техникийн хэрэгсэлд хамгаалуулагч байгууллагын машинаст, харуулчин ахлагч нар хамтарсан үзлэг шалгалт хийж, Хяналтын 2, 3 дугаар цэгийн гаднах гортиг, хамгаалалтын хашааны өргөст тор унжсан, тасарсан хэсгийг бүрэн бүтэн болгон, Гүний 8-р худгийн урд “Хориотой бүс” гэсэн тэмдэг 2 ширхгийг хийж байршуулан, Шалган нэвтрүүлэх цэг, харуулын даргын өрөөнд нэгдсэн интернэтийн төхөөрөмж байршуулан, телехяналтын камерыг бүрэн ажиллагаанд оруулан засварлалаа.

Тус салбараар “Үзлэг-хяналт, шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг санаачлан удирдамж, төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус арга хэмжээний хүрээнд 2022.09.08-ны өдөр томилгоот үүрэг гүйцэтгэсэн харуулын бүрэлдэхүүн үзлэг шалгалт хийж ажиллах хугацаанд Хяналтын 3 цэгийн орчимд 1 иргэн явааг саатуулан шалгахад БНХАУ-ын иргэн Улаанбаатар хотоос хүн тосох гэж байгаад төөрсөн гэх тайлбартай явж байсныг шуурхай арга хэмжээ авч Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд болон Дотоодын цэргийн штабт мэдэгдэж уг этгээдийг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч ажиллалаа.

В. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/582 дугаартай захирамжаар “Мал Мах Хяналт-2022”, “Торгон хил” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хооронд зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, малыг гоц халдварт өвчний үед зөвшөөрөлгүй мал, мах зах зээлд худалдан борлуулах зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, малчдын бүлэг холбоог шинэчлэн байгуулах, сайн дурын үндсэн дээр нэгдсэн малчдын бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймгийн хэмжээнд мал, махны худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах зэрэг ажлуудыг төлөвлөн, мал хулгайлах 42 холбогдогчтой 19 гэмт хэргийг илрүүлснээс 12 хэргийг яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлэн, одоо 7 хэргийг яллагдагчаар татах саналтай прокурорт хүргүүлэхээр холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулж ажиллав.

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/582 дугаар захирамжаар “Мал, мах хяналт-2022” нэгдсэн арга хэмжээ, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргын баталсан “Торгон хил-2022”, Аймгийн ГХУСАЗСЗ-ын 05 дугаар тогтоолоор баталсан тэргүүний “Малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдаан, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/297 дугаар “Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэлтийг ахиулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгт улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох, эзэн холбогдогч тогтоогдоогүй хэрэг бүртгэлтийн хэргүүдийг шалгаж шийдвэрлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн газраас ажиллах салбар төлөвлөгөө, удирдамжийг гарган батлуулж, төлөвлөгөөнд заагдсан ажил, арга хэмжээнүүдийг тодорхой үе шаттайгаар зохион байгуулан ажиллалаа.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх тухай хууль, Хууль зүйн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/160/А-73 тоот хамтарсан тушаалыг хэрэгжүүлэх, сум, баг бүрт мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах “Малчдын бүлэг”-ийг байгуулж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд иргэд, малчид, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ахиц гаргах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 10-наас 45 хоногийн хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “03”

дугаар тогтоолоор батлагдсан удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд тэргүүний “Малчдын бүлэг” болзолт уралдаан зохион байгуулах нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, дүгнэв.

Тэргүүний “Малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдааны хүрээнд сум бүрт мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах малчдын сайн дурын бүлгийг байгуулах, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн гишүүд, малчдын бүлгийн гишүүдэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, журмуудыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, шагнаж урамшуулах ажилд шаардагдах 2,5 сая төгрөгийг “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд хөтөлбөр”-ийн зардлаас шийдвэрлүүлж ажиллав.

Чойбалсан, Дашбалбар, Булган сумдын хийж гүйцэтгэсэн ажил шалгарч сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, хэсгийн төлөөлөгч нарыг 2,000,000 сая төгрөгийн шагналын сантайгаар урамшуулж 13 сумын нутаг дэвсгэрт гэмт хэрэг ихээр үйлддэг газруудад 42 малчдын бүлгийг шинээр байгуулаа. Тэргүүний “Малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдаан удирдамж төлөвлөгөөг 2022 оны 11 дүгээр сарын 01-ны Аймгийн ГХУСАЗСЗ-ын 05 дугаар тогтоолоор батлуулан зохион байгуулан ажиллалаа. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэлтийг ахиулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг олж тогтоох, хэрэг бүртгэлийн хэргүүдийг шуурхай шалгаж шийдвэрлэх зорилгоор Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 2018 оны 106 дугаар дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газартай хамтран аймаг, сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал, махны худалдаа эрхэлдэг аж ахуй нэгж, зах худалдааны төвүүд, аймгийн төв зам дагуу малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн зурагт самбар, боршур, аймгийн төвөөс орох, гарах төв зам дагуу байрлах Ялалт, Баянтүмэн гүүрний /10x12/ самбаруудад аннос байршуулж, 13 сумдаас гарах замуудад иргэдэд хандсан ухуулга сурталчилгааг явуулжээ.

Мөн малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй алба хаагч нар аймгийн Хөгжимт драмын театрын найруулагч, жүжигчидтэй хамтран 2 шторк, контент нэвтрүүлэг бэлтгэн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг “Мижи”, “Дорнод ТВ”, “Шинэ суваг”, “Жаран.мн” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар цагдаагийн газар болон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн page хуудсаар мал хулгайлах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, малаа хариулга маллагаатай байлгах талаар анхааруулга сэрэмжлүүлгийг тогтмол нэвтрүүлж нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор орон нутгийн 6 телевизэд ярилцлага өгч, 2 ФМ радио болон Jaran.mn сайтад мэдээлэл нийтэлж ажиллалаа.

Арга хэмжээний хүрээнд “Хулгайч нарт боломж бүү олго”, “Малчин таны хариуцлага хамгийн чухал”, “Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авч байна”, “Эрдэнэт болсон мал сүргээ эзэнгүй бүү орхи”, “Малын хулгайн ял шийтгэл чангарлаа” зэрэг 2500 ширхэг боршур зурагт хуудсыг бэлтгэн малчин болон мал бүхий иргэдэд түгээж, олон нийтийн цахим хэрэгсэл “facebook” хуудсанд бэлтгэсэн мэдээллийг түгээсэн нь үр дүнтэй урьдчилан сэргийлэх ажил болж байна.

“Торгон хил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Цагдаагийн газар нь Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хоорондын хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааны хамтарсан ажлын хэсгийн 2021 оны хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 5в/7870 дугаартай албан бичгээр өгсөн зөвшөөрөл, ажлын чиглэл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гадаадын байгууллага, иргэнтэй харилцах /код 131/ журам”-д заасныг тус тус удирдлага болгон Өвөрбайгалийн хязгаарын Чита хот, Агийн Бурятын тойрогт Цагдаагийн газрын даргаар ахлуулсан, хил залгаа сумдын тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарын бүрэлдэхүүнтэй 2022 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрийг хүртэлх хугацаанд үүрэг гүйцэтгэж ажиллалаа.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газартай хамтран аймаг, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж

байгаа мал, махны худалдаа эрхэлдэг аж ахуй нэгж, зах худалдааны төвүүд, аймгийн төв зам дагуу малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт самбар бэлтгэн 3 цэгт байршуулан ажилласан.

Аймгийн хэмжээнд олон дагагчтай, хандалт өндөртэй “Жаран,мн” сайттай хамтарч Цагдаагийн газрын зүгээс аймгийн хэмжээнд үйлдэгдсэн малын хулгайн гэмт хэрэг нөхцөл байдал, илрүүлэх чиглэлээр болон урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар 10 минутын нэвтрүүлгийг бэлтгэн малчид иргэдэд түгээх ажлыг хийв.

Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Прокурорт, аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч нартай хамтарч “Малын хулгайн гэмт хэргийн шийдвэрлэлтийг ахиулах” сэдвээр уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж тодорхой үр дүнд хүрч ажиллалаа.

Г. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн болон Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, орон нутгийн удирдлага, Цагдаагийн байгууллагын даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, Цагдаагийн ерөнхий газрын 2022 онд дэвшүүлсэн зорилтыг ажилдаа удирдлага болгон хүүхдээс гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, бууруулах, гэмт хэргийг таслан зогсоох, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын оролцоонд тулгуурлан тодорхой төрлийн ажлуудыг хэрэгжүүлж ажиллалаа.

Тус цагдаагийн газраас хүүхдийн эрхийг хангах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон бусад төрийн байгууллагуудтай хамтран “Хүүхэд хамгаалал”, “Сэрэмжлүүлье”, “Сэрэмжилье-нэгдье”, “Хүчирхийлэлгүй хүүхэд”, “Сургууль аюулгүй орчин”, “Хамтарсан баг-Хяналт”, “Шөнийн дуран”, “Хөршийн холбоо”, “Хүчирхийлэлгүй-Орчин” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллав.

Зохион байгуулсан онцлог ажил арга хэмжээг дурдвал: Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлэх болон Гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээний тухай ойлголт, хамгаалалтын арга хэмжээнд хэрхэн хамрагдах талаарх мэдээллийг өгөх, хамтарсан багийн гишүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор “Хамтарсан багийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалт, зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүнийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хамтарсан багаараа хөгжье, суралцъя” зөвлөгөөнийг цагдаагийн газраас санаачлан зохион байгуулж, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн Аймгийн засаг даргын орлогч бөгөөд хүүхдийн эрхийн хорооны дарга, Хэрлэн сумын засаг дарга нар урилгаар оролцов.

Монгол улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн, ХЭҮК-ийн ИНЗ-ийн гишүүн Д.Ундраа насанд хүрээгүй хүнийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хамтарсан багийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах урьдчилан сэргийлэх” сэдвээр мэдээллийг хүргэн, зөвлөгөөнд оролцож байгаа оролцогчоос санал хүсэлтийг авч ажиллав. Уг зөвлөгөөнд цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, мөрдөн байцаах тасгийн дарга, 13 сумын хэсгийн төлөөлөгч, 11 багийн хэсгийн байцаагч, Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, Цэцэрлэгийн нийгмийн ажилтан, багийн засаг дарга, нийгмийн ажилтан, нийт 85 иргэдийг хамрууллаа.

Хууль зүй дотоод хэргийн яам, Хөдөлмөр нийгэм, хамгааллын яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүн амын сан хамтран зохион

байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон талт хамтын ажиллагаа” сэдэвт үндэсний чуулганд алба хаагчдыг хамруулав.

Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн нийгмийн ажилтан нартай хамтран “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн гишүүдийг чадавхжуулах, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс сэргийлэх, сургуулийн орчинд хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд 09 дүгээр сард 52 сурагчдад танхимын сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын А/23 дугаар захирамжийн дагуу алслагдсан сум, багийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-г 13 сумдад зохион явуулах аймгийн засаг даргын чиглэлийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага болон тодорхой хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран аймгийн нийт 13 сумдаар тус бүр 2 хоногийн хугацаатай ажиллаж, иргэдэд эрх зүйн боловсрол олгох сургалт, сурталчилгаа мэдээ, мэдээлэл хүргэж, эрх зүйн зөвлөгөө өгч, сумдын алслагдан байршилд амьдардаг төрийн үйлчилгээг тухай бүр авч чаддаггүй иргэдийг уг арга хэмжээнд оролцуулж санал хүсэлтийг сонсож, гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх болон таслан зогсоох зорилгоор нэг бүрчлэн ганцаарчлан, уулзаж ярилцаж гарын авлага, зурагт хуудас зэргийг тарааж ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион явуулах төлөвлөгөөний дагуу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж зөрчил гаргаж шүүхийн шийтгэвэрээр баривчлагдсан иргэдэд аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай”, “Архи тамхины хор нөлөө”, “Гэр бүлийн хүчирхийлэл түүний шинж” сэдэвт сургалтыг 7 хоногийн “Пүрэв”, “Баасан” гарагуудад хуваарийн дагуу зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 123 иргэнийг хамруулаад байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1, 34.1, Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу хүлээн авч, үйлчлүүлэгчид үзүүлэх суурь үйлчилгээ, үйлчлүүлэгчийг асран хамгаалах, үйлчлүүлэгчийг тайвшруулах, сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, холбон зуучлах болон гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээнүүдийг үзүүлэн ажиллалаа.

Д. Сэтгэл зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил

Цагдаагийн газрын сэтгэл зүйчээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан ЦБҮАЖ-ийн /код-938/-д заасны дагуу алба хаагчид сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чиглэлээр цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүйн байдлыг судлан оношлох, цагдаагийн байгууллагын алба хаагч, ажиллагсад зориулсан сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, алба хаагч, ажиллагсдын хүсэлтээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал болон дэмжих бүлгийн ярилцлага хийх, мэргэжлийн тусламж, үйлчилгээний явцад гарсан асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагад мэдээлэл өгөх, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтад мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах, мэргэжлийн мэдлэг, чадвараа хөгжүүлэх, шинийг санаачилж, хэрэгжүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цагдаагийн газрын даргын тушаалаар алба хаагчдын Эрүүл мэнд сэтгэл зүйн баг Шуурхай удирдлагын тасгийн даргаар ахлуулсан Сэтгэл зүйч, эрүүлжүүлэх саатуулах байрны эмч нарын 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан үйл ажиллагаа тогтмол явуулж байгууллагын хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажил, зохион байгуулалтын арга хэмжээ авч байгаа ажлын талаар мэдээллээр ханган долоо хоног бүрийн “Баасан” гарагт нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж ажиллав.

Тус багаас хийж хэрэгжүүлсэн ажлаа 7 хоног бүрийн Баасан гарагт нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж хэвшсэн. Тус цагдаагийн газрын “Дорнод цагдаа-Алба хаагчдын

чөлөөт индэр” цахим хаягт эрүүл мэнд, сэтгэл зүйн багаас алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор цахим зөвлөмж 12, сэтгэл зүйн мэдээлэл 21 удаа байршуулан хүргүүлэв.

Мөн цагдаагийн газрын “Эрүүл мэнд-Сэтгэл зүйн” багаас алба хаагчдад Харилцааны ёс зүй” сэдвээр Дорнод Их сургуулийн Монгол хэл уран зохиолын тэргүүлэх багш Г.Цоглхагва, “Монгол хэл бичгийн заавар, зөв бичих дүрэм”-ийн талаар Улсын тэргүүний 5-р сургуулийн Хэл уран зохиолын багш М.Хэнчбиш, “Хорт зуршлаас татгалзах арга, архины хор уршиг”-ийн талаар Дорнод аймгийн Сэтгэц эмгэг наркологиын сэтгэц эмгэгийн мэргэжилтэн Н.Урангэрэл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Гэр бүлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Хэрлэнтуул “Ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт орж, сэтгэл зүйн тест бөглүүлж, хэрхэн стрессийг бууруулах талаар зөвлөмж өгч, БОЭТөвийн яаралтай түргэн тусламжийн тасгийн эмч Э.Наранбаатар, Т.Тэмүүжин, сувилагч Б.Ууганбаяр нар “Эмнэлгийн анхан шатны тусламж амилуулах суурь тусламж”-ийг практик сургалтыг тус тус зохион байгуулав.

Сэтгэл түгшил, сэтгэл гутрал, мэдрэл-сэтгэцийн тогтвортой байдал, ММРІ, Люшерийн /өнгө/ сорилыг судалгаандаа тогтмол ашиглан алба хаагчдаас сорилыг авч судалгааны дүгнэлтийг гарган дунд хугацааны сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллав. Сэтгэл зүйн туслалцаа үзүүлэхэд зүйрлэлийн /МАК/ картыг ашиглан 4 алба хаагч, 1 гэр бүлийн гишүүнтэй ярилцлага, зөвлөмжийг өгч ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт Аюулгүй байдлын хэлтсээс 2022.11.11-ний өдөр 6/8965 дугаартай алба бичгээр ирүүлсэн Цагдаагийн алба хаагч ажилтны ажлаас халшрах хам шинжийн урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд зориулан бэлтгэсэн сэтгэл зүйн дасгал тоглоом бүхий гарын авлагыг алба хаагч нарын сургалт, ганцаарчилсан уулзалтад ашиглаж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт Аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд сэтгэл зүйн тасгийн даргын 2022.09.23-ний өдөр 66/7626 дугаартай алба бичгээр ирүүлсэн Оросын холбооны Улсын Москва хотын их сургуулийн профессор, сэтгэл судлаач Е.В.Харитоновыгийн “Хувь хүний нийгэм, мэргэжлийн хэрэгцээт байдлын сорил, А.В.Леорова, С.Б.Величковская нарын “Ажиллах чадварын бууралтыг судал сорил”-уудыг үйл ажиллагаандаа ашиглаж, алба хаагчдаас стресс түүний шалтгаан нөхцөлийн талаарх судалгааг авч цагдаагийн газрын даргад танилцуулсан. Судалгаагаар 21 алба хаагч буюу 26,7 хувь нь стрессгүй, 32 алба хаагч буюу 46,5 хувь нь дундаас доош түвшний, бага зэргийн стресстэй, 10 алба хаагч буюу 14,1 хувь нь дунд зэргийн, хөнгөн стресстэй, 5 алба хаагч буюу 7 хувь нь дундаас дээш түвшний стресстэй, 4 алба хаагч буюу 5,6 хувь нь Стрессийн өндөр түвшинд байна. Алба хаагчдад өдөр тутам хэрэглэж стрессээс урьдчилан сэргийлэх аргын талаар мэдээлэл хүргэж ажиллав.

Сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан, албаны шалгалт хийгдсэн 21 алба хаагчтай ганцаарчилсан уулзалт ярилцлага зохион байгуулав. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга шинээр томилогдсонтой холбогдуулан тасгийн алба хаагчдаас санал асуулга авч дүгнэсэн.

Сэтгэл зүйн өрөө, тасалгааг тохижуулахад шаардагдах төсөв, зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлж, сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Сэтгэл зүйн өрөөг тохижуулах төсөв”-ийг гаргаж зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэн холбогдох газарт хүргүүлэв.

Цагдаагийн албанд орж ажиллах хүсэлт гаргасан 18 иргэнээс сэтгэл зүйн хэв шинжийг тодорхойлох зорилгоор Айзенкийн темпераментыг тодорхойлох тест, сэтгэлгээний хэв маяг, сэтгэн бодох чадварын тестүүдийг авч сэтгэл зүйн тодорхойлолтыг гарган холбогдох материалыг хавсаргаж ажилласан байна.

Алба хаагчдын сэтгэл санааны байдлыг илрүүлэх зорилгоор сэтгэл зүйн хэв шинжийг тодорхойлох Айзенкийн темпераментыг тодорхойлох тест, Сэтгэлгээний хэв маяг тодорхойлох тестүүдийг авч дүгнэж ажиллалаа.

Е. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр.

Тус аймгийн хэмжээнд гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газар болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтыг тодорхой хувиар бууруулах, зөрчлийн илрүүлэлтийг ахиулах зорилтыг тавьж эргүүл, шалгалтыг хуваарь, хүн хүчний тооцоог гарган гудамж талбай, олон нийтийн газрыг хяналтад авах, иргэд байгууллага аж ахуйн нэгжээс ирж байгаа дуудлага мэдээлэлд шуурхай хандах, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүргэх, эргүүлийг оновчтой зохион байгуулах чиглэлээр

авто хөдөлгөөнт эргүүлийг аймгийн төвийн 11 багийг 4 бүсчлэлд хувааж зохион байгуулан ажиллав.

Аймгийн хэмжээнд жил бүр гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн цаг хугацаа, үйлдлийн арга, шалтгаан нөхцөлд криминологи судалгаа хийж аймгийн хэмжээнд 134 эмзэг цэг, хэсэг, гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй газрын судалгааг гарган, хэв журмын эргүүлийг зохион байгуулахдаа алба хаагч нарт анхааруулан, хяналт тавих чиглэлээр үүрэг зааварчилгаа өгч биелэлт үр дүнг ханган ажиллалаа. Үүнд:

Жагсаал, цуглааны талаар: Аймгийн хэмжээнд улс төрийн нам, эвсэл, иргэний хөдөлгөөн, иргэдээс зохион байгуулсан 9 удаагийн жагсаал, цуглааны арга хэмжээний хамгаалалтыг төлөвлөгөө, зураглал, хүн, хүчний хуваарийг гарган биечлэн хяналт тавьж зохион байгууллаа.

Тус аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч П.Гэрэлбаатар нь 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 10:00 цагт Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Тусгаар тогтнолын талбай”-д нутагтаа сайхан амьдрах, төр засгийн бодлого шийдвэр, үнийн өсөлтийг эсэргүүцэж байна, өсөж төрсөн нутагтаа амгалан тайван амьдармаар байна гэх уриа лоозон барьж иргэдийг жагсахыг цахимаар уриалан жагсаал, цуглааныг зохион байгуулсан.

Тус аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр багийн иргэн “Улам ундрах” ТББ-н захирал Ш.Уламбаяр нь 2022 оны 04 дүгээр сарын 16, 17-ний өдрүүдэд 10:00 цагаас 17:00 цагийн хооронд “Тусгаар тогтнолын талбай”-д ард түмний хуралдаан хуралдуулах зорилгоор цуглаан зохион байгуулсан бөгөөд тус мэдээллийн дагуу нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамгаалалтыг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 23 дугаар хорооны иргэн Т.Дөлгөөн нь 2022 оны 04 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд 11:00 цагаас 21:00 цагийн хооронд “Зэвтэй усны эсрэг” гэх уриан дор жагсаал, цуглааныг Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах аймгийн Засаг даргын тамгын газрын үүднээс “Дорнод НАА” ОНӨААТҮГ хүртэл явган хүний зам талбайгаар тайван жагсаал зохион байгуулсан.

Хэрлэн сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах “Найрамдал” цэцэрлэгт хүрээлэнд “Дорнод аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо”-ний дарга Х.Баатарсүх нь “Олон улсын хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл”-ийн өдрийг тохиолдуулан 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 11:00 цагаас 13:00 цагийн хооронд “Нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтыг ижил тэгш олго, Монголдоо ажиллаж сайхан амьдаръя, хяналтгүй үнийг хязгаарла” гэх уриа лоозон барьж тайван жагсаал зохион байгуулсан ба тус жагсаалд 150 орчим иргэд, дэмжигчид хамрагдсан.

“Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл” ТББ-ын тэргүүн Г.Адилбиш, Халхгол сумын Ялалт багийн иргэн Л.Алдармаа, Б.Бямбадорж нар нь бүтээгдэхүүн хуваах гэрээнд өөрчлөлт оруулах зорилготой 5 шаардлагын хүрээнд тус аймгийн Халхгол сумын Ялалт багийн нутаг дэвсгэр байрлах “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ны газрын тосны тээвэрлэлт явуулдаг төв замд 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 13-ны өдрийн хооронд эсэргүүцлийн жагсаалыг зохион байгуулсан. Тус жагсаалын үед Г.Адилбишээс цахим орчинд шууд бичлэг хийн жагсаал, цуглаанд иргэдийг уриалсны дагуу “Нэгүүн.мн”, “Фокус мик.мн” зэрэг мэдээллийн сайт, “Монголоо аваръя”, “Босоо хөх Монгол Дорнод салбар” зэрэг төрийн бус байгууллагуудын төлөөлөл, мөн цахим орчинд олон дагагчтай гэх Г.Солонго, Р.Батбуян, М.Мягмарсүрэн /Х.Тэнгэрхүү/, Б.Соронзонболд нар Улаанбаатар хотоос Халхгол суманд ирж, тэдний үйл ажиллагааг дэмжин хэт нэг талыг барьсан, бодит бус мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж, үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг буруушаасан, эсэргүүцсэн мэдээ, мэдээллийг цахим орчинд идэвхтэй түгээсэн. Мөн иргэн Г.Адилбиш нь жагсаал, цуглааныг зохион байгуулах явцдаа Баянхошуу хилийн боомт руу зорчих авто замыг жагсагчдын хамт дур мэдэн хааж, газрын тосны улс хоорондын тээвэрлэлтийг түр хугацаагаар зогсоосон гэх хууль бус үйлдэл гаргасан тул Халхгол сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Жагсаал, цуглааныг албадан тараах тухай” А/117 дугаартай захирамжийн дагуу Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 503/ журам”-д заасныг баримтлан албадан тараасан.

“Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл” ТББ-ын тэргүүн Г.Адилбиш /жм84012164/, Г.Солонго /Ц385051501, Б.Соронзонболд /ЖЭ84101370/ нар нь 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Халхгол сумын Ялалт багийн нутаг дэвсгэр байрлах Монгол Улсын Хилийн

Баянхошуу боомтоос баруун тийш 50 км зайд газрын тосны 21 дүгээр талбайн төв /магистрал/ замд нь бүртгэлгүй жагсаал, цуглаан зохион байгуулж зам хаах хууль бус үйлдэл гаргасан тул Халхгол сумын ЗДТГазрын дарга Н.Ариунсүвд дээрх бүртгэлгүй жагсаал, цуглааныг 2 цагийн дотор сайн дураараа тарах талаар шаардлага хүргүүлсэн боловч шаардлагыг үл биелүүлсэн тул ЦАТХуулийн 23 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 503/ журам"-д заасныг баримтлан албадан тарааж хуульд заасан үндэслэл журмын дагуу арга хэмжээ тооцож ажилласан.

Хэрлэн сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр байрлах "Тусгаар тогтнолын талбай"-д аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Х.Баатарсүх нь 2022 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн 12.00-14.00 цагийн хооронд "Төрийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх" уриан дор бүртгэлтэй тайван цуглааны арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд жагсаал цуглаанд цэцэрлэгийн багш, эмнэлгийн эмч, ажилчид, татварын алба, нийтийн аж аж ахуй, ус, цаг уур орчны шинжилгээний газрын нийт 113 иргэн нэгдэн оролцсон байна.

Ардчилсан намын гишүүн Т.Энхтөр, Б.Билгүүн нар Хэрлэн сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Ардчилсан намын байрны гадна талбайд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 12.00-18.30 цагийн хооронд "Ардчилсан намаа аваръя" гэх уриатай жагсаал, цуглааныг нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажилласан. Жагсаал цуглаан зохион байгуулж байгаа иргэд Ардчилсан намын дарга У.Дашид намын байрыг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр чөлөөлж өгөх талаар "Шаардлага" хүргүүлэн тарсан болно.

Тус аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр багийн иргэн "Улам ундрах" ТББ-н захирал Ш.Уламбаяр нь 2022 оны 12 дугаар сарын 05-наас 15-ны өдрүүдэд 12:00 цагаас 16:00 цагийн хооронд "Тусгаар тогтнолын талбай"-д "Нүүрсний хулгайчийг зарла" гэх зорилгоор Хэрлэн сумын Засаг даргын тамгын газарт бүртгүүлсэн ба цуглаан зохион байгуулсан бөгөөд тус мэдээллийн дагуу нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамгаалалтыг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Хорио цээрийн дэглэмийн талаар: Тус аймгийн Баянтүмэн сумын 2 дугаар баг Хулстайн булаг гэх газарт оршин суух малчин Ч.Мягмарсүрэн, У.Баттулга нарын үхэр сүрэгт 2022 оны 06 дугаар сарын 18-ны өдөр үхрийн арьс товруутах өвчин илэрсэнтэй холбогдуулан Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан 2019 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар", 2022 оны "Үхрийн арьс товруутах өвчинтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай А/143 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж, аймгийн Онцгой комиссын 18, дугаар тогтоолын дагуу үхрийн арьс товруутах өвчний хорио цээрийн дэглэмийг мөрдүүлж, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.

Өвчний тохиолдол илэрснээс хойших хугацаанд аймгийн Онцгой комиссыг 5 удаа, Хөлөнбуйр сумын Онцгой комиссыг 4 цахим хурал зохион байгуулж, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал эмнэлгийн газраас мэргэжлийн удирдлага заавар зөвлөмжөөр аймаг, сумын Онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудыг хангаж, өвчин гарсан баг, нутаг дэвсгэрт хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

Аймгийн Онцгой комиссын 25 дугаар тогтоолоор малын гоц халдварт өвчин батлагдсан /Баянтүмэн, Булган, Баяндун, Дашбалбар, Матад, Халхгол/ сумдаас 2022 оны 10 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэл хугацаанд хорио цээрийн дэглэмийг сунгаж, аймаг дотор бүх төрлийн мал, мах түүхий эдийг "Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар"-ын дагуу тээвэрлэх, худалдан борлуулах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэхийг хориглож, эрүүл байгаа /Баян-Уул, Гурванзагал, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Чулуунхороот, Хэрлэн/ сумдын нутаг дэвсгэрээс Бүх төрлийн мал, мах, түүхий эдийг Хөлөнбуйр сумын хяналтын цэгээр дамжуулан нийслэл болон бусад аймаг руу үржлийн бус, хүнсний хэрэгцээний зориулалтаар ачааны тээврийн хэрэгслээр нийт 4802 тээврийн хэрэгсэл дамжин өнгөрсөн Мал эмнэлгийн байгууллагатай хамтран хяналтыг зохион байгуулан ажилласан. Цагдаагийн байгууллагаас 60 алба хаагч, Мал эмнэлэг болон орон нутгийн төрийн байгууллагаас нийт 120 төрийн алба хаагч 5 тээврийн хэрэгсэлтэй ажил үүргийн дагуу 24 цагийн тасралтгүй хяналтыг тавин 2880 хүн цагийн үүргийг гүйцэтгэн ажилласан байна.

Цагдаагийн газрын дарга, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга нараас Зааварчилга, үүрэг чиглэл өгч, цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт, ЦБҮЖ-уудыг дагаж мөрдөх, үүрэг гүйцэтгэхдээ албаны бэлэн байдлыг хангах, өөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар зааварчилж, гарын үсэг зуруулж баталгаа авч Цагдаагийн газрын даргын тушаалаар томилон ажиллаж байна.

Хөлөнбуйр сумын малын гоц халдварт арьс товруутах өвчний постод нийт 12 алба хаагчийг постод 7 хоног тутамд ээлжийг солилцуулан алба хаагчдын ажлын ачаалал, амралтын цагийг ханган ажиллаж, алба хаагчдын сахилга ёс зүй, үүрэг гүйцэтгэлтэд Хөлөнбуйр сумын цагдаагийн тасгийн дарга х/ч Б.Эрдэнэхөлөгөөр өдөр бүр хяналтыг тавиулан Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд өдөр тутам хийсэн ажлын мэдээг нэгтгэн ажилласан. Хорио цээрийн дэглэм сахиулах хяналтын постод үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч нараас гаргасан санал хүсэлт тулгарч буй хүндрэл бэрхшээл, сахилга ёс зүйн зөрчил дутагдалгүй хэвийн үүрэг гүйцэтгэн ажилласан болно.

ГУРАВ. САХИЛГА ХАРИУЦЛАГА, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВИЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТАЛААР

А. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн.

Цагдаагийн газар нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Төрийн албаны сахилга дэг журам, ажлын хариуцлагыг чангатгах тухай 258 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2022 оны 01 сарын 31-ны өдрийн 3/44 дүгээр албан бичгээр ирүүлсэн “Сахилга, ёс зүйг чанд баримтлах үүрэг хүргүүлэх тухай” чиглэлийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцож ажиллалаа. Цагдаагийн газрын даргын “Сахилга, ёс зүйг дээшлүүлэх тухай” албан даалгавар 1, албадын дарга нарын манлайллыг дээшлүүлэх, алба хаагчдын сахилга хариуцлагыг чангатгах, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр бие бүрэлдэхүүнд 51 удаа үүрэг хүргүүлэн биелэлт, үр дүнг тооцон ажиллалаа. Тус цагдаагийн газрын даргын 2022 оны А/43 дугаартай тушаалаар захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулан тасаг, албадын ахлахуудаас бүрдсэн “Сахилга ёс зүйн дэд зөвлөл”-өөс цагдаагийн газрын алба хаагчдын сахилга ёс зүйг дээшлүүлэх, бууруулах чиглэлээр 17 заалт бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэв. Мөн алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулах, өргөсөн тангарагтаа үнэнч байж, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэж, шударга, зарчимч, ёс зүйтэй, шуурхай, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Итгэлцлийн гэрээ”-г Цагдаагийн газрын дарга, тасгийн дарга нар алба хаагч нартай байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдах, өртөж хохирох, сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Харилцаа-хандлага”, “Удирдлагын манлайлал”, “Сахилга ёс зүйн аян”, “Хариуцлагатай алба хаагч” аян зэрэг нөлөөллийн арга хэмжээ, албаны сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж, дүнг нэгтгэж ажиллалаа. Цагдаагийн газраас 2022 онд улирал бүр “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг сумдын цагдаагийн тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг хамруулан онлайн цахим хэлбэрээр зохион байгуулж, Цагдаагийн газрын удирдлагаас алба хаагчдын гаргасан зөрчлийн шинж байдалд тулгуурлан сургалтын хэлбэрүүдийг сонгон мэргэшүүлэх, дадлагажуулах, мэдлэг олгох, гоо зүй, соёлын хичээл сургалт, зөрчил гаргасан алба хаагчдаар бие бүрэлдэхүүнд алдаан дээрээсээ суралцах сургалтуудыг оруулж, тэдний гэр бүлийн гишүүн бүртэй уулзаж сэтгэлзүйн зөвлөгөө өгүүлж, зөрчил дутагдалгүй ажилласан алба хаагчдыг сайшаах, сайн чанаруудыг нь хамт олонд сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Зөвлөгөөний үеэр зөрчил дутагдал гаргасан алба хаагч бүрээс дахин давтан зөрчил гаргахгүй байх “Баталгаа” гаргуулан авч, зөрчил дутагдал гаргаагүй алба хаагчдыг хамт олны өмнө сайшааж, Цагдаагийн газрын даргын “Талархал” гардуулан ажилласнаар алба хаагчдаас гаргах сахилга, дэг журмын зөрчлүүд буурсан эерэг хандлага гарч байгаа юм.

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засаж арилгах, ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, төсвийн

хөрөнгийг зөв зохистой зарцуулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр албан даалгавар 9, зөвлөмж, зааварчилгааг 12, газрын даргын үүрэг, ажлын чиглэл 72-ийг албан бичгээр хүргүүлж, биелэлт, үр дүнг долоо хоног бүр тооцож ажиллалаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, 14.5, 15 дугаар зүйлийн 15.1.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Сахилгын шийтгэл ногдуулах /код 914/ журам”-ын 914.5.2, 914.5.2б-д заасныг хэрэгжүүлэх, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах, алба хаагчдын албандаа хандах хандлагыг эерэг болгож, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, харилаа, хандлагыг өөрчлөх зорилгоор бүхий “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” 1 сарын аяныг зохион байгуулж, үр дүнг тооцов.

Цагдаагийн газрын “Сахилга ёс зүйн дэд зөвлөл”-өөс 7 хоног бүрийн “Даваа” гаригт сахилга, ёс зүйн чиглэлээр бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийж алба хаагчдаас гаргаж буй нийтлэг зөрчлийг бууруулах нөлөөллийн ажлуудыг явуулж, нийт алба хаагчдыг насны ангиллаар 4, энгийн ажилчид, эмэгтэйчүүдийн зөвлөлийг тус бүр Цагдаагийн газрын даргын зөвлөлийн гишүүд уулзалт хийж санал хүсэлтийг хүлээн авч, үр дүнг тооцон цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаарын 28-ны өдрийн А/201 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, дэд даргын 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 3/284 дугаартай үүргийн хэрэгжилтийг хангах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Дүрэмч ажиллагаа-бидний соёл 2022” 45 хоногийн аян, Мөн алба хаагчдыг харилцааны соёл, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, сахилга ёс зүйн алдаа дутагдал, гаргахгүй ажиллах зорилгоор 30 хоногийн хугацаанд “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” зэрэг аянуудыг зохион явуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн газрын удирдлагаас ажлын үр дүнг дээшлүүлэх, сахилга ёс зүйг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, эрэн сурвалжлах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлыг боловсронгуй болгоход дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад гаргасан бүтээлч санал, санаачилгыг дэмжиж урамшуулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачилгыг дэмжих” /код 116/-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Шинэ санаачилга-Тэргүүн туршлага” болзолт уралдааныг санаачлан болзол шалгуурыг даргын зөвлөл болон хамт олны хурлаар хэлэлцэж батлуулан, бие бүрэлдэхүүний дунд зарлаж үр дүнг тооцож ажиллав.

Уралдааны хүрээнд 12 алба хаагч ажлын үр дүнгээр шалгарч “Батламж” сарын үндсэн цалингийн 20 хувиар урамшуулж ажиллав. Тайлант хугацаанд тасаг албад, алба хаагчдын албаны шуурхай бэлэн байдал, цагдаагч ажиллагаа, ажлын хариуцлага, сахилга ёс зүйг дээшлүүлэх, ажлын үр дүн, шат дараалсан хариуцлагыг өндөржүүлж “Захиргааны удирдлагын тасгийн жолооч, алба хаагчдын ажлын хариуцлага сахилга, ёс зүйг сайжруулах сарын аян”, “Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлье” 45 хоногийн аян, “Сахилга ёс зүй, дэг журмыг сайжруулах 60 хоногийн аян”, “Дүрэмч ажиллагааг дээшлүүлэх” зэрэг 4 нэгдсэн арга хэмжээ, “Сахилга ёс зүйн зөвлөгөөн”, “Гэр бүлийн зөвлөгөөн” нэгдсэн арга хэмжээг төлөвлөгөө удирдамжийн дагуу зохион байгууллаа.

Алба хаагчдын болон тэдний ар гэрийнхний хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж, санал хүсэлтийг сонсох, алба хаагчдын ажлын цаг ашиглалтын байдлыг сайжруулж зөрчил гаргагчдад хариуцлага хүлээлгэх, албадын дарга ахлахуудын гүйцэтгэдэг ёс журмын эргүүлийн чанар, үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын албаны шуурхай бэлэн байдал, цэрэгжилт жагсаалч байдал, ажил үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшинг шалгах, ахиулах, ажлын хэсэг, эргүүл, жижүүр, харуул болон эрүүлжүүлэх баривчлах байр, түр саатуулах байрны үйл ажиллагааг шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг засуулах зэргээр иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээнд шуурхай, хуульч ажиллагааг хэвшүүлж, хүнд суртлыг багасгахад чиглэгдсэн ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цагдаагийн газрын даргын 2022.05.20-ны А/50 дугаар тушаалаар Захиргааны удирдлагын тасгийн даргаар ахлуулсан 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй “Сахилга ёс зүйн алба”-ыг шинэчлэн байгууллаа.

“Сахилга ёс зүйн алба” нь 6 удаа хуралдаж, сахилга ёс зүйн зөрчил гаргасан 81 алба хаагч /давхардсан тоогоор/-ийн талаар хэлэлцэж, 20 алба хаагчид дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг сануулж, 3 алба хаагч буруугүй болох нь тогтоогдсон тул хариуцлага тооцох үндэслэлгүй гэж шийдвэрлэж, 81 алба хаагчид ажлын үр дүнгээр цалинг хасах, 42 алба хаагчид нөлөөллийн арга хэмжээ авч шийдвэрлэв.

Цагдаагийн газрын тасаг албадын дарга, ахлахууд нь газрын дотоод журмын дагуу “Ёс журам сахиулах эргүүл”-ийн үүргийг хуваарийн дагуу 24 цагаар гүйцэтгэж алба хаагчийн сахилга ёс зүй зөрчсөн, цагдаач жагсаалч байдал, албаны шуурхай бэлэн байдал хангаагүй 16 офицер, 18 ахлагчийн 34 зөрчлийг илрүүлэн 20 зөрчлийг газар дээр нь засуулж, 8 зөрчлийг дахин давтахгүй байх талаар баталгаа гаргуулж, 3 зөрчлийг сахилга ёс зүйн албаны хурлаар хэлэлцүүлж, 1 зөрчлийг газрын даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж шийдвэрлэжээ. Сахилга ёс зүйн дутагдлын шалтгаан нөхцөлийг судалж “Алба хаагчдын сахилга ёс зүйг ажлын бүтээмжийг дээшлүүлэх” сэдэвт сахилга хариуцлагын зөвлөгөөнийг тасаг албадын хэмжээнд 7, газрын хэмжээнд 4 удаа хийж зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтэд “Сахилга ёс зүйн алба” хяналт тавин ажиллаж байна.

Мөн зөрчил гаргасан 4 алба хаагчийг ЦЕГ-ын Сургалтын нэгдсэн төвд ёс зүйн төлбөртэй сургалтад хамруулаад байна. Цагдаагийн газрын криминологи судалгааны багаас алба хаагч нарын гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох дүгнэлт хийж, тухайн дүгнэлтэд тулгуурлан зөрчил гаргасан алба хаагч нарт ганцаарчлан зааварчилга зөвлөмж өгч, алдаагаа дахин давтахгүй түүний гаргасан алдааг бусад алба хаагч нарыг гаргуулахгүй байх зорилгоор “Алдаанаас суралцах” сургалтыг тогтмол зохион байгууллаа.

Газрын удирдлагаас алба хаагчидтай 2022 оны үр дүнгийн гэрээг байгуулж, алба хаагчийн сахилга, ёс зүйг сайжруулах, өргөсөн тангарагтаа үнэнч байж, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэж, шударга, зарчимч, ёс зүйтэй, шуурхай, мэргэшсэн үйл ажиллагааг хэвшүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “ИТГЭЛЦЛИЙН ГЭРЭЭ”-г тус цагдаагийн газрын дарга цагдаагийн газрын 187 алба хаагч нэг бүртэй байгуулан ажиллалаа.

Удирдлагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд энэ онд эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон алба хаагч байхгүй ба энэ онд нийт 8 сахилга, ёс зүйн зөрчил бүртгэгдэн, 8 алба хаагч сахилгын арга хэмжээ тооцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн тоо 2 нэгжээр буюу 20 хувиар өсөж, арга хэмжээ авагдсан алба хаагчийн тоо 10 буюу 20 хувиар тус тус буурсан байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 87.5 хувийг офицер, 12.5 хувийг ахлагч бүрэлдэхүүнээс гаргасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчийн тоог нийт бие бүрэлдэхүүний тоотой харьцуулахад 4.7 хувийг эзэлж байна.

Тайлангийн хугацаанд сахилга хариуцлагын зөвлөгөөнийг улирал бүр, тасаг албад сар бүр сахилга хариуцлагаа хэлэлцэж, алба хаагчдын гаргасан зөрчлийн шинж байдалд тулгуурлан сургалтын хэлбэрүүдийг сонгон мэргэшүүлэх, дадлагажуулах, мэдлэг олгох, гоо зүй, соёлын хичээл сургалт, зөрчил гаргасан алба хаагчдаар бие бүрэлдэхүүнд алдаан дээрээсээ суралцах сургалтуудыг оруулж, тэдний гэр бүлийн гишүүн бүртэй уулзаж сэтгэлзүйн зөвлөгөө өгүүлж, зөрчил дутагдалгүй ажилласан алба хаагчдыг сайшаах, сайн чанаруудыг нь хамт олонд сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласнаар цагдаагийн газрын алба хаагчдаас гаргасан зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар буурсан сайн үзүүлэлттэй байна.

Б. Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр дотооддоо зохион байгуулсан сургалт.

Тус Цагдаагийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/02 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”, ЦЕГ-н дэд даргын энэ оны 3/30 дугаартай “Үүрэг, ажлын чиглэл”-ийн дагуу Цагдаагийн газрын даргын 2022 оны А/51 тоот тушаалаар Сургалтын багийг 11 хүний

бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, цагдаагийн газрын алба хаагчдад 2022 онд зохион байгуулах нэгдсэн болон үлгэрчилсэн төлөвлөгөө боловсруулан "Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт"- 25, "Алба хаагчийг хөгжүүлэх сургалт" 15, "Дадлагажуулах сургалт"-12, "Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалт" -4, "Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах сургалт" -7, танхимын сургалт 24, дадлага 34, зайн болон цахим 54, нийт 114 цагийн сургалтын цаг сэдвийг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулж, нийт давхардсан тоогоор 19732 алба хаагчдыг сургалтад 96.7 хувьтай хамруулав.

Алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн болон мэргэжлийн холбогдолтой сургалтуудыг 7 хоног бүрийн "Лхагва", нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээнийг зохион байгуулж, албаны спортыг хөгжүүлж, албаны бэлтгэлийг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой сургалтыг "Пүрэв" гарагуудад тогтмол явуулж ажиллалаа.

Дотоод хэргийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилд шинээр 1 алба хаагч элсэн орж, "Цагдаагийн ажил эрх зүй" мэргэжлийн эчнээ сургалтад 4 алба хаагч суралцаж байгаа ба "Боловсрол соёл эрх зүйн" дээд сургуулийн эчнээ сургалтад шинээр 1 алба хаагчийг суралцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн хамрууллаа

Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулагдсан "Архив, албан хэрэг хөтлөлт", "Сошиал орчинд ажиллах, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй харилцах ур чадварыг дээшлүүлэх нь" сургалтууд, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн иргэдийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх "Англи хэлтэй Дорнодчууд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Access" сургалтын төвтэй хамтран төрийн албан хаагчдад мэдлэг олгох англи хэлний сургалтад 2 алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр хамруулав. Мөн Хэнтий аймагт зохион байгуулагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх "Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах", Дотоодын цэргийн штабаас зохион байгуулсан англи хэлний А2 түвшний 1 сарын сургалтад 1 алба хаагчийг суралцуулж, мэргэшүүллээ.

Алба хаагчдад явуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт, үр дүн 98.6 хувийн хэрэгжилттэй хангагджээ.

Алба хаагчдын мэдлэг боловсрол, ажлын ур чадварыг тодорхойлох, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажилдаа хандах хандлагыг өөрчлөх, урам зоригийг сэргээх зорилгоор алба хаагчдын дунд "Шилдэг удирдагч", "Шилдэг хэсгийн төлөөлөгч", "Шилдэг хэсгийн байцаагч", "Шилдэг мөрдөгч", "Шилдэг харуулчин" "Шилдэг ахлагч", "Шилдэг жолооч" зэрэг ажил мэргэжил, ур чадварын тэмцээнүүдийг зохион явуулж шалгаруулахдаа галт зэвсэг, тусгай мэх хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор галт зэвсгийн задаргаа, буудлагын төрлөөр, сумдын хэсгийн төлөөлөгч нараас мал зүслэх, им тамга нэрлэх, морь унах, эмээллэх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, жолоодлого зэрэг төрлүүдээр алба хаагчдаас шалгалт авч дүгнэлээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах, офицер бүрэлдэхүүний манлайлал, албаны шуурхай бэлэн байдал, ажлын хариуцлага, хувь хүний сахилга ёс зүйн байдалд дүгнэлт хийх, зөрчил дутагдлыг засах, засуулах, ажлын үр дүн, шат дараалсан ажлын хяналт, алба хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор тус Цагдаагийн газарт "Офицер бүрэлдэхүүний нэгдсэн сургалт, зөвлөгөөн", "Ахлагч бүрэлдэхүүний" зөвлөгөөнийг тус тус цагдаагийн газрын хурлын танхимд зохион байгуулагдлаа.

Зөвлөгөөний үеэр төрөл мэргэжлийн албадаас сургагч, багш нарыг оролцуулан "Төрийн албаны /шинэчилсэн найруулга/ тухай хууль, нийгмийн баталгаатай холбоотой дүрэм журам", "Дүрэмч ажиллагаа, жагсаалын үзлэг, албаны бэлэн байдлын талаарх мэдээлэл, "Нийгмийн харилцаан дахь гэр бүл", "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, түүнд анхаарах асуудал", "Төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих асуудал", "Ахмад ажилтнуудын ажлын арга барил, туршлага", "Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал", "Алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага", "Хэрэг бүртгэх мөрдөн байцаалтын чиглэлээр тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнээс гарах арга зам", "Байгууллагын хөгжил манлайлал", "Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс зохион байгуулж буй арга хэмжээ" сэдвээр тус тус сургалт явуулан мэдээлэл хийж, нийт 84 офицер алба хаагчид хамрагдсан байна.

Хөдөө сумдад ажиллаж байгаа алба хаагч нарт улирал бүр албаны сургалтыг CD/DVD/ хэлбэрээр гарын авлага, ном, видео хичээлийг бэлтгэн хүргүүлж, бие даан судлуулан үр дүнг тооцож байна. Албаны сургалтыг шинэлэг арга хэлбэрээр явуулах зорилготойгоор 13 сумдын хэсгийн төлөөлөгч нарын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг “Чойбалсан” суманд дадлага, сургалтыг зохион байгуулав.

“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын соён гэгээрүүлэх ажлын хүрээнд ажлын байран дахь стрессийг бууруулах зорилгоор “стресс хөтөлбөр”, “Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх” аяны хүрээнд удирдах албан тушаалтнуудаас бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийх хуваарийг гарган батлуулан 2 удаа сургалт зохион байгуулав.

Алба хаагчдад явуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт, үр дүн 98.6 хувийн хэрэгжилттэй хангагджээ.

В. Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ.

Цагдаагийн газраас Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны А/20 дүгээр тушаалаар батлагдсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулах “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ журам, Цагдаагийн газрын даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар алба хаагчдын дунд соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах Дотоодын цэргийн захирагчаар ахлуулсан “Спорт хамтлаг” ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, тушаалын хавсралтаар “Тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээ”, “Биеийн тамир спортын уралдаан тэмцээн”, “Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ”-ний хуваариудыг батлан 2 бүлэг 18 заалттай ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Алба хаагчдын харилцааны соёл, сахилга ёс зүйг төлөвшүүлэх, “Алба хаагчдын албан тушаалын тодорхойлолт”-д заасан зорилго, зорилтыг хангахад чиглэсэн төрөл мэргэжлийн болзолт уралдаануудыг зарлан хэрэгжүүлж цагдаагийн газрын даргын тушаалаар ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилтыг хангахад чиглэсэн, алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээж “Шилдэг жолооч”, “Шилдэг хэсгийн төлөөлөгч”, “Шилдэг хэсгийн байцаагч”, “Шилдэг мөрдөгч”, “Шилдэг харуулчин” “Шилдэг ахлагч” ур чадвар, ажил мэргэжлийн уралдаан тэмцээн, “Тэргүүний соёлч боловсон офицер, ахлагч, эмэгтэй алба хаагч”, “Шинэ санал санаачилга” болзолт уралдаануудыг зохион явуулж дүгнэн шагнаж урамшуулав.

Цагдаагийн газрын удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн газраас санаачлан “Удирдлагын манлайллыг дээшлүүлье” 45 хоногийн аян, “Шилдэг удирдагч” ажил мэргэжлийн уралдааныг зарлан явуулж, нийт тасаг, хэсгийн дарга, ахлах албан тушаалтан нарыг хамруулж, хууль эрх зүй, сэтгэн бодох, гадаад хэл, компьютер сүлжээний мэдлэг сорих зэрэг тест болон бие бялдрын шалгалтуудыг авч дүгнэв.

Алба хаагчдын харилцааны соёл, сахилга ёс зүйг төлөвшүүлэх, “Алба хаагчдын ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтод заасан зорилго, зорилтыг хангахад чиглэсэн төрөл мэргэжлийн болзолт уралдаануудыг зарлан хэрэгжүүлж ажиллав. Цагдаагийн газрын алба хаагч нарын илтгэх ур чадварыг сайжруулах, харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор 7 хоног бүрийн Даваа, Баасан гаригт хуваарийн дагуу тасаг, албадаас зохион байгуулсан ажил, улс оронд болж өнгөрсөн онцлог үйл явдал, харилцаа ёс зүй, биеэ зүй зохистой авч явах, тэвчээртэй байх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг 5 минутын мэдээллийг бэлтгэж нийт 93 удаа бие бүрэлдэхүүнд хүргэж ажиллав. Мөн цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс дотоодод зохион байгуулагдсан ажил, арга хэмжээ, уралдаан тэмцээний талаар “СУРВАЛЖИЛГА” мэдээг бэлтгэж 7 хоног бүрийн “Даваа” гарагт, нийт 24 удаа бие бүрэлдэхүүнд танилцуулан ажиллаж байна.

Цагдаагийн газрын хэмжээнд “Хувь хүний төлөвшил” аян, “Нэг сэтгэл, нэг соёл” уриатай “Өглөөний цайтай ажлын өдөр”, “Нэг өдөр нэг ажил”, “Шинэ санал санаачилга”, “Буянтай буурал”, “Хэрлэн голын жавар”, “Эх хэлээрээ цэвэр, зөв бичиж суръя”, “Хорт зуршил-Эрүүл бие” аяны хүрээнд “Дугуйт болон явган аялал”, “Удирдлагын манлайллыг дээшлүүлье”, “Хэрвээ би удирдах албан тушаалын алба хаагч байсан бол”, “Илүүдэл жин баяртай”, “Гэр бүлээ сонсьё”, “Долоо хоногийн сурвалжилга”, “5 минутын мэдээлэл” зэрэг аян, оюуны чадамж, бичгийн болон илтгэх ур чадварыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор ахлагч бүрэлдэхүүний дунд “Номтой нөхөрлөө” аян, мэдээлэл сурталчилгааны 201, соёл хүмүүжлийн 82, нийт 282 ажил арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 41029 алба хаагч хамруулан зохион явууллаа.

Цагдаагийн газрын алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн болон мэргэжлийн холбогдолтой сургалтуудыг 7 хоног бүрийн “Лхагва” гарагт, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн зохион байгуулж, албаны спортыг хөгжүүлж, албаны бэлтгэлийг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой сургалтыг “Пүрэв” гарагт тогтмол явуулж хэвшүүлээ.

Тасгийн дарга, ахлахуудын дунд “Удирдлагын манлайллыг дээшлүүлье” 45 хоногийн аяныг хууль эрх зүй, сэтгэн бодох, гадаад хэл, мэдээллийн сан, эсээ бичлэг, шийдвэр гаргах ур чадвар, бие бялдар зэрэг төрлөөр шалгалт авч дүгнэв. Цагдаагийн газрын алба хаагчдын дунд “Дүрэмч ажиллагаа” сарын аян өрнүүлж, алба хаагчдын цэрэгжилч, жагсаалч байдлыг сайжруулах зорилгоор жагсаалын бэлтгэлийг өдөр тутам хуваарийн дагуу зохион байгуулж ажиллалаа.

Сахилга, ёс зүйн байдал, ажлын үр дүнгээрээ идэвх санаачилга гарган, хамт олноо хошуучлан ажилласан 14 алба хаагч, хамт олноос нь зөрчил дутагдал заагдаагүй 2 тасгийн дарга нарт “Талархлын хуудас” гардуулж, алба хаагчдын манлайлал, тэдний сайн талыг сурталчлах зорилгоор үлгэр дуриалалтай ажиллаж буй 10 офицер, 10 ахлагчийн “Сайн туршлага”-ыг алба хаагчдад танилцуулан сурталчилж ажиллалаа. Мөн Цагдаагийн газрын тасаг тус бүрээс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ нэр төртэй биелүүлж, сахилга, ёс зүй, албандаа хариуцлагатай хандаж, хамт олноо хошуучлан ажиллаж, байгууллагын үйл ажиллагаанд шинэлэг санааг дэвшүүлэн, арга хэмжээнд идэвхтэй оролцсон алба хаагчдыг дүгнэн, нийт 10 алба хаагчийг “Хариуцлагатай алба хаагч”-аар шалгаруулж, “Талархал”, дурсгалын зүйлсээр шагнаж урамшуулав.

Спортын уралдаан тэмцээнийг тухай бүр зохион байгуулснаар алба хаагчдын хүмүүжил, танин мэдэхүй дээшилж, албаараа бахархах, илтгэл үнэмшил нэмэгдсэн үр дүнтэй ажил боллоо. Алба хаагчдын дунд соён гэгээрүүлэх, тэмцээн уралдаан зохион байгуулах 2 бүлэг 18 заалттай төлөвлөгөөний хэрэгжилт 98.7 хувийн гүйцэтгэл 4.8 баллын үнэлгээтэй дүгнэн ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлэв. Алба хаагчдын биеийн дархлааг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрын түвшинг нэмэгдүүлэх ажил, арга хэмжээг 100 хувь нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарч байна.

Цагдаагийн байгууллагыг олон нийтэд таниулах, сурталчлах, иргэдэд тухай байгууллагын мэдээлэл нээлттэй ил тод байх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор цагдаагийн газрын “Dornod.police.gov.mn” цахим хуудас, фейсбүүк хуудас болон цагдаагийн газрын иргэд хүлээн авах танхимд авилгаас урьдчилан сэргийлэх ил тод байдлын самбар шинээр хийж байршуулан авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж, иргэд олон нийтийг нэгдэхийг урьж, авлигын эсрэг хууль тогтоомжийн чиглэлээр мэдээ мэдээллийг сурталчлан ажиллаж байна.

Тус цагдаагийн газраас “Цагдаа дотоодын цэргийн анги байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 14 заалт бүхий салбар төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр цагдаагийн газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллалаа.

Цагдаагийн газрын удирдах албан тушаалтнаас алба хаагчдын ажлын хүндрэл бэрхшээл, санал шүүмжлэл, анхаарах асуудлын талаар харилцан ярилцаж, санал бодол, сэтгэгдлийг сонсох, алба хаагчдад өдөр тутмын үйл ажиллагаандаа анхаарах зүйлийн зөвлөмж, зааварчилга өгөх, удирдах ажилтан, алба хаагчдын дунд эерэг таатай уур амьсгалыг бүрдүүлж, тасаг хэсэг, алба хаагчидтай “Алба хаагчаа сонсьё” арга хэмжээг энэ онд 2 удаа зохион байгуулж хуваарийн дагуу давхардсан тоогоор 384 алба хаагчтай уулзаж дэвшүүлсэн санал хүсэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллав. Мөн алба хаагч нарыг насны онцлог, тэдний хүсэл сонирхол, ар гэр ахуй амьдралтай танилцах, шинэ санал санаачилгыг дэмжих чиглэлээр 18-25 нас, 26-31 нас, 32-36 нас, 37-оос дээш нас, цагдаа эмэгтэйчүүд гэсэн 5 ангилалд хуваан тасаг албадын дарга нараар ахлуулсан алба хаагчид уулзаж санал хүсэлтийг сонсон тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар шийдвэрлэж ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл

мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөр, Улсын хэмжээнд зохион явагдаж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян”-нийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд алба хаагчдын ажлын байран дахь эрсдэлийг бууруулах болон үйлдвэрлэлийн осол, хөдөлмөр хамгаалал, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Алба хаагчийн эрүүл, аюулгүй ажлын байр-2022” өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр “Аюулгүй ажиллаж - Амжилтаараа тэргүүлцгээе” урин дор зохион байгуулагдаж буй өдөрлөгийн арга хэмжээнд ХАБЭА-ийн мэргэжилтэн Д.Ган-Эрдэнэ “ХАБЭА-н тухай хуулийн танилцуулга, байгууллагын дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам, дүрэм, ажилтан болон ажил олгогчийн эрх үүрэг хариуцлага”, Онцгой байдлын газраас “Объектын гал унтраах, гал түймрийн нөхцөл байдал”, Мэргэжлийн хяналтын газраас “Үйлдвэрлэлийн ослын шалтгаан, үр дагавар”, Аймгийн Улаан загалмайн хорооноос “Анхны тусламж үзүүлэх” сэдвүүдээр тус тус танхимын болон дадлага сургалтын үйл ажиллагааг зохион байгуулав.

Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, 14.5, 15 дугаар зүйлийн 15.1.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Сахилгын шийтгэл ногдуулах /код 914/ журам”-ын 914.5.2, 914.5.2б-д заасныг хэрэгжүүлэх, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авах, цагдаагийн албаны дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах, алба хаагчдын албандаа хандах хандлагыг эерэг болгож, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, харилаа, хандлагыг өөрчлөх зорилгоор бүхий “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” 1 сарын аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд цагдаагийн газрын Сахилга ёс зүйн дэд зөвлөл 7 хоног бүрийн баасан гарагт хуралдаж цагдаагийн газрын ёс журмын жижүүр, удирдах алба хаагчдын рапортад зөрчил заагдсан алба хаагчдыг хурлаар хэлэлцэн зохих арга хэмжээг хэрэгжүүлэн цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд “Сахилга ёс, зүйн байдал”-д дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг танилцуулж ажиллалаа.

Тус Цагдаагийн газраас Дотоодын цэргийн түүхт 100 жилийн ойг угтсан ажлын хүрээнд 2022 оны төв орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн удирдах ажилтны сургалт зөвлөгөөний үеэр Цагдаагийн ерөнхий газрын дэд даргаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соён гэгээрүүлэх ажил” /код 940/-ыг удирдлага болгон алба хаагчдын дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, тамирчин алба хаагчдын алдрыг таниулан сурталчлах, алба хаагчдын спортоор хичээллэх дур сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” аяны хаалтын ажиллагаа болох “Бидний бахархалт тамирчид” спортын цол зэрэгтэй алба хаагчдыг алдаршуулах өдөрлөгийн арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

Арга хэмжээг МҮОНРТелевизийн ахлах редактор Д.Батжаргал урилгаар хөтөлж, спортын цол зэрэгтэй алба хаагчдын амжилтыг танилцуулж, алдаршууллаа. Цагдаагийн газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу алба хаагчдын спортын замналын талаарх сурвалжлаг, видео нэвтрүүлгийг бэлтгэн, нийт бие бүрэлдэхүүнд сонирхуулж, Монгол Улсын гавьяат жүжигчин Т.Ганзоригт ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн байна. Мөн үеэр Цагдаагийн газрын хамт олон, алба хаагчдын гавьяа шагналаас бүрдсэн “Алдарын булан”-г шинээр байгуулав

Алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилготой “Дүрэмч ажиллагаа бидний соёл 2022” сэдэвт 45 хоногийн аяныг 45 хоногийн хугацаатай зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллалаа.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үсч хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд алба хаагчдын чөлөөт цагийг зөв болсон өнгөрүүлэх, сахилга ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Намар эрүүл цагдаа-гэр бүл” өдөрлөгийн үйл ажиллагааг “Энх зуслан” амралтын бааз дээр Цагдаагийн газрын хамт олон, гэр бүлийн дунд зохион байгууллаа. Өдөрлөгөөр тасгууд мэндчилгээ, хүүхдийн гар зургийн уралдаан, дартс шидэлт, холимог гар бөмбөгийн тэмцээн, хөгжөөнт буухиа тэмцээний төрлөөр хурд хүч, авхаалж самбаа, ур чадварын тэмцээн уралдааныг зохион явуулав.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/112 тушаалаар батлагдсан “Хорт зуршлаас татгалзаж-Сайнаар үлгэрлэе”

нөлөөллийн аян, “Манай хамт олон” арга хэмжээний хүрээнд шинээр томилогдсон ахлагч бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах зорилгоор “Дэд ахлагчийн өдөр” арга хэмжээг 7 хоногийн хугацаатай зохион явуулав. Арга хэмжээний хүрээнд алба хаагчдын албаны бэлэн байдлыг шалгах, жагсаалын бэлтгэл хийх дадлага сургалтыг Зэвсэгт хүчний 327-р ангийн салааны ахлагч а/а Э.Балжиннямтай хамтран зохион байгууллаа. Мөн олон жил үр бүтээлтэй ажиллаж буй цагдаагийн ахлах ахлагч С.Энхтулга, Э.Бат-Эрдэнэ нар ахлагч нарт зориулж, албандаа хандах хандлагаа зөв төлөвшүүлэх, үүрэгт ажлаа хариуцлагатай, нэр төртэй ажиллахад өөрсдийн дадлага туршлагаа хуваалцаж, харилцан ярилцлаа. Цагдаагийн газрын удирдах бүрэлдэхүүнээс алба хаагч нартай уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ажиллалаа.

“Байгууллагын соёл, эрүүл мэнд сэтгэл зүйг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, “Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах” Цагдаагийн газрын алба хаагчдын ахуй амьдралтай танилцах, судлах, Цагдаагийн байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах, гэр бүлийн харилцаа хандлагыг тодорхойлох замаар тэдний гэр бүлийн гишүүдтэй уулзаж санал хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Гэр бүлээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 116 гэр бүлийн гишүүн хамрагдсан ба цагдаагийн газраас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээтэй танилцаж ажиллав. Тус арга хэмжээний хүрээнд гэр бүлийн гишүүдэд цагдаагийн газрын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Дорнод цагдаа-2021 сэтгүүлийг “Ил захидал”-ын хамт өгч, Арга хэмжээг 2 хэсгээр зохион байгуулсан ба алба хаагч, гэр бүлийн гишүүдийн нөхөрсөг, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Воллейбол”-ын тэмцээн зохион явуулж, тэмцээнд 9 багийн 62 гэр бүлийн гишүүн оролцуулан гэр бүлийн гишүүдийн дунд азтан шалгаруулах арга хэмжээг зохион байгууллаа.

Цагдаагийн газраас “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Хүүхэд бидний ирээдүй” арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Мөрөөдлийн ордон” тоглоомын төв дээр зохион явууллаа. “Шинэ суваг” телевизийн “Хүүхдийн цаг” хөтөлбөрийн хүүхдүүд урлагийн хэсэгчилсэн тоглолт сонирхуулав. Мөн хүрэлцэн ирсэн хүүхдүүдийг “Цайллагын танхим”-д амттанаар дайлж, гарын бэлэг гардуулан, бүх тоглоомын хэрэгсэл дээр тоглууллаа. Арга хэмжээний үеэр хүүхэд, багачуудын дунд “Биднийг хамгаалах цагдаа” сэдвээр уран зураг, “Цагдаа миний бахархал” сэдвээр зохион бичлэг болон шүлгийн уралдаан тэмцээн зохион явагдаж, Тэргүүн болон Дэд байранд шалгарсан хүүхдүүдийг “Өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав. Мөн урлаг, спортоороо бусдыгаа манлайлж буй алба хаагчдын хүүхдүүдээс 3 хүүхэд Монголын хүүхдийн ордны “Эрдэн алтан” медаль, 4 хүүхэд “Эрдэм мөнгөн” медалиар тус тус шагналаа.

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Улсын хэмжээнд зохион явуулж буй “Намайг алгас” арга хэмжээний хүрээнд алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтач уур амьсгалыг бүрдүүлэх, соёл гоо зүйн боловсролыг дээшлүүлэх, нийтийн бүжгийн үр нөлөө, ач холбогдлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Цагдаагийн газрын “Цагдаа-эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс алба хаагчид, тэдний гэр бүлийн дунд “ХЭН САЙН БҮЖИГЛЭХ ВЭ” бүжгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соён гэгээрүүлэх ажил /код 940/ журам”, хэрэгжилтийг хангах, алба хаагчдын ном ашиглалтыг сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номыг бүтээлчээр уншиж оюуны чадамж, бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх, сэтгэлгээ хандлагыг өөрчлөх зорилгоор “Утастай биш номтой нөхөрлөө” аяныг зохион байгуулан уншиж судалсан номын талаар тэмдэглэл хөтлөн, бие бүрэлдэхүүнд уншсан номын түүврийг танилцуулах арга хэмжээг зохион явуулав.

Цагдаагийн газрын 2022 оны сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Номтой нөхөрлөө” ажил арга хэмжээг Цагдаагийн газрын хурлын зааланд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит аймгийн төв номын сангийн алба хаагчтай хамтран “Ном хожьё” 30 номын уналт тэмцээнийг зохион явууллаа. Тус арга хэмжээнд Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний дунд мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 30 номын уналт танин мэдэхүйн хөгжөөнт цэнгээнт тэмцээнийг 8 тасгийн нийт 32 алба хаагч хамрагдан идэвх санаачилгатай оюун ухаан, мэдлэг ур чадвараа уралдуулан оролцсон. “Ном хожьё” 30 номын уналт тэмцээнийг 50 саяын уналт

телевизийн шоу нэвтрүүлгийн дүрмийн дагуу нийт 8 асуулттай хасагдах журмаар зохион байгуулагдав.

Цагдаагийн газрын удирдлагаас ажлын үр дүнг дээшлүүлэх, сахилга ёс зүйг сайжруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, эрэн сурвалжлах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлыг боловсронгуй болгоход дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад гаргасан бүтээлч санал, санаачилгыг дэмжиж урамшуулах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачилгыг дэмжих” /код 116/-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Шинэ санаачилга-Тэргүүн туршлага” болзолт уралдааныг санаачлан болзол шалгуурыг даргын зөвлөл болон хамт олны хурлаар хэлэлцэж батлуулан, бие бүрэлдэхүүний дунд зарлаж үр дүнг тооцож ажиллав. Энэ уралдааны хүрээнд 4 алба хаагч ажлын үр дүнгээр шалгарч “Батламж” сарын үндсэн цалингийн 20 хувиар шагнагдсан юм.

Алба хаагчдыг нөхөн сэргээх сувилалд хөнгөлөлттэй буюу төлбөргүйгээр эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байдлыг харгалзан “Сүүж-Уул” сэргээн засах амралт сувилалд амраах 42 алба хаагчийн судалгааг гарган өнөөдрийн байдлаар тус цагдаагийн газраас 32 алба хаагч, гэр бүлийн 1 гишүүний хамт хамруулж, сувиллын зардалд хөнгөлөлт үзүүлэн 3.168.000 төгрөгийн зардлыг шийдвэрлэж өгөв.

Цагдаа эмэгтэйчүүдийн зөвлөлөөс цагдаагийн газрын алба хаагчдын гэр бүлийн гишүүдээс “Алба хаагч тэдний гэр бүлийн дунд тодорхой ажлуудыг үе шаттай зохион байгуулах, оролцоог нэмэгдүүлэх” гаргасан санал хүсэлтийг дэмжих зорилгоор “Гэр бүлийн зөвлөгөөн” өдөрлөг, урлаг уран сайхны арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд цагдаагийн алба хаагчийн 90 гэр бүлийн гишүүд оролцлоо.

Мөн алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн дунд “Гар бөмбөг”, “Дартс”-ны тэмцээнийг тус тус зохион байгуулж азтан тодруулах сугалааг явуулж нэг өдрийг алба хаагчдын гэр бүлийн гишүүдийн хамт үдийн зоог, тэмцээн уралдаан, урлагийн арга хэмжээтэй зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Соён гэгээрүүлэх ажил” /код 940/ журам, “Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах” ЦБҮАЖ /код 941/, мөн даргын А/135 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл цагдаа” хөтөлбөр, цагдаагийн газрын 2022 онд бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулагдах “Соён гэгээрүүлэх ажил”-ын төлөвлөгөөний хүрээнд спортын тэмцээн уралдаануудыг зохион байгуулж байна.

Алба хаагч болон тэдний гэр бүлийн дунд “Эрүүл зөв хооллолт”-ын сургалт, өдөрлөгийг тасаг албадын дунд зохион явуулж, алба хаагчид өөрсдийн хийсэн эрүүл зөв хоолоор ширээ засаж бусдад сурталчлах, амтлагаа явуулах зэрэг тэмцээнийг зохион байгууллаа.

Цагдаагийн газрын хэмжээнд алба хаагчдын ар гэр, ахуй амьдралтай танилцах, санал хүсэлтийг хүлээн авах, сонсох зорилгоор “Бид нэг гэр бүл” нэгдсэн арга хэмжээг зохион явуулж, арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газрын нийт 185 алба хаагч нарыг тасаг, хэсгийн дарга, ахлахуудад хуваарилан өгч, алба хаагч нэг бүрийн гэр орноор орж, гэр бүлийн гишүүдтэй уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна. Одоогоор нийт алба хаагчдын 68.1 хувь буюу 126 алба хаагчийн ар гэрээр зочилж санал сэтгэгдлийг хүлээн авч ажилласан байна.

Далд өвчлөлтийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нью Эндорфин” эмнэлгийн дотоод шүүрлийн булчирхайн эмч Д.Цэцэгмаа “Далд чихрийн шижинг илрүүлье-2022” төсөл, хөтөлбөр, чихрийн шижин өвчлөлийн талаар бие бүрэлдэхүүн сургалтад нийт 86 алба хамрагдлаа.

Цагдаагийн газрын хэмжээнд 25-аас дээш насны алба хаагчдын судалгааг гарган сахарын сорил, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулснаар нийт 84 алба хаагч сайн дурын үндсэн дээр сорилд хамрагдав.

Цус харвалтын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, харвалтын эрт үеийн шинж тэмдгийн талаар мэдлэг олгох зорилгоор алба хаагчдад “Цус харвалтаас урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг Дорнод аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдрэлийн тасгийн эмч Ц.Алтанцэцэг сургалт явуулж, нийт 83 алба хаагч хамрагдав.

Эмчийн үзлэгээр болон тест сорилоор сөрөг үзүүлэлттэй гарсан 26 алба хаагчдын нэрсийг гарган дахин тархины бичлэг, үзлэгт хамруулахаар ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Алба хаагчдын далд өвчлөлтийг илрүүлэх, онош тодруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газрын эмэгтэй алба хаагчдыг Улаанбаатар хотын “Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг”-ийн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамрууллаа. Эмэгтэй алба хаагчдыг үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээг 3 дахь жилдээ зохион байгуулж байна.

“Намар-Эрүүл” цагдаа арга хэмжээний удирдамжийн хүрээнд алба хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, спорт явган аяллыг хөгжүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор “Явган аялал”-ыг зохион байгуулж, 105 алба хаагч хамрагдав.

Явган аяллыг “Цагдаагийн газар-Музей-Хэрлэн гол” гэсэн маршрутаар аялж, аймгийн байгалийн болон түүхийн музейг үзэж сонирхон Хэрлэн голын эрэг хүртэл нийт 7 км явган аяллыг зохион байгуулав.

“Намар-Эрүүл” цагдаа арга хэмжээ болон явган аяллын хүрээнд алба хаагчдын дунд “Витаминжуулах” аяныг аймгийн Монгол эм импекс концернтэй хамтран зохион байгуулж, 3 төрлийн амин дэм, витамин алба хаагчдад тараав.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Өглөөний гүйлт”-ийг зохион байгуулж, алба хаагчдыг өглөөний 06 цагт Хэрлэн сумын 2 дугаар баг “Монгол дайчдын хөшөө”-ний дэргэд цуглуулж, 5 км зайд гүйж хээрийн гимнастик хөдөлгөөнийг хийж, ажлын хүнд хүчир ачаалал стрессийг тайлах арга хэмжээг зохион байгуулав.

Бие бялдар, биеийн тамирын спортыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан:

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах” /код 940/ журмын дагуу бие бүрэлдэхүүний дунд нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулж чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээг төлөвлөгөө удирдамжийн дагуу зохион байгуулж ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/28 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд бие бүрэлдэхүүнд зохион явуулах сургалтын 2022 оны нэгдсэн төлөвлөгөө, хуваарийг цагдаагийн газрын даргаар батлуулж, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, албаны бэлтгэлийг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх сургалтуудыг долоо хоногийн “Пүрэв” гарагт спорт зааланд халаалтын болон бэлтгэлжилтийн дасгал хөдөлгөөн хийж, алба хаагчид гар бөмбөг болон сагсан бөмбөгөөр тогтмол тоглож ирлээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын дунд болон аймаг, сумын хэмжээнд зохион явагдсан уралдаан, тэмцээнүүдэд алба хаагчдыг бүрэн хамруулан оролцуулж, Цагдаагийн газраас алба хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээ зохион явуулах хуваарийг оны эхэнд гарган батлуулж, зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

Цагдаагийн газраас “Хэрлэн голын жавар”, “Сагсны болон гар бөмбөг”, “Снукер билльярд”, “Марш тактик”, “Буудлага”, “Аэробик”, “Хүчний гурван төрөлт”, “Дартс”, “Буухиа”, “Явган аялал”, “Үндэсний бөх”, “Шатар”, “Шагайн харваа”, “Ширээний теннис”, “Хөл бөмбөг” зэрэг 16 уралдаан, тэмцээнийг зохион явуулж, давхардсан тоогоор 356 тамирчид хамрагджээ.

“Хэрлэн голын жавар” арга хэмжээг Дотоодын цэргийн тусгай салбараас Хэрлэн голын хөвөөнд зохион байгуулж, тасгуудаас 6 хүний бүрэлдэхүүнтэй 9 баг тамирчид оролцон, мөсний шагай, сүмо, олс таталтын тэмцээн, хээрийн цай шалгаруулах төрлүүдээр ур чадвар, хурд хүч, авхаалж самбаагаа уралдуулан, хамт олны халуун дулаан уур амьсгалын дунд зохион байгуулагдаж, нийлбэр дүнгээр Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 2 дугаар баг Тэргүүн байранд, Захиргааны удирдлагын тасаг Дэд байранд тус тус шалгарлаа.

Байгууллагын аварга шалгаруулах сагсны тэмцээнд 200.000, Цас мөсний баярын спортын арга хэмжээнд 200.000, шатрын тэмцээнд 170.000, хөл бөмбөгийн тэмцээнд 200.000, гар бөмбөгийн тэмцээнд 200.000, бильярдын тэмцээнд 200.000, марш тактикийн тэмцээнд 200.000, хүчний 3 төрөлт 200.000, аэробийн тэмцээнд 100.000, Цагдаагийн баярын спортын арга хэмжээнд 200.000, нийт 1.870.000 төгрөгийн зардлыг шийдвэрлэж, алба хаагчдыг шагнаж урамшуулав.

Г. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан байдал:

Тус цагдаагийн газрын цахим хуудас www.Dornod.police.gov.mn сайт болон “Дорнод- цагдаа” фэйсбүүк хуудсанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай хүртээмжтэй хүргэх ажлуудыг хийж гүйцэтгэв.

1. Дорнод аймгийн албан ёсны цахим сайт www.Dornod.mn болон хуулийн [legalinfo](http://legalinfo.gov.mn), шилэн дансны нэгдсэн систем <http://shilendans.gov.mn/org/> 438 сайтуудын линкийг өөрийн вэб сайттай холбож шууд хандах боломжийг бий болгосон.

2. www.Dornod.police.gov.mn сайт болон “Дорнодын цагдаа” фэйсбүүк хуудсаар дамжуулан цагдаагийн газрын цаг үеийн мэдээ мэдээлэл, соёл, урлаг спорт, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, шилэн дансны мэдээлэл болон соён гэгээрүүлэх ажлын мэдээ мэдээллүүдийг тухай бүрт нь оруулж байршуулан ажиллаж байна.

3. Манай байгууллагын цахим сайтаас иргэд ял шийтгэлийн тодорхойлолт авах, тамга тэмдэг, гэрээт харуул хамгаалалт, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх, дуусгавар болох, зурагт танилцуулга, иргэдээс гэмт хэргийн талаар төлбөртэй мэдээлэл авах тухай зэрэг мэдээллүүдийг авах боломжтой. Тус цагдаагийн газрын www.Dornod.police.gov.mn цахим хуудасны “Мэдээллийн ил тод байдал” цэсний үйл ажиллагаа гэсэн дэд цэсэнд цагдаагийн газрын 2022 оны 1 дүгээр улирал, хагас жил, 3 дугаар улирал, жилийн эцсийн тайланг байршуулж ажилласан болно.

Мөн цагдаагийн газраас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, соён гэгээрүүлэх ажил, тэмцээн уралдаан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, хяналт шалгалтын талаарх мэдээ мэдээллийг тухай бүр Захиргааны удирдлагын тасгийн даргаар хянуулан газрын цахим хуудас болон нүүр хуудсанд байршуулж ажилласан.

Цагдаагийн газар, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр “Нэг зорилгын төлөө хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгуулж, Хэвлэл мэдээллийн байгууллагатай ажиллах ЦБҮАЖ /код 242/-ын дагуу 2022 онд “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан, гэрээний хүрээнд тасаг албадаас газрын даргын баталсан хуваарийн дагуу 7 хоногт бүр эрүү, хэв журмын нөхцөл байдлыг мэдээлж, газрын даргын баталсан хуваарийн дагуу тасаг албадаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл, ярилцлага, нэвтрүүлэг явуулж ажиллав.

Цагдаагийн газрыг олон нийтэд таниулах, сурталчлах, иргэдэд тухай байгууллагын мэдээлэл нээлттэй ил тод байх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор Цагдаагийн газрын “Dornod.police.gov.mn” веб сайтад 162 шинэ мэдээлэл, “Дорнод аймгийн Цагдаагийн газар”, фэйсбүүк хуудсанд 165 мэдээ, мэдээлэл тавьж, 3400 мэдээг шэйрлэн, 52 төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны шинэчилсэн хувилбар, бусад төрлийн мэдээллийн баяжилтыг тухай бүр сайтад байршуулж ажиллалаа.

Мөн хандалт ихтэй “Дорнодчуудын нэгдэл”, “Дорнодын нэгдсэн зар”, “Дорнодын ээжүүд” зэрэг 25 цахим группт санамж, сэрэмжлүүлэг, шторк, мэдээ мэдээллийг байршуулснаар 3.248.595 иргэд, олон нийтэд түгээн ажиллалаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 242/-ын дагуу орон нутгийн “ТҮ6”, “Мижиг”, “Шинэ суваг”, “D1”, “Дорнод ТҮ”, “Совь”, “PBS” телевизүүдтэй хамтран нээлттэй арга хэмжээний мэдээллийг 7 хоногт 2 удаагийн давтамжтайгаар 3 удаа явуулж, Дорнод аймгийн Цагдаагийн газрын “dornod.police.gov.mn” вэб сайтад болон “Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар”-ын цахим хуудас, аймгийн хэмжээнд идэвхтэй хэрэглэгддэг гурван фэйсбүүк хуудсанд 4 удаа байршуулан ажилласан болно.

Аймгийн “Дорнод”, “Дөл” сонины газруудтай хамтран ажиллах гэрээний дагуу “Цагдаагийн газраас мэдээлж байна” буланд “Сар шинэ -2022” нэгдсэн арга хэмжээний Цагдаагийн газрын тасаг албадаас хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 6, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 5, Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх 11, Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх 4, Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 12, Архидан согтуурахтай тэмцэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 18, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 5, нийт 61 удаа мэдээлэл, нийтлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж бэлтгэн нийтлүүлж, иргэд олон нийтэд хүргэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн цахим орчинд түгээж байгаа богино хэмжээний кино, контентуудыг тухай бүр цаг алдалгүй олон хандагчтай цахим хуудаснуудад түгээж байна.

Иргэдийг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил, осолд өртөж хохирох /осгож, хөлдөх, хордлого/-оос урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн ирүүлсэн Монголын мэдээ /цагийн хүрд анхааруулга мэдээ, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 6 төрлийн сэрэмжлүүлэг, Архидан согтуурахтай тэмцэх чиглэлийн 9 төрлийн сэрэмжлүүлэг, нийт 15 төрлийн сэрэмжлүүлэг, Халаасны хулгайн шторк, Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шторк, Авто машины хулгайгаас урьдчилан сэргийлэх, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 6 төрлийн шторк, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Шинэ суваг” телевизтэй хамтран аймгийн онцлогт тохируулан 6 төрлийн видео шторк, нийт 12 төрлийн шторк, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх 2 нэвтрүүлэг, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтод нэвтрүүлэг, Халуун сэдэв зорилтод нэвтрүүлэг, Хүчингийн гэмт хэргийн зорилтод нэвтрүүлэг, нийт 5 нэвтрүүлэг, цаг үеийн нөхцөл байдлын 32 мэдээ мэдээлэл, нийт 64 сэрэмжлүүлэг, шторк, нэвтрүүлэг, мэдээ мэдээллийг орон нутгийн “Шинэ суваг”, “ТҮ6”, “Мижи”, “D1”, “Совь”, “PBS” зэрэг телевизүүдээр долоо хоног, сарын давтамжтайгаар түгээн нэвтрүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн мэргэжилтэнтэй уулзан улсын хэмжээнд явагдаж буй “Зөв тусгал” аяны хүрээнд хийгдсэн олон нийтийн сүлжээнд тавигдаж буй шторк, видеог Хэрлэн сумын 7 дугаар баг “Тусгаар тогтнол”-ын талбайд байрлах “LED” дэлгэцээр гаргаж, хүн ихээр төвлөрдөг томоохон цэг хэсгүүдийн урсдаг самбаруудаар цацаж эцэг, эхчүүдэд мэдээллийг хүргэн ажиллалаа.

Д. Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн ажлын чиглэл, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх “Цагдаагийн байгууллагын авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-ний нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаа.

Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн талаар болон соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд цагдаагийн газрын алба хаагчдыг иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай, харилцааны өндөр соёлтой үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор газрын үүдний иргэдэд үйлчлэх өрөөнд “Санал хүсэлтийн дэвтэр”, “Санал авах хайрцаг”, цагдаагийн алба хаагчийн хүнд суртал, авлига хээл хахуулийн талаарх мэдээллийг хүлээн авах ёс журам сахиулах эргүүлийн 7058102, 70194403 дугаарын утас зэргийг иргэдийн нүдэнд харагдахуйц газарт байрлуулж, байгууллагуудын гадна талд “Авлигын эсрэг хамтдаа”, “Авлига, хүнд суртал”, “Авлигад таны үгүй чухал” “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын авлига, хээл хууль, хүнд суртлын талаар мэдээлэл хүлээн авах 126 тусгай дугаар”-ын зурагт хуудсыг байрлуулав.

Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын алба хаагч нараас авлига ашиг сонирхлын зөрчил дутагдал гаргасан алба хаагч байхгүй байна. Хөтөлбөрийн дагуу “Авлигад өртөж болзошгүй эрсдэлтэй албан тушаал, түүнд ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрт хяналт тавих албан тушаалтны судалгаа”, “Авлигад өртөж болзошгүй алба хаагчдын судалгаа”-зэргийг гарган хяналт тавин ажиллаа УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын дагуу тус Цагдаагийн газраас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах эрх бүхий 83 алба хаагч

мэдүүлгээ өөрийн биеэр, тогтоосон хугацаанд бүрэн гаргуулан авч хуулийн хугацаанд баталгаажуулан ажиллалаа.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, тайлбар, мэдэгдэл, мэдээлэл тэдгээрийн шийдвэрлэлт, хөрөнгө орлогын их хэмжээний өөрчлөлтийн бүртгэлийг маягтын дагуу бүрэн хөтөлж 2022 онд 32 алба хаагч хөрөнгө орлогын мэдүүлэг шинээр мэдүүлж, үүнээс 2 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэг, 1 алба хаагчийн их хэмжээний өөрчлөлтийг хүлээн авч бүртгэн санд шивж баталгаажууллаа.

Авлигын эсрэг хууль, тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг /цаашид ХАСХОМ гэх/-ийг бүртгэх, хянах болон нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах, мэдүүлэх үйл ажиллагааг цахимаар хэрэгжүүлж, алба хаагч нарт үнэн зөв мэдүүлэх анхаарах асуудлын талаар Захиргааны удирдлагын тасгийн дарга, хүний нөөцийн мэргэжилтнээс албаны сургалтыг 3 удаа, ажлын чиглэл зааварчилга 2 удаа тус тус өгөөд байна.

Алба хаагчдаас баталгаа авч авилгаас урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих алба хаагчдын сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллалаа.

Хөтөлбөрийн дагуу “Авлигад өртөж болзошгүй эрсдэлтэй албан тушаал, түүнд ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрт хяналт тавих албан тушаалтны судалгаа”, “Авлигад өртөж болзошгүй алба хаагчдын судалгаа”-зэргийг гарган хяналт тавин ажиллаа. Авилгаас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага, нийт бие бүрэлдэхүүний үйл хэрэг болгон алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд заалт оруулж, авилгад өртөхгүй байх, удирдах албан тушаалтнуудын үлгэрлэл манлайлалтай ажиллаж, алба хаагч нарт тавих дотоодын хяналт, зарчимч шаардлагыг өндөржүүлэн ажилласнаас гадна авилгын хор уршиг, ашиг сонирхлыг зөрчил, түүнээс ангид байхыг уриалж хамт олноороо авилгыг тэвчиж ажиллахыг санал болгон гарын үсэг зуруулан авлигад өртөхгүй байх баталгааг гаргуулж ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагыг олон нийтэд таниулах, сурталчлах, иргэдэд тухай байгууллагын мэдээлэл нээлттэй ил тод байх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор цагдаагийн газрын “Dornod.police.gov.mn” цахим хуудас, фейсбүүк хуудас болон цагдаагийн газрын иргэд хүлээн авах танхимд авилгаас урьдчилан сэргийлэх ил тод байдлын самбар шинээр хийж байршуулан авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж, иргэд олон нийтийг нэгдэхийг урьж, авлигын эсрэг хууль тогтоомжийн чиглэлээр мэдээ мэдээллийг сурталчлан ажиллаж байна.

“Авлигын эсрэг хуулийн”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.8-д заасан үүргийн хүрээнд иргэдээс авлигын талаар гомдол авах 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан, мөн харандааны зураглалаар хийгдсэн 3 төрлийн, нийт 4 төрлийн шторк сурталчилгааг өөрийн цахим хуудас болон хандалт ихтэй орон нутгийн цахим хуудаснуудад байршуулж, орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлж иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулав.

Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 98.0 хувь буюу 4.9 үнэлгээтэй дүгнэгдлээ.

ДӨРӨВ. САНХҮҮ, БҮРТГЭЛ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар хийсэн ажил, арга хэмжээ.

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, шилэн дансны тухай хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу өдөр тутмын үйл ажиллагааг мөрдөн ажиллаж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг тооцон судалж төсөвлөгдөөгүй өр авлага үүсгэхгүй байх талаар анхаарч, санхүүгийн ил тод байдлын хүрээнд тухай бүр хийсэн ажил, гарсан зардлын мэдээг алба хаагчдад танилцуулан, шилэн дансны сайт болон байгууллагын цахим хуудас, санхүүгийн мэдээллийн самбарт төсвийн талаар мэдээг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлэн ажиллаж байна. 2021 оны санхүүгийн тайланд

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас хяналт шалгалт хийж “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн. Тайланг Цагдаагийн ерөнхий газрын санхүү аж ахуйн албанд хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

Байгууллагын дотоод хяналт шалгалт явуулах 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу үнэт цаас, шилэн данс, эд хөрөнгө ашиглалтын чиглэлээр хяналт шалгалтыг явуулан дүнг зөвлөлийн хурлаар хэлэлцэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заасны дагуу байгууллагын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг хууль журам, бодит зардлын тооцоолборыг хийж боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанд хүргэн нэгтгүүлэв. Мөн Монгол банкны Дорнод салбарын гэрээт цагдаагийн зардлыг төсөв тооцоог хийж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 210 алба хаагчдад цалингийн зээл, 130 алба хаагчийн татварын буцаан олголтын цалингийн тодорхойлолт, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох алба хаагчийн сүүлийн 60 сарын цалингийн тодорхойлолт, цагдаагийн албаны тухай хуулийн 89.2-т заасан 30 сарын тэтгэмж авах болзол шаардлага хангасан алба хаагчийн сүүлийн 60 сарын үндсэн цалингийн тодорхойлолтыг тус тус гарган өгч шийдвэрлүүлэв.

Батлагдсан төсөв, түүний зарцуулалт: Улсын төсвөөс 3.4 тэрбум төгрөг, өөрийн орлогоор 15.0 сая, гэрээтийн орлогоор 55.7 сая төгрөг нийт 3.5 тэрбум төгрөгийн батлагдсан төсөвтэй хэмнэлтийн горимд үйл ажиллагаа явуулж байна.

Төсвийн гүйцэтгэлийг тооцон судалж төсөвлөгдөөгүй өр авлага үүсгэхгүй байх талаар анхаарч, үүссэн өр авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан удирдлагад танилцуулан ажилласан. Төсөвт зохицуулалт хийх саналыг Цагдаагийн ерөнхий газрын санхүү аж ахуйн албанд хүргүүлэн төсвийн хуваарьт 28.9 сая төгрөгийн өөрчлөлтийг хийлгүүлэн ажиллав.

Мөнгөн хөрөнгө: Алба хаагчдын цалинд 3.2 тэрбум, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 67.3 сая, байр ашиглалтын зардалд 56.7 сая, бичиг хэрэг 41.4 сая, шатахуун 142,4 сая, холбооны зардал 7.4 сая, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлийн зардал 9.3 сая, хоол, эм бэлдмэлийн зардал 0.8 сая, хоолны зардал 9.3 сая, нормын хувцас 1.4 сая, багаж техник хэрэгслийн зардал 14.3 сая, хөдөлмөр хамгаалах хэрэгсэл 3.8 сая, урсгал засварын зардал 60,0 сая, алба хаагчдад хөдөө орон нутаг болон хот руу албан ажлаар явсан алба хаагчдад томилолт 15,6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил арга хэмжээний зардал 10.3 сая, байцаан шийтгэх ажиллагааны зардал 7.8 сая, тээврийн хэрэгслийн татвар 1.3 сая, газрын татвар 2.8 сая, сургалт дадлагын зардал 2.3 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 9.7 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж 17.1 сая нийт 3.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж ажилласан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын зарцуулалт, эргэн төлөлтийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг мэргэжлийн байгууллагын шинжээчээр дүгнэлт гаргуулахад 7.8 сая төгрөгийг олгож, буцаан гэм буруутай этгээдээр 900.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, бусад гарсан зардлыг төлүүлэх ажлыг эрчимжүүлэн байгууллагыг төлөөлсөн нэхэмжлэгчээр мэдүүлэг өгч материалд хавсарган ажилласан.

Тус цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн 100070012401 тоот дансанд аймаг орон нутгаас Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулал, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд орсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулал 152.7 сая төгрөг, “Номин даатгал” ХХК-иас автомашины даатгалын төлбөр 40.8 сая төгрөг нийт 193.5 сая төгрөгийг төвлөрүүлэн, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 02 дугаар хавсралт “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу нээлгүүлэн зориулалтын дагуу бүрэн зарцуулан ажилласан.

Цагдаагийн газрын Ахмадын сангийн 100070012503 тоот дансанд Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/26 дугаар тушаалаар 15,962,000 төгрөгийн орлогыг бүртгэн авч сар шинийн баяр, Монгол улсад орчин цагийн

цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний 101, Дотоодын цэргийн түүхт 100 жилийн ой, Цагдаагийн газрын ахмад ажилтны ар гэрээр явах, ахуй байдалтай танилцах, санал хүсэлт, “Олон улсын ахмад өдөр”-ийг тохиолдуулан байгууллагын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, 115 ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлж, шагнаж урамшуулах зардалд нийт 15,504,870 төгрөгийн зарцуулсан.

Цалин хөлс бүртгэл: Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1 “Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно” гэж заасны дагуу цалинг сард 2 удаа тооцоолон сарын бүрийн 10, 25-ны өдрүүдэд хас, голомт банканд байрших алба хаагчдын цалингийн дансанд шилжүүлэн олгосон.

ХХОАТатварт 213.8 сая төгрөгийг суутгаж аймгийн Татварын албаны дансанд шилжүүлсэн, улирлын тайланг дараа сарын 10-ны өдөр <https://e-tax.mta.mn/> хаягаар цахимаар шивж тоон гарын үсгээр илгээн байгууллагатай тооцоо нийлж ажилласан.

Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу алба хаагчдын цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож цалингаас, ажил олгогчоос нийт 118.8 сая төгрөгийг аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн 100070090000 тоот дансанд шилжүүлэн тайланг www.ndaatgal.mn/nd8/ хаягаар цахимаар шивж илгээн баталгаажуулан ажилласан.

Хүний нөөцийн мэргэжилтнээс Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишиг шинэчлэн тогтоох тухай” 24 дүгээр тогтоолын дагуу алба хаагчдын шатлал удаан жилийг сар бүр тооцон өөрчлөлтийн тушаалыг хэрэгжүүлсэн мөн “Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээ”-г шинэчлэн батлагдсантай холбогдуулан шинэчилсэн цалингаар тооцон олгосон. Сар бүрийн ажлын үр дүнг хэлэлцсэн тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн цалинд нэмэлт, хасалтыг тухай бүрт оруулан тооцож цалингийн өр төлбөргүй ажилласан.

Мэдээллийн ил тод байдал: Төсөв, санхүүгийн ил тод байдлын хүрээнд Цагдаагийн газрын төсвийн орлого, батлагдсан төсвийн зарцуулалтыг www.dornod.police.gov.mn сайтын шилэн дансны хэсэгт, www.shilendans.mn шилэн дансны сайт, байгууллагын санхүүгийн ил тод байдал гэсэн мэдээллийн самбарт 2022 оны жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, улирал, сарын төсвийн гүйцэтгэл, хагас жилийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр тус тус байршуулан албан хаагчид болон иргэд, олон нийтийг нээлттэй үзэх боломжоор бүрэн хангаж ажилласан 2022 онд худалдан авах хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөгөөг гарган батлуулан шилэн дансны сайтад мэдээлэн ажилласан.

Санхүүгийн мэдээллийн самбарыг шинэчлэн хийлгэн байгууллагын 1 дүгээр конторын үүдэнд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, төсвийн гүйцэтгэлийн 1-11 дүгээр сарын мэдээ, 2021 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, шилэн дансанд мэдээлбэл зохих 111 мэдээллийг бүрэн байршуулан 100 хувийн биелэлттэй ажиллаж байгаа ба тайланг 3 удаа илгээн ажилласан.

Хөрөнгө оруулалт: Байгууллагын 2022 оны төсвийн хөрөнгөөр түлш шатах тослох материал худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу www.tender.gov.mn сайтад цахимаар зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан НИК ХХК-тай 132.4 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

2022 онд аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах ажлын хүрээнд Матад, Булган, Гурванзагал, Баяндун сумын цагдаагийн тасаг, хэсгийн алба хэрэгцээнд нийт 4 автомашин худалдан авах 125,0 сая төгрөгийн худалдан авах тендер зарлагдсан боловч оролцогч ирээгүй тул тендерийг цуцалж аймгийн 2022 оны төсвийн тодотголоор санхүүжилтийг татсан, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/-ны засварт 41,2 сая төгрөг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт тендерийг зарлаж тус аймгийн “Дорнын их өглөг” ХХК-тай гэрээ байгуулан

Цагаан-Овоо сумын Цагдаагийн хэсгийн байрыг засварлуулан комисс хүлээн авч Сэргэлэн сумын цагдаагийн хэсгийн байрыг 2023 онд засварлахаар ажиллаж байна.

Хууль зүй дотоод хэсгийн яамнаас балансаас баланст шилжүүлсэн Ланд-200 маркийн 167.7 сая төгрөгийн автомашин, Чойбалсан хотын Засаг даргын тамгын газраас 20 ширхэг 27.0 сая төгрөгийн согтуурал тандагч драйгер, Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2022 оны төсвөөс 15 ширхэг 8.8 сая төгрөгийн Энгэрийн камер /Antebo DSJ-V2/, Цагдаагийн Ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвөөс 30 ширхэг бугуйн гав, 20 ширхэг цахилгаан бороохойг хүлээн авсан.

Номин даатгалаас автомашины даатгалын нөхөн төлбөрт 40.8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулан УАЗ-Мега ХХК-тай гэрээ байгуулан Уаз-Хантер маркийн автомашиныг шинээр худалдан авч ашиглалтад оруулсан. Цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагад шаардлагатай бараа материал худалдан авах ажиллагаанд үнийн судалгаа хийж хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.

Төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор УАЗ-220695 маркийн 2759дор, Toyota Prius20 маркийн 8969дор Toyota Harrieri маркийн 00-29дор улсын дугаартай 75.9 сая төгрөгийн автомашинуудыг балансаас баланст шилжүүлэн авсан.

Орон нутгийн 2023 оны төсөвт тусгуулах төсвийн санал, тооцоог гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ажлуудаас: Аймгийн 2023 оны төсөв олон нийтийн 8 цагдаагийн орон тоог баталгаажуулан үйл ажиллагааны зардалд 64.4 сая төгрөг, Сумдын цагдаагийн хэсгийн байр “Кобан” -ны засвар /Сэргэлэн сум/ 20.0 сая төгрөг, Цагдаагийн газрын 1 дүгээр конторын барилгын дулааны шугамыг 2 дугаар хэлхээнд холбох /ялтсан бойлуур тавих/ 41.7 сая төгрөг, Баян-Уул сумын цагдаагийн тасгийн байрны завсар 60.0 сая төгрөг нийт 186.1 сая төгрөг шийдвэрлүүлсэн.

Чойбалсан хотын 2023 оны төсөвт Аймгийн төвийн гудамж, зам талбайн телехяналтын нэгдсэн системийн төв болон стандартад нийцсэн серверийн өрөөг байгуулах 21.5 сая, суурин компьютер, энгэрийн камер, гар станц, техник хэрэгсэл авах 48.6 сая, олон нийтийн цагдаа 2 орон тоогоор 14.8 сая, “Би цагдаа” болзолт уралдаан 40.0 сая, эргүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчдын амьдрах орчин нөхцөлийн сайжруулах 10.0 сая, нийт 135.0 сая төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2023 оны төсөвт шаардлагатай тоног төхөөрөмж тусгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Үнэт цаасны тооцоо бодолт: Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас үнэт цаасны нөөц бүрдүүлэлт хийж няравт хүлээлгэн өгсөн. Нярваас алба хаагчид нэг бүрт бүртгэлээр санхүүгийн тэмдэг дарж олгосон. Алба хаагч нартай үнэт цаасны тооцоог хийхдээ мөнгөний баримт, нэгдсэн сүлжээнд шивэгдсэн эсэх, бүртгэлийн тэмдэг дарагдсан эсэхийг шалгаж үлдэгдлийг тулган баталгаажуулан ажилласан. Үнэт цаасны тайланг цалин тооцохоос өмнө гаргаж үлдэгдэл ихтэй болон тооцоо хийхгүй удаасан алба хаагчидтай тооцоог хийлгэх хийж арга хэмжээг тогтмол авч ажилласан.

2022 оны 3 дугаар улиралд давхардсан тоогоор 94 алба хаагчид шийтгэлийн хуудас маягт-1, маягт-2 шийтгэлийн хуудас 2002 ширхэг олгож, давхардсан тоогоор 237 алба хаагч маягт 1, 2 шийтгэлийн хуудас 2059 ширхгээр тооцоо хийж 457,0 сая төгрөгийн орлого оруулж, бэлэн бус торгуулиар тайлант хугацаанд 405,9 сая төгрөгийн орлого оруулж, нийт төсөвт **625.5 сая** төгрөгийн торгуулийн орлогын орон нутгийн төсөвт оруулсан.

Үнэт цаас болон галт зэвсгийн гэрчилгээний тайланг сар бүр гаргаж цагдаагийн газрын удирдлагад танилцуулан нярвын үлдэгдлийг тоолж баталгаажуулан мэдээг тайланг дараа сарын 01 өдрийн дотор Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албаны дотоод сүлжээгээр хүргүүлэн зөрчил дутагдалгүй ажилласан байна. Эрүүлжүүлэх баривчлах байрны тайланг сар бүр гаргуулан хянаж хүлээн авч 6,9 сая төгрөгийн орлогыг бүртгэн тайлагнасан.

Бараа материал, өмч хөрөнгө: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 422 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын

баримт бичгийн “Бараа материалын бүртгэл” хэсэг, Цагдаагийн газрын даргын 2015 оны а/03 тоот тушаалаар батлагдсан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагын данс бүртгэлд байгаа тусгай эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж ажиллалаа.

Санхүүгийн 2018 оны тайланд хийсэн аудитаар өгөгдсөн санал, зөвлөмжийн дагуу 2019 онд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалын 6 дугаар хавсралт “Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа”-г үндэслэн байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд анхны өртгөө нөхсөн 348 ширхэг 218.3 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж цаашид ашиглах хугацааг тогтоох саналыг гаргаж аймгийн Өмчийн албанд хүргүүлэн зөвшөөрөл авч хэрэгжүүлэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, УСНББОУС-17 –г хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эд хөрөнгийн 2022 оны жилийн эцсийн тооллогоор элэгдлийн хугацаа дуусаж цаашид ашиглах боломжгүй болсон 202 ширхэг 71.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасах саналыг орон нутгийн өмчийн газарт хүргүүлээд байна.

Албаны дүрэмт хувцасны хангалт: Албанд шинээр томилогдсон алба хаагч нарын томилгоо цол зэрэг албан тушаал өөрчлөгдсөн тухай бүр тушаалыг Хангалт үйлчилгээний хэлтэст хүргүүлэн алба хаагч нарын хөдөлгөөний баяжилтийг ахлах мэргэжилтэн х/ч Золзаяатай тулгалт хийж шинээр албан томилогдсон болон цагдаагийн 175 алба хаагчдад хантааз, бусад хангалтыг тараан олгосон. Цагдаагийн газраас өөрийн хүсэлтээр халагдсан цагдаагийн ахлах дэслэгч 15 алба хаагчаас 13 алба хаагчын 7.8 сая төгрөгийн төлбөрийг төлүүлж 2 алба хаагчын төлбөрийг барагдуулах ажлыг зохион ажиллаж байна.

Автомашин, мотоциклийн талаар: Дорнод аймгийн Цагдаагийн газрын албан ашиглагдаж байгаа авто машинуудыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан "Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, газар, нэгжийн автомашины тоо, хоногийн гүйлтийн хэмжээ"-г мөрдөж, засвар үйлчилгээг чанартай хийх тал дээр анхаарч Жолооч нарын замын хуудас бөглүүлэх авто машины стометрийн залттай тулгалтыг сар бүр хийж Цагдаагийн газрын даргын тушаалаар баталсан техникийн комисстой хамтарч авто машины сэлбэг хэрэгсэл дээр акт үйлдэж Төсвийн тухай хуулийн 41.2.2, зам тээврийн хөгжлийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2019 оны 390 дүгээр тушаалыг үндэслэн Цагдаагийн газрын даргаар тушаал гаргуулан Цагдаагийн газрын данс бүртгэлд байгаа авто машинуудын 100 км гүйлтэд зарцуулагдах жишиг нормыг батлуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Бусад ажлын талаар: Цагдаагийн газрын эзэмшилд байгаа газруудын газрын гэрчилгээг баталгаажуулах зорилгоор аймгийн улсын бүртгэлийн хэлтэст албан тоотой хүргүүлж газрын гэрчилгээг баталгаажуулан авч газрын гэрчилгээгүй 7 сумыг гэрчилгээжүүлэхээр албан тоот төлөвлөж газрын даргаар хянуулан тухайн суманд хүргүүлснээс Хөлөнбуйр сумын газрын гэрчилгээ, Цагаан-Овоо сумын газрын гэрчилгээ баталгаажигдсан бусад сумдын газрын гэрчилгээг гаргуулахаар холбогдох албан тушаалтантай холбогдон ажиллаж байна.

Цагдаагийн газрын гэнэтийн ослын даатгалд 200 алба хаагч, тээврийн хэрэгслийн даатгалд 21 автомашин, 14 мотоцикль, үл хөдлөх хөрөнгийн даатгалд 1, 2 дугаар конторын барилгыг хамруулах судалгааг гарган Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүргүүлэн 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл Алба хаагчдын гэнэтийн ослын даатгалын гэрээг “Номин даатгал”ХХК, үл хөдлөх хөрөнгийн даатгалыг “Хаан даатгал”ХХК, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг “Практикал даатгал”ХХК-тай тус тус байгуулан ажилласан.

Дэлхий нийтэд тархаад байгаа шинэ کروناвирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай халдваргүйтгэл, ариутгалын бодис болон амны хаалт/ маск/ нэг удаагийн хувцас хэрэглэлийн судалгааг хийж нөөц бүрдүүлэлт хийж, эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэн ажилласан.

Цагдаагийн газрын эзэмшилд байгаа газар болон ойр орчмын 50 метр газрын хог хаягдлыг цэвэрлэж, 1, 2 дугаар байрны хогыг ачуулж, цэвэрлэгээ ариутгалыг Эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу өдөр дутам чанартай хийн ажиллаж байна.

Санхүүгийн аюулгүй байдлын чиглэлээр: Нягтлан бодох бүртгэлийн болон төсвийн тухай хуулиудыг мөрдлөг болгон төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, ашиглах, завших, үрэгдүүлэх, хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулахад хяналтыг тогтмол тавьж Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -т “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид” хүргүүлнэ гэсэн заалтын дагуу 2021 оны жилийн эцсийн тайланг 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсэн.

Байгууллагын дотоод хяналт шалгалт явуулах 2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу эрүүлжүүлэх саатуулах байрны төлбөр төлөлт, автомашины ашиглалтын чиглэлээр хяналт шалгалтыг явуулж дүнг Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн тасгуудад албан “Мэдэгдэл” хүргүүлэн ажилласан.

Туслах мал аж ахуйн чиглэлээр Хаврын ямаа самналтаар нийт данс бүртгэлээр 171 ямаа самнахаас 136 ямаа самнаж 27,5 кг ноолуур бэлтгэн тухайн үеийн зах зээлийн үнэлгээгээр 156000 төгрөгөөр тооцон борлуулж нийт 4.290.000 төгрөгийг санхүүд хүлээлгэн өгсөн. Малчны ахуй амьдрал гэрээний дагуу сард 2 төлөг, зарцуулдаг нь одоо үеийн зах зээлийн нийгэмд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй байсан тул оны эхнээс Цагдаагийн газрын дарга болон зөвлөлийн гишүүдэд танилцуулан 2 төлөг дээр нэмж 1 борлон ямаа олгохоор шийдвэр гаргуулан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэн ажилласан.

Туслах аж ахуйн 2022 оны төл бойжуулалтад анхаарч тасаг алба хаагчдын хүчээр нэмэгдүүлэн ажиллан унага 8, тугал 8, хурга 80, ишиг 75 толгойг тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгасан.

ТАВ. АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ХАНГАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/112 тушаалаар батлагдсан “Хорт зуршлаас татгалзаж-Сайнаар үлгэрлэе” нөлөөллийн аян, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус Цагдаагийн газрын орон тооны бус “Эрүүл мэнд, сэтгэл зүйн баг”-аас БОЭТөвийн дотоод шүүрлийн тасгийн эрхлэгч эмч, анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч Д.Цэцэгмааг урьж, “Далд чихрийн шижин, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр Эрүүл мэндийн газрын халдварт бус өвчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Бибишийг урьж “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах тухай танилцуулга” сэдвээр тус тус сургалтыг зохион байгууллаа.

Мөн өдөр тус Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд далд чихрийн шижинг илрүүлэх 1 удаагийн глюкозын ачаалалтай шинжилгээ авч, алба хаагч нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Алба хаагчдыг түр болон удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд зориулж хамт олны “Журмын сан”-гаас 800.000 төгрөгийн мөнгөн тусламжийг 6 алба хаагчдад үзүүлсэн байна.

2022 оны хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний дагуу “Асралт үйлс” өрхийн эмнэлгээс алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Эрүүл зөв хооллолт”, “Давсны хэрэглээг зохицуулах ач тус”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх” зэрэг сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор “dornod tsagdaa surgalt” хаалттай фейсбүүк хуудсанд байршуулж ажиллаа.

Ахмадын сангийн данс нээлгэж 2022 оны төсөв 15.9 сая төгрөг батлуулж, Ахмадын баярын арга хэмжээнд 115 ахмад ажилтанд гарын бэлэг, 1 адуу, 1 ахмад ажилтныг "Алдар нь мөнхөрсөн ахмад буурал" -аар өргөмжлөл мөнгөн шагнал гардуулж хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соёл, Соён гэгээрүүлэх ажил" /Код-940/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан "Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газраас ахмад үеэсээ үлгэр дуурайлал авч албандаа хандах хандлага, албаараа бахархах сэтгэгдэл бий болгох зорилгоор 1996-1998 онд тус цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Д.Цэрэндорж "Дурсамж-уулзалт" арга хэмжээ зохион байгуулав.

Тус цагдаагийн газраас алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, дэвшилтэт техник технологийг алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлтдээ ашиглах зорилгоор хамгаалуулагч байгууллага "Дорнод Нийтийн аж ахуй" компаниас дотоодын цэргийн тусгай салбарын алба хаагч нарт үүргийн радио гар болон суурин станц, шөнийн дуран, гар чийдэн, дрон зэргийг хүлээлгэн өгсөн.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг оны эхэнд байгуулан гэрээний дагуу алба хаагч нарт элэгний В,С вирусийн шинжилгээг "Эрүүл монгол хүн-эрт илрүүлэг" 2 удаа алба хаагчдыг нэгдсэн журмаар шинжилгээнд хамруулан ажиллав.

Цагдаагийн газраас 2022 оны хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний дагуу "Асралт үйлс" өрхийн эмнэлгээс алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд "Эрүүл зөв хооллолт", "Давсны хэрэглээг зохицуулах ач тус", "Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх" зэрэг сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор "dornod tsagdaa surgalt" хаалттай фейсбүүк хуудсанд байршуулж ажиллаа.

Томуу, томуут төст өвчлөл их байгаатай холбогдуулан алба хаагчдыг дархлаажуулах аяныг "Асралт үйлс" ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулав.

Ахмадын сангийн данс нээлгэж 2022 оны төсөв 15.9 сая төгрөг батлуулж, Сар шинийн баярын арга хэмжээнд 115 ахмад ажилтанд 3.0 сая төгрөгийн гарын бэлэг, 3 ахмад ажилтанд ууцны хонь, 3 ахмад ажилтанд "Буянтай буурал" -аар өргөмжлөл тавгийн идээг тус тус гардуулан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соёл, Соён гэгээрүүлэх ажил" /Код-940/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан "Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газраас ахмад үеэсээ үлгэр дуурайлал авч албандаа хандах хандлага, албаараа бахархах сэтгэгдэл бий болгох зорилгоор нийтийн хэв журам хамгаалах тасгийн "Ахмад, дунд, залуу үеийн уулзалт" арга хэмжээ 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион явагдаж, урилгаар Ахмадын хорооны дарга, цагдаагийн бэлтгэл хошууч Х.Болдбаатар, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Н.Болдсайхан, цагдаагийн бэлтгэл ахмад Л.Улаан, Б.Отгонсүрэн, цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч Ө.Нэргүй, Ц.Энхбаатар нар оролцлоо. Уулзалтаар Цагдаагийн газраас хийж хэрэгжүүлж буй ажлаа танилцуулан, ахмад дунд залуу үеийн холбоог сайжруулах чиглэлээр санал хүсэлтийг хүлээн авч, ажил хэрэгч яриа өрнүүлж, туршлага судалсан сайхан ярилцлага болж өндөрлөсөн байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн цагдаагийн тасгаас санаачлан тус цагдаагийн газрын бэлтгэл дэд хурандаа Х.Мөнхжаргалыг урьж, дурсамж уулзалтыг зохион байгуулав.

"Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх" хөтөлбөрийн хүрээнд ард иргэдийнхээ амар тайван амьдралын төлөө хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ нэр төртэй гүйцэтгэж ирсэн үе, үеийн ахмадуудаа "олон улсын ахмадын өдөр"-ийг угтан хүлээн авч, "Монгол цагдаа-Бидний бахархал" хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчид жагсаж хүндэтгэл үзүүлэв.

Хүндэтгэлийн арга хэмжээнд Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, ахмадын хорооны дарга, бэлтгэл хошууч Х.Болдбаатар болон ахмад

ажилтнууд оролцож, Цагдаагийн газрын байлдааны тугийг залж, ахмад ажилтнууд тугандаа ёсолж, залуу халуун дурсан жагсаалаар жагсаж хүндэтгэл үзүүлэв.

Шинэ залуу ажилтнуудыг сурган дадлагажуулах үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж, Цагдаагийн газрын баярын бичиг, үнэ бүхий зүйл, түлээ нүүрсний хөнгөлөлт урамшууллын эрхийн бичгээр 21 ахмад ажилтныг шагнаж урамшуулав.

Ахмад ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, халамж үйлчилгээг үзүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор сар шинийн гарын бэлэг, нүүрсний тусламж, хөнгөлөлт, бусад шагнал, буцалтгүй тусламж, шатахууны зардалд нийт 5.936.556 төгрөгийг зарцуулсан байна.

Алба хаагчдыг нөхөн сэргээх сувилалд хөнгөлөлттэй буюу төлбөргүйгээр эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байдлыг харгалзан “Сүүж-Уул” сэргээн засах амралт сувилалд амраах 42 алба хаагчийн судалгааг гарган өнөөдрийн байдлаар тус цагдаагийн газраас 32 алба хаагч, гэр бүлийн 1 гишүүний хамт хамруулж, сувиллын зардалд хөнгөлөлт үзүүлэн 3.168.000 төгрөгийн зардлыг шийдвэрлэж өгөв.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус Цагдаагийн газрын баталсан орон тооны бус “Эрүүл мэнд, сэтгэл зүйн баг”-аас алба хаагчдын эрүүл мэнд, дархлааг сайжруулах зорилгоор хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс “Витаминжуулалт” аяныг эхлүүлж, аяны хүрээнд “Асралт үйлс” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран дархлаа дэмжих витамин С, D аньс, чацарганы витаминь тарааж, стресс бухимдлыг саармагжуулах, ядаргаа тайлах амин дэмүүдийн талаар сургалт зохион байгууллаа.

Цагдаагийн газрын хэмжээнд 2022-2023 онд орон нутгийн “Хаан даатгал”-д 1 жилийн хугацаатай алба хаагчдыг “Хөдөлмөрийн чадвар түр алдалт”-ын гэнэтийн ослын даатгалд 186 алба хаагч, тээврийн хэрэгслийн даатгалд 20 автомашин, 28 мотоцикл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд 20 алба хаагчдыг тус тус хамруулах судалгааг гарган ЦЕГ-ын СААА-нд хүргүүлж, хамруулах ажлыг зохион байгууллаа. Гэнэтийн ослын даатгалын буцаан олголтыг амралтын өдөр харгалзахгүйгээр тооцон олгогдох давуу нөхцөлтэйгөөр гэрээ байгууллаа. Алба хаагчдын нийгмийн баталгаа хангах чиглэлээр хуулиар олгогдсон газраа өмчлөөгүй байсан 63 алба хаагчдад олгох Хэрлэн сумын Засаг даргын захирамж гаргуулж, хөнгөлөлттэй орон сууцны зээлд 3 алба хаагч хамрагдлаа.

Цагдаагийн газрын гэнэтийн ослын даатгалд 200 алба хаагч, тээврийн хэрэгслийн даатгалд 21 автомашин, 14 мотоцикл, үл хөдлөх хөрөнгийн даатгалд 1, 2 дугаар конторын барилгыг хамруулах судалгааг гарган Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүргүүлэн 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл Алба хаагчдын гэнэтийн ослын даатгалын гэрээг “Номин даатгал”ХХК, үл хөдлөх хөрөнгийн даатгалыг “Хаан даатгал”ХХК, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг “Практикал даатгал”ХХК-тай тус тус байгуулан ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын Баян-Уул сумын Цагдаагийн тасгийн албаны УАЗ-Хантер маркийн автомашин албан үүрэг гүйцэтгэж яваад шатсан талаарх нөхөн төлбөрийн материалыг “Номин даатгал” ХХК-нд хүргүүлэн даатгалын нөхөн төлбөрт 40.8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулан УАЗ-Мега ХХК-тай гэрээ байгуулан Уаз-Хантер маркийн автомашиныг шинээр худалдан авч ашиглалтад оруулав.

Албан үүргээ гүйцэтгэж байгаад зам тээврийн осолд өртөж нас барсан 1, гэмтэж бэртсэн 4 алба хаагчийн гэнэтийн ослын нөхөн төлбөрийн материалыг бүрдүүлэн “Номин даатгал”ХХК -нд хүргүүлэн ажиллалаа.

ЗУРГАА: ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР**А. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн байдал**

Цагдаагийн нь 2022 онд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангах, хэрэгжүүлэх талаар хийсэн ажилд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам” /код 110/-ыг удирдлага болгон хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч хүргүүлэн ажиллав.

ЦЕГ-ын даргын А/38 дугаар тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалт”-ыг /291/ баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, тооцох баримт бичгийн үр дүн 2020 онд 98, 2021 онд 98.5 , 2022 онд 98.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь жил бүр өссөн үр дүнтэй байна.

Цагдаагийн газраас 2022 онд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/86 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах /код 112/ журам”-дийг баримтлан тасаг хэсгүүдийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн байдлаар учирч болох эрсдэл, хяналт шинжилгээ дүгнэлтийг хийж түүний үндсэн цагдаагийн газрын даргаар 25 заалт бүхий Дотоод хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж биелэлт үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн газрын удирдлага нь оны эхэнд “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг явуулах” /код 112/, Санхүүгийн дотоод хяналт шалгалт хийх журам /код 117/ Хууль зүйн сайдын 2015 оны а/238 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу тасаг, албад, алба хаагчдын ажлын алдаа, зөрчил дутагдлыг засаж арилгах, таслан зогсоох, ажлын хэвийн нөхцөлийг хангах, чанар үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын ажлын болон сахилга ёс зүйн дутагдлыг илрүүлэх, засуулах зорилгоор “Дотоодын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө” гарган алба хаагчдын ажлыг шалган зааварчлах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн алба хаагчдаас 2021 онд хэрэг бүртгэлтийн дугаар авч шалгаж шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг тоолох, шийдвэрлэлтийн үндэслэлийг шалгаж тогтоох ажлын хэсгийг Эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар, Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад шалгагдаж байгаа эрүүгийн хэргийн эд мөрийн баримтыг хадгалах зориулалтай “Эд мөрийн баримт”-ын өрөөнд байгаа эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгах ажлын хэсгийг Шуурхай удирдлагын тасгийн даргаар, Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн үнэт цаасны орлого, зарцуулалт, баримтын бүрдлийг шалгах болон, галт зэвсгийн гэрчилгээжүүлэлтийн байдлыг шалгах ажлын хэсгийг эдийн засгийн ахлах мөрдөгчөөр, 2022 оны эхний улиралд шалгаж шийдвэрлэсэн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн шийдвэрлэлтийн байдлыг Мөрдөн байцаах тасгийн даргаар, Дотоод аюулгүй байдлыг шалгах ажлын хэсгийг Дэд даргаар ахлуулсан ажлын хэсгүүдийг тус тус байгуулан шалгалтын дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн хугацаатай үүрэг даалгавар өгч илэрсэн зөрчил дутагдлыг засуулан ажиллалаа.

Б. Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээ:

Цагдаагийн газрын удирдлага нь оны эхэнд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг явуулах” /код 112/, Санхүүгийн дотоод хяналт шалгалт хийх журам /код 117/, Хууль зүйн сайдын 2015 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2022 оны 02 сарын 25-ны өдөр баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Дотоод аюулгүй байдлыг хангах талаар 2022 онд хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн, Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/21 тоот тушаалаар Цагдаагийн газрын Дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, орон тооны бус ажлын хэсгээс 2022 онд 7 хэсэг бүхий 45 төрлийн ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаа. Орон тооны бус ажлын хэсгээс 2022 онд 4 удаагийн хурлыг зохион байгуулж ажиллав.

Орон тооны бус ажлын хэсгээс цагдаагийн газрын алба хаагчдын албаны нууц хадгалалт, хамгаалалтыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаарх шалгалтын удирдамж, төлөвлөгөөг гаргаж конторын алба хаагч болон орон нутагт үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарт 5 заалт бүхий зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код-113/ “Дотоод аюулгүй байдлыг хангах” журмын хүрээнд Цагдаагийн газрын хэмжээнд “Санхүүгийн, Мэдээллийн, Галт зэвсгийн, Барилга байгууламжийн, Алба хаагчийн, Улсын онц чухал объектын аюулгүй байдал”-ыг тасгийн дарга нараар 2022 оны 6 дугаар сарын эхэнд шалгуулан Газрын даргын зөвлөлийн хурлаар шалгасан дүнг хэлэлцэж, шалгалт явуулсан алба хаагчдад шалгалтын мөрөөр тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг, ажлын чиглэл, зааварчилгыг хариуцсан тасаг албад, албан тушаалтанд хүргүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх ажил, санал, зардлын тооцоог гарган ажиллав.

Орон тооны бус ажлын хэсгээс цагдаагийн газрын алба хаагчдын албаны нууц хадгалалт, хамгаалалтыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар 4 удаа, алба хаагчдын гар утасны ашиглалтын байдалд 1 удаа шалгалт явуулж, алба хаагчдад аюулгүй байдлын чиглэлээр үүрэг, ажлын чиглэл 2, зааварчилга 1, зөвлөмж 4 боловсруулан хүргүүлж ажиллалаа. Байгууллагын дотоод аюулгүй байдлын тайланг 98.6 хувьтай дүгнэж, тайланг ЦЕГ-ын Дотоод хяналт аюулгүй байдлын газарт хүргүүлэн ажиллалаа.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан 5 зорилт, 63 заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх журам”-ын /код 108/ дагуу 5 бүлэг 63 зорилт бүхий цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

- 2022 онд аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах ажлын хүрээнд Матад, Булган, Гурванзагал, Баяндун сумын цагдаагийн тасаг, хэсгийн алба хэрэгцээнд нийт 4 автомашин худалдан авах 125,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа цуцалж төсвийн тодотголоор санхүүжилтийг татсан, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/-ны засварт 41,2 сая төгрөг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт тендерийг зарлаж Дорнын их өглөг ХХК-тай гэрээ байгуулан Цагаан-Овоо сумын Цагдаагийн хэсгийн байрыг засварлуулан хүлээн авсан Сэргэлэн сумын хэсгийн байрыг засварлаж тохижуулав.

-Хууль зүй дотоод хэсгийн яамнаас балансаас баланст шилжүүлсэн Ланд-200 маркийн автомашиныг шилжүүлэх тогтоолыг гаргуулан данс бүртгэлд 167.7 сая төгрөгөөр

бүртгэн авсан. Мөн Чойбалсан хотын Засаг даргын тамгын газраас согтуурал тандагч драйгер 20 ширхэг 27.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлэв.

Номин даатгалаас автомашины даатгалын нөхөн төлбөрт 40.8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулан УАЗ-Мега ХХК-тай гэрээ байгуулан Уаз-Хантер маркийн автомашиныг шинээр худалдан авч ашиглалтад орууллаа.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд “Намар эрүүл цагдаа-гэр бүл” өдөрлөгийн үйл ажиллагааг “Баянтүмэн натурал виллаж” амралтын бааз дээр зохион явуулж ажиллалаа.

Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ны үйл ажиллагааг “Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл” НҮТББ-ын тэргүүн Г.Адилбиш болон нэр бүхий нутгийн иргэд хамтран 5 шаардлага тавьж эсэргүүцэж газрын тосны тээвэрлэлт явуулдаг төв замд жагсаал зохион байгуулагдах үед тус тасгийн алба хаагчид хэв журам сахиулах хамгаалалтын үүргийг гүйцэтгэн ажилласан.

Удирдлагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд энэ онд эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон алба хаагч байхгүй ба энэ онд нийт 8 сахилга, ёс зүйн зөрчил бүртгэгдэн, 8 алба хаагч сахилгын арга хэмжээ тооцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн тоо 2 нэгжээр буюу 20 хувиар өсөж, арга хэмжээ авагдсан алба хаагчийн тоо 10 буюу 20 хувиар тус тус буурсан байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 87.5 хувийг офицер, 12.5 хувийг ахлагч бүрэлдэхүүнээс гаргасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчийн тоог нийт бие бүрэлдэхүүний тоотой харьцуулахад 4.7 хувийг эзэлж байна.

Цагдаагийн байгууллагад иргэд, хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 4547 гомдол мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 354 буюу 8.4 хувиар өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллийн 1518 буюу 33.3 хувийг гэмт хэргийн шинжтэй, 3029 буюу 66.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сард 467 холбогдогчтой, 2.548.2 төгрөгийн хохиролтой, 600 гэмт хэрэг бүртгэгдэж, 94 хэргээр буюу 18.5 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 53.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 245 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 2 буюу 10 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 26 буюу 11.8 хувиар буурсан байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 530.7 төгрөг буюу 28.7 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 197 бүртгэгдэж 7 буюу 3.6 хувь, Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 68 бүртгэгдэж 5 буюу 7.9 хувь, Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 41 бүртгэгдэж 20 буюу 95.2 хувь, Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 32 бүртгэгдэж 5 буюу 18.5 хувь, Хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 50 бүртгэгдэж 14 буюу 38.8 хувь, Бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 47 бүртгэгдэж 2 буюу 4.4 хувь, Бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 150 бүртгэгдэж 61 буюу 68.5 хувиар тус тус өссөн. Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдэж 8 буюу 34.7 хувиар буурсан байна.

Хүнийг алах 8 бүртгэгдэж 2 буюу 33.3 хувь, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж буюу 100 хувь, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 225 бүртгэгдэж 27 буюу 13.6 хувь, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 2 нэгжээр буюу 2 дахин, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 1 дахин, Хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдэж 43 буюу 61.4 хувь, Залилах гэмт хэрэг 68 бүртгэгдэж 18 буюу 36 хувь, Хөрөнгө завших гэмт хэрэг 20 бүртгэгдэж 6 буюу 42.8 хувь, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 буюу 25 хувь, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 3 буюу 3 дахин, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин, Бусад төрлийн гэмт хэрэг 24 бүртгэгдэж 12 буюу 100 хувиар тус тус өсөж, Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 15 бүртгэгдэж 2 буюу 11.7 хувь, Хүчиндэх гэмт хэрэг 12 бүртгэгдэж 2 буюу 14.2 хувь, Гээгдэл эд зүйл, алдуул мал

завших гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3 буюу 33.3 хувь, Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах 1 бүртгэгдэж 100 хувь, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувь, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 буюу 50 хувь, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин, Хууль бусаар ан агнах гэмт хэрэг 1 дахин, Хууль бусаар мод бэлтгэх 7 бүртгэгдэж 6 буюу 53.8, Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 21 бүртгэгдэж 4 буюу 16 хувиар тус тус буурч, Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг 2, Халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 6, Дээрэмдэх гэмт хэрэг 4 ижил түвшинд байна. Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг, Эрүүл мэндийн эсрэг, Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, Үндэсний аюулгүй байдлын эсрэг, Авлигын эсрэг, Соёлын өвийн эсрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна. Хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 буюу 61.4 хувь өсөж үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 97 бүртгэгдэж 37 буюу 61.6 хувь өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 49 бүртгэгдэж 1 буюу 2 хувиар буурсан байна.

НАЙМ. ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ

1. Цагдаагийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлж, алба хаагчдын хууль эрхийн мэдлэг, сахилга, дэг журмыг сайжруулахад онцгой анхаарч, албадын дарга, ахлахуудын манлайлал, хариуцлагыг дээшлүүлэх.
2. Алба хаагчдын дунд зохиох сургалт, соён гэгээрүүлэх ажлын арга барил, хэлбэрийг боловсронгуй болгож, чанар, үр дүнг дээшлүүлэх.
3. Хуульч шуурхай ажиллагааг хангаж, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх.
4. Алба хаагчдын хувийн болон ажил үүргийн гүйцэтгэлд анхаарч, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй, авлигад өртөхгүй хамт олон байж улс, аймгийн тэргүүний байгууллага болох.
5. Өссөн гэмт хэргийн үзүүлэлтүүдийг бууруулах чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулах.
6. Прокурорын шаардлагын хувийг бууруулах, алба хаагч бүр зөрчил дутагдалгүй ажиллах, алдаан дээрээсээ суралцах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ТАЙЛАН БИЧСЭН:
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ